

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY



“Ус уул уурхайгаас илүү ашиг
өгөх учиртай”

Саарал усны ашиг

Азийн залуус ба боломж

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2012. 01 сар. №001 (011)

www.mongolianeconomy.mn

Ангамал дэлхийн цангамал Монгол болох гэж үү



Naran Motors Co., Ltd
www.bmw.mn



PRINCIPLES OF LEADERSHIP.

BMW 7 Series. Inspired by the core principles that take leaders from success to success.

БАЙГАЛИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ШИЛДЭГ СТАНДАРТ

Аливаа уул уурхайн үйл ажиллагааны дараах нөхөн сэргээлт нь тухайн газар нутгийг байгалийн унаган төрхөнд нь буцаан оруулж, сэргээх явдал юм. Энэ стандартыг манай компани нөхөн сэргээлтийн үйл ажиллагаандаа байнга мөрдлөг болгодог. Үүний нэг тод жишээ бол Булган аймгийн Сайхан сумын нутаг дахь Эрээний уурхай байсан газар юм.

Өнөөдөр нөхөн сэргээлтийн дараа энэ газрын өвс ургамал нь зэргэлдээ бэлчээрийн газраас даруй 4 дахин илүү гарцтай байна.

Бид байгаль хамгааллын энэхүү стандартыг дэлхийн өнцөг булан бүрт явуулж буй үйл ажиллагаандаа нэвтрүүлдэг. Бидний энэ арга барилыг, тухайлбал Эрээний уурхайд хэрэгжүүлсэн нөхөн сэргээлтийн ажлыг Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон холбогдох бусад байгууллагууд өндрөөр үнэлж байна.

АНУ-д төвтэй Пийбоди Энержи компани нь дэлхийн хамгийн том хувийн хэвшлийн нүүрсний компани юм.

Бид аюулгүй ажиллагаа, байгаль хамгаалал болон нийгмийн хариуцлагын чиглэлээр өнгөрсөн 5 жилийн хугацаанд 150 гаруй шагнал, өргөмжлөлийг хүртсэн. Саяхан Mongolia Mining Journal Awards 2011-ын Шилдэг Эко уурхайгаар мөн шалгарсан билээ.



Нөхөн сэргээлтийн дараа



Leonardo DiCaprio
and his New Link.



HISTORY BEGINS EVERY MORNING



TAGHeuer

SWISS AVANT-GARDE SINCE 1860

Swiss Watch Shop

Наран Пойнт, Хувьсгалчдын гудамж #9 Утас: 326435
Наран Молл, 2-р давхар, Сөүлийн гудамж Утас: 328841

www.mongolianeconomy.mn

 **MONGOLIAN
ECONOMY**

Үүсгэн байгуулагч,
Эрхлэгч: Д.Бэхбаяр
9999 4248

Үүсгэн байгуулагч,
Орлогч Эрхлэгч:
И.Отгонжаргал
8800 6228

Англи хэлний редактор:
Terrence Edwards

Сэтгүүлч:
Х.Хулан
Э.Зоригт
Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Б.Ууганбаяр

Орчуулагч:
Э.Өлзийлхам
С.Жавхлан

Дизайнер:
Ш.Оюундарь

Маркетингийн менежер:
Д.Бариянжав
8880 0825
Б.Энхцэцэг
9901 5476

Хаяг:
Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23
Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар,
Төв шуудан, ш/ х-2762

Утас/Факс: 976 - 7011 5476

www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

“Улаанбаатар принт”
ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

Борлуулах цэгүүд:

"Интер ном"
"Цэцэг төв"
"Зиг заг" автосервис
"Минж плаза"
"Алтангүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

Эрхлэгчийн зурвас



Эрхлэгчийн зурвас
Ногоон эдийн засаг,
тогтвортой хөгжил, ертөнцийн
хүн амьтан, байгаль дэлхийн
амин булаг болсон устай
холбоотой асуудлуудыг
дэлгэн тавьсан шинэ оны
эхний дугаараараа уншигч,
захиалагчидтайгаа учран
золгож байгаадаа баяртай
байна.

Анх гарч эхэлсэн цагаасаа
хойш бүтэн нэг жилийн
хугацаанд сар бүр таны гар

очдог байсан “Mongolian Economy” сэтгүүл маань
шинэ оны эхний сараас эхлэн танд 14 хоног тутамд
хүрэх болсон таатай мэдээг дахин тэмдэглэе.

Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн мэдээ
мэдээлэл, мэдлэг өгсөн нийтлэл, ярилцлага,
мэргэжлийн эдийн засагч, шинжээчдийн манай
сэтгүүлээр дамжуулан танд хүргэх үг хэл, үзэл бодол
цаг хугацааг товчлох шаардлага байгаа учраас бид
ийнхүү сэтгүүлээ сард хоёр гаргахаар боллоо. Бидний
эдийн засагт чиглэсэн дуу хоолой зөвхөн сэтгүүлээр
хязгаарлагдахгүй болсныг энд бас онцлон хэлэх
хэрэгтэй болов уу. Нэг үгээр хэлбэл, 14 хоног тутамд
гарч байгаа сэтгүүлийн хуудаснаа буусан эдийн засаг,
санхүү, бизнесийн мэдээ мэдээллийн хурд өнөөгийн
үсрэнгүй хөгжил, эдийн засгийн их өсөлтийн ритмд
гологдох учраас манай “Mongolian Economy” сэтгүүл
саяхнаас

www.mongolianeconomy.mn, цахим хуудас, “Econ-
omy” телевизийн студиер хурд, хүчээ нэмсэн гэдгийг
дуулгахад таатай байна. Ингэснээрээ эдийн засгийн
холбогдолтой цаг үеийн мэдээ мэдээлэл манай
монгол-англи хэл дээрх цахим хуудаснаа цаг алдалгүй
мэдээлэгдэж, эдийн засаг, санхүү, бизнесийн шинэ
соргог, содон сонирхолтой нэвтрүүлэг, ярилцлага,
сурвалжлагууд телевизийн студид бэлтгэгдэн, цэнхэр
дэлгэцээр танд хүрч байх юм.

Эдийн засгийн мэдээ мэдээлэл гэхээсээ илүүтэй
улс хөгжин дэвжихийн хэрээр иргэдэд эдийн засгийн
боловсрол мэдлэгээ дээшлүүлэх шаардлага тулгарч
байгаа тул манайх ийнхүү хүрээгээ өргөжүүлэн тэлж
буй билээ.

Орлогч эрхлэгч И.Отгонжаргал

3.Батбаяр: Ус уул уурхайгаас илүү ашиг өгөх учиртай

Алтан тэвшийн хөндийгөөс гарч буй ус чанарын хувьд үнэхээр сайн. Ийм усаар л бид хоолоо хийж, шалаа угааж, “ОО”-доо татаж байна байна шүү дээ.....11



Хаагаарай



Идэр насны хүдэр эр, гурван есийн хүйтнийг үл хайхран энгэр заам нь зайдгай байх агаад “Хаагаарай” хэмээн хашгирна....14

Дотоодын нийт аз жаргал



Бутан улс байгаль хамгааллын асуудлаа аз жаргалын дөрвөн тулгуурт баганын нэгт тооцдог...21

Ногоон эдийн засаг

- 8 Ногоон өсөлт Монголын ирээдүй
- 9 Ангамал дэлхийн цангамал Монгол болох гэж үү
- 11 3.Батбаяр: Ус уул уурхайгаас илүү ашиг өгөх учиртай
- 14 Хаагаарай
- 16 Үнэ цэнэтэй “Хөх сувд”
- 17 Саарал усны ашиг
- 19 “Усны алтан үе” дууссан
- 21 Дотоодын нийт аз жаргал
- 23 Тогтвортой хөгжил өөд 20 жил хамтдаа
- 24 Уурхайн цогц нөхөн сэргээлт: Эрээнний уурхай ногоон бүс
- 26 Монголд сэргээгдэх эрчим хүчний төсөл хэрэгжүүлэх сонирхолтой байна


Эдийн засаг

- 30 Төмөртэй хүн баяждаг
- 33 Амьдралын Америк зам хөгжлийн цорын ганц зөв зам мөн үү
- 34 Азийн залуус ба боломж
- 36 Эдийн засгийн тулгын гурван чулууг ивлээ

Бизнес

- 38 Ногоон амьдрал бэлэглээ
- 41 “Хэрвээ ингэвэл яах вэ” гэдэг асуултад хариулж чаддаг бол
- 43 Чимээгүй тахалтай өдөр бүр тэмц
- 45 Ногоон аж ахуйн нэгж-амжилтын үндэс
- 46 Та ямар Ногоон ном уншихыг зөвлөх вэ? Яагаад?

Эдийн засгийн тулгын гурван чулууг ивлээ



Тогтсон уламжлалаараа манай хамт олон сүүн хундагаа өргөж, шинэхэн вэб сайт, ТВ студия хүлээн авлаа...36

Ногоон амьдрал бэлэглээ



Манай сэтгүүл энэ удаагийн “Амьдрал” буландаа ногоон хөгжилд хувь нэмрээ оруулж олонд үнэлэгдсэн хүмүүсийн тухай бичиж байна....38

Чимээгүй тахалтай өдөр бүр тэмц



ДЭМБ-ын статистикийн мэдээнээс үзэхэд чихрийн шижин өвчний тархалт 15 жил тутамд хоёр дахин нэмэгдсэн байна....43



Онцлох сэдэв

Ногоон өсөлт Монголын ирээдүй

И.Отгонжаргал

Дэлхийн хөгжлийг тодорхойлохоор довтлон буй ногоон эдийн засаг, тогтвортой хөгжлийн талаар мэдье, үзье, судлая гэвэл Та манай “Mongolian Economy” сэтгүүлийг сонирхон уншаарай. Ногоон эдийн засгийн хөгжилд хамааралтай олон асуудал, олон сэдэв бий. Бид эдгээрийг сэтгүүлдээ байнга хөндөх учиртай. Мөн түүнчлэн “Ногоон эдийн засгийн өсөлт” төрийн бус байгууллагын маань үйл ажиллагаа ч энэ чиглэлд байх юм. Тиймээс шинэ оны эхний дугаарынхаа онцлох сэдвийг ногоон хөгжилд тэр дундаа хүн төрөлхтний амин булаг болсон устай холбоотой бахархам сайхан басхүү бачуурмаар таагүй асуудлуудыг хөндсөн нийтлэл, сурвалжлага түлхүү бэлтгэн хүргэж байна. Ерөнхийдөө дэлхийн сэтгэл зүрхийг шаналгасан усны асуудалд голчлон анхаарлаа.

Бөөрөнхий дэлхийн нэг хэсэгт нь хүмүүс хоолой чийглэх усгүй алтан амиа алдаж, нөгөө хэсэгт нь харангадахгүйн тулд бүх л амьдралаа балга усанд

дугаарлаж өнгөрөөж буй нь ч бий. Харин Чингисийн Монголд байгаль эх далай ээжийг харамгүй заяалгажээ. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс болж ангамал дэлхийн амьдрал улам бүр дордож буй өнөө үед хөх сувдаар хүрээлэгдсэн монголчууд их хувь заяандаа олзуурхаад суух биш, одооноос чандмань эрдэнэ гэгддэг усаа хайрлан хамгаалж, гамнаж хэмнэх аргад суралцах шаардлага бидний өмнө тулгарч байна. Монголчуудад балга усанд дугаарлаж зогсох баргар амьдрал “айлчлахгүй” гэх газар үгүй. Тиймээс усны асуудалд бидэнд амны уншлага болсон “Маргааш” гэдэг үгийг хэрэглэх эрх байхгүй. Нэг үгээр хэлбэл, нөөц баялгаа хэмнэж, эдийн засгийн үр ашиг гаргах дэлхийн “ухаанд” суралцахгүй бол горьгүй нь. Ингэхийн тулд хамгийн гол нь хэмнэлт гэдэг үгийг хамгаас чухалчилж авч үзэх цаг болжээ. Сүүлийн жилүүдэд цөлжилт, уул уурхайн хөгжил хурдтай явагдаж байгаа учраас усны асуудалд анхаарлаа хандуулж, ариг гамтай хэрэглэх, эдийн засгийн эргэлтэд оруулах талаар түлхүү ярьж, тодорхой ажил хийж эхлэхгүй бол Монголд 15-хан жилийн дараа усны асуудал маш хүнд болохыг Дэлхийн банкнаас гаргасан судалгаа бэлхэнээ харуулж буй. Хүн төрөлхтний амин эрдэнэ болсон усаа хэмнэж гамнах талаар манай сэтгүүл нэг бус нийтлэл, сурвалжлага, ярилцлага нийтэллээ.

Мөн цаашид энэ чиглэлээр их зүйл хийгдэж онцгой үр дүн гараасай гэсэндээ оны эхэнд онцолж байгаа хэрэг. Зөвхөн Монголдоо буй асуудлыг биш, усны гачаалд орж зовж зүдэрч буй хүмүүс, мөн усыг хөгжлөө болгож чадсан улсын тухай ч сонирхолтой нийтлэл хүргэж байна. Харьцуулж жишиг сонирхох зургуудыг ч цөөнгүйг тавилаа. Уншигч Та яг энэ мөчөөс хувьдаа усаа хайрлаж, хэмнэх мэргэн ухаан сийлээрэй. Цэнхэр гаригаас Монгол орон ундаалах усаа ахиу авч чаджээ. Баримт дурдвал дэлхийн усны 97 хувь нь давстай, түүний ганцхан хувь нь л гүнийх байдаг бол Монголд газрын гүний цэвэр ус 30 хувийг эзэлж байх жишээтэй. Нэг хүнд ногдох усны нөөцөөрөө Монгол Улс дэлхийн 182 орноос 56 дугаар байрт жагсаж байгаа нь бахархууштай зүйл юм. Түүнчлэн дэлхийд цэвэр цэнгэгээрээ гайхуулдаг Хөвсгөл далай Монголынх. Хөвсгөл далайд бөмбөрцгийн цэнгэг усны нэг хувь нь ногддог гээд устай холбоотой бахархмаар, хайрлахгүй байхын аргагүй сайн мэдээ олоон, Монголд.

Мөн ирэх зургадугаар сарын 20-22-нд Бразилийн Рио -Де-Жанейро хотноо зохион байгуулах НҮБ-ын “Тогтвортой хөгжил” сэдэвт дээд хэмжээний уулзалтыг угтаж, дэлхийн хэмжээний уг арга хэмжээг Монголтой уяхын тулд манай сэтгүүл өмнөх дугаараасаа эхлэн “Рио+20+Монгол” гэсэн байнгын булан нээж ажиллуулж байгаагаа тэмдэглэхэд таатай байна. ■

Асуудал

Ангамал дэлхийн цангамал Монгол болох гэж ү?

Б.Баяртогтох

Үнийн өсөлт монголчуудыг хүссэн хүсээгүй хэмнэлтийн горимд шилжихэд хүргэж байгаатай адил усандаа ч ийм харамын сэтгэлээр хандах цаг хэдийнэ болжээ.

Улаанбаатарчууд ундны усны гачаалд орж үзээгүй. Харин шатахууны хомсдолд бол байн байн орж байсан. Өнөөдрийн байдлаар нэг литр усанд гэр хорооллын айл нэг төгрөг, орон сууцны өрх 25 мөнгө төлж байна. Зах зээлийн нийгэмд 25 мөнгө, нэг төгрөгөөр уснаас өөр юу худалдан авч болох вэ. Ганц ширхэг чихэр, нэг ширхэг бохь ч худалдан авч чадахгүй. Тэгэхээр монголчууд шиг ийм хямд үнээр чандмань эрдэнэ болсон усаа хэрэглэдэг орон дэлхийд бий болов уу. Мэдээж байхгүй. Тэгвэл дэлхийн улс орнуудад усны үнэ сүүлийн таван жилд л гэхэд АНУ-д 27, Анлид 32, Австралид 45, Канадад 58 хувиар тус тус өссөн байна. Хэдий Америк, Английнх шиг өндөр цалин, амьдрах таатай орчин Монголд үгүй ч усны үнийг нэмэх шаардлага бий. Мэдээж хүн бүр үүнийг талархаж хүлээж авахгүй нь ойлгомжтой. Гэхдээ усны үнийг өсгөх асуудал дээр иргэдээс эмээх хэрэггүй гэж төр, засгийн шийдвэр гаргаж, бодлого тодорхойлогчдод зөвлөмөөр байна.

Учир нь, үнэгүй юм үнэгүй л байдаг. Хэрвээ манайх ангамал дэлхийн цангамал Монгол болох гээгүй л юм бол усны үнийг нэмж байж үнэ цэнийг нь ойлгуулах хэрэгтэй болов уу. Тэгж шийдэмгий хөдөлж байж Монгол Улсын цэвэрцэнгэгуснызамбараагүйхэрэглээг хязгаарлаж, хэмнэж гамнах ухаанд сургаж, эдийн засгийн үр ашиг, урагштай хөгжлийг харах учиртай. Усыг манайхан чандмань эрдэнэ гэж сайхан нэрлэдэг ч чихэнд сонголонтой сайхан үгээр илэрхийлэгдэх бүтээгдэхүүнийхээ үнэ цэнийг мэддэггүй.

Өнөөдөр Монгол Улс нэг хүнд ногдох усны нөөцөөрөө дэлхийд 56 дугаарт орж байна. Дэлхийн 14 улсад хийсэн судалгаанаас үзэхэд нэг шоо метр усны дундаж үнэ Хятадад 48 цент, АНУ-д 66 цент, Дани, Герман улсад 2.25 ам.долларын хооронд хэлбэлзэж

байна. Эдгээр улстай харьцуулахад манай улсын усны үнэ 15-100 дахин хямд байгаагаас гадна усныхаа 50 шахам хувийг төлбөрөөс чөлөөлж үнэгүй ашиглуулна. Харин усны асуудлын тухайд үнэ цэнийг нь ойлгох, хайрлаж гамнах, сэтгэл зүрх л бидэнд дутаж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2011 оныг “Усныжил” хэмээн зарласан боловч авах арга хэмжээ, асуудлууд цаасан дээр л мяралзан жирэлзэн урссан байх. Туул голд хивсээ угааж, машинаа зүлгэх хүмүүсийн тоо цөөрсөн болов уу. Арьс ширний үйлдвэрлэлд ашигладаг хром хэмээх химийн элементийг төв цэвэрлэх байгууламж нь цэвэршүүлж дийлэхгүй шууд л Туул гол руу нийлүүлж буй. Гэтэл хромыг үйлдвэрлэгч арьс ширний үйлдвэрийнхэнтэй ямар арга хэмжээ авч, хэдийнх нь үйл ажиллагааг хаагаа бол гээд бодохоор санаанд торох зүйл байхгүй л байна. Есөн жилийн дараа дуусах “Ус” үндэсний хөтөлбөрт хөрөнгө мөнгө хайж давхисаар байтал Улаанбаатар усны нөөцөө шавхах уу. 2010 оны хавар батлагдсан тус хөтөлбөрийн үр дүн хэзээ нүдэнд харагдаж, гарт баригдах бол оо.

Цаасан дээр буусан усны төлөөх

үйл ажиллагаа, чиг зорилтууд чимх ч болтугай ажил болж мэндлээсэй. Улсын хэмжээнд 551 гол, 483 нуур ширгэсэн гэх мэдээг “Усны жил”-ийн адагт БОАЖЯ-наас танилцууллаа. Эдгээр тоог сонссон хэний сэтгэл хамгийн түрүүнд түгшсэн бол. Ийм үр дүнтэй, ийм сүржин онцлох жил байлаа гээд хэнд ашигтай байв. Хэн нэр төр олов.

“Усны жил”-д 140 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Үүний дүнд хаа нэгтээх голын ширгэх дөхсөн усны түвшин нэмэгдэж, бохирдол буурч чадсан гэвэл хэн ч үнэмшихгүй байх. Харин усны талаарх та бидний оюун санааг гэгээрүүлэх гэж зурагтай ном, хэвлэмэл хуудас тараахад чамгүй хөрөнгө зарсан нь үнэн. Зөвхөн өөрийнхөө төлөө усны ай сав, голын гольдролыг өөрчилсөн эрх мэдэл бүхий компанийн эзэдтэй хариуцлага тооцсон уу гэвэл бас л худлаа хэмээн Иргэний хөдөлгөөнийхөн мэдэгдсэн удаатай. Үүнийг салбарынхан нь үгүйсгэж байгаа. БОАЖ-ын сайд Л.Гансүх “Усны нөөц хамгаалах, үр ашигтай ашиглах, эрүүл ахуй, усны эх үүсвэрийг хамгаалах зэрэг төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн” хэмээн онцлов.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 58 ▶



▶ дугаар чуулганаас “Ус-амьдралын эх булаг” хэмээн уриалсан. Ус олон улсын сэдэв, ус өөрөө онцгой геополитик болжээ. Харин манайд уул уурхай, дараа нь улс төр, их өсөлтийн тухай оньсого таалцаж суугааг дэлхий хараад гайхаж буй биз ээ.

“Усны жил”-д ус булингартаж, гол горхи чимээгүй нүд аниж байгаа нь өнөөдрийн төрх, маргаашийн гачигдал. БОАЖЯ-ны мэдээллээс үзэхэд улсын хэмжээнд ажиллаж байгаа 18 мянга гаруй үйлдвэр аж ахуйн газрууд 526 тонн химийн хаягдал гаргаж байгаа нь экологи, усан орчинд ямар нөлөө үзүүлэх нь тодорхой. Эрүүл монгол хүн дөрвөн уулын дундаас төрөх үү. Ус, утаа, уур бухимдал...

Үндэсний статистикийн хорооноос мэдээлснээр 36,8 сая толгой малтай монголчуудын өрхийн төсөвт ус ямар үнэ цэнэтэй вэ. Улс орон оршин тогтнох, Улаанбаатар нүүх, суух нь устай шууд холбоотой атал бид хэдий болтол усанд тун тоомжиргүй хандах вэ. Манай улсын ДНБ-ий дөнгөж 0.25 хувийг усны салбарт зарцуулж байна. Монгол Улсад

гамшгийн хэмжээнд хүрээд буй хоёр “У” бий. Үүнийг задалбал Утаа, Ус гэдэгтэй олон хүн санал нийлэх байх.

Төв Азийн гадагш урсацгүй ай савын урсац 2040 хүртэл нэмэгдэх бөгөөд цаашдаа буурах төлөвтэй байгааг Английн “Хэдлэй” төвийн уур амьсгалын ирээдүйн тоймд өгүүлсэн байна. Энэ нь мөнх цаст, мөсөн голууд дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн хайлж, алсдаа гол горхи, нуур тэжээлгүй болно гэсэн үг. Агаарын температурын өөрчлөлттэй уялдан Цамбагарав уулын мөстлийн хайлалт 2040-2069 оны үед 371 см-ээр нэмэгдэх төлөвтэй байна. Та хаа байсан 2040 он бэ гэж бодож магадгүй л дээ. Хэрэв Та одоо 40 настай бол 68 насны босгон дээр юу болох бол оо л гэж зүрх сэтгэлдээ ойр хүлээж ав. Орон байр, унах унаа, хадгаламжид мөнгө гээд танд үр хойчдоо өвлүүлэхээр амжуулж хойшоо хийсэн зүйл бишгүй л бий байх. Харин усны хадгаламж нээсэн үү?

Дөрвөн жил тутамд хийх усны тооллогын дүнгээр улсын хэмжээнд нуурын ус 3126, устайд тооцогдох 6095

гол тоологджээ. Энэ хэр бодитой тоо вэ. Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөний удирдах зөвлөлийн гишүүн Д.Энхтөр “Өнөөдөр нэг тэрбум хүн цэвэр усны хомсдолтой байна” гэв. Тэрбээр нэгэн сонирхолтой баримт хэлсэн юм. “Хүн эхийн хэвлийд байхдаа биеийнх нь 99 хувь нь уснаас бүрддэг. Харин амьдралынхаа хугацаанд хүний биеийн усны хэмжээ 70 хувь болж багасдаг. 50 хувиас бага болохоор хорвоогоос хальдаг. Өнөөдөр бид усыг юу ч бишээр бодож байхад хүний бие дээр аваад үзэхэд нүдний 99, уушиг, зүрхний 80, булчин шөрмөсний 75, ясны 20, өөх тосны 10 хувь нь тус тус уснаас бүрддэг. Шүдний паалан хүртэл 0.2 хувийн устай байдаг” гэлээ. Ус амьдралыг тэтгэгч амин булаг гэдэг нь эндээс тодорхой харагдаж байна.

1960-аад оны замбараагүй мод бэлтгэл, 1970-аад оноос нуурын ай сав газар дахь зэгсийг сүйтгэсэн, 1980-аад оноос усалгаатай газар тариалангийн үе эхэлж, голыг салаалж усалгаатай тариалангийн хэмжээ нэмэгдсэн, 1990-ээд оноос “Алт” хөтөлбөр хяналтгүй хэрэгжсэн, мөн тооцоо судалгаагүйгээр баригдсан усан цахилгаан станц, шинэ мянганаас уул уурхайн компаниуд усыг бохирдуулж эхэлсэн зэрэг нь Монголын усны салбар уруудахад нөлөөлсөн гэж үзэж болох ажээ. Нэгэн зуунд монголчууд усанд хэт хайр гамгүй загнасан бол ангамал дэлхийн түүхээс сургамж аваад ирээдүйн хэрэглээгээ яагаад зөвөөр залж болохгүй гэж. Цэнхэр сувдаараа дэлхийд гайхуулах Монголын цэнгэг устай холбоотой хариулт нэхсэн асуулт хөвөрсөөр...

Монголд бэлчээр, ус ашигласан төлбөрөөс аль эрт мал, малчин хоёрыг чөлөөлсөн. Сүүлдээ бүр ноостой хонинд, ноосоо тушаасан малчинд мөнгө тараана. Гэтэл цаана нь хүн, малын ундаа болсон усны нөөц дундарч гол, горхи хатсан сайр, ангамал тал болон хувирахад маргааш төрөөс хайр зарласан мал, малчин хоёрынхоо хоолойг юугаар чийглэх болж байна вэ. Атар газар, усалгаатай тариаланг юугаар усалж, арвин ургац авах вэ?

Уул уурхайн компаниуд Орхон голыг улаанаар нь эргэтэл бохирдуулаад зогсохгүй, байгаль өөрөө өөрийгөө цэвэршүүлэх тэнхэлгүй болтол нь сөхрүүлж байна. Монголд алтны нинжаа очоогүй гол, горхи, хүнд техникийн мөр гараагүй уул хөндий цөөн болжээ. Гэтэл далайгаас хэдэн мянган бээр, эх газрын элгэнд буй монголчууд ус хэмээх амин эрдэнийг авран хамгаалах талаар хамтдаа сэтгэл зовох нь таны чин хүсэл ▶

Дэлхийн усны нөөц ба нөхөн сэргээлт

Усан мандал	Хэмжээ /10 ³ км ³ /	Нөхөн сэргээгдэх
Далай	1.388.000	2.500 жил
Гүний ус	23.400	1400 жил
Туйлын мөс	24.023.5	9700 жил
Уулын мөнх цас, мөс	40.6	1600 жил
Цэвдэгтэй газрын хөрсөн доорх мөс	300	10.000 жил
Нуур	176.4	17 жил
Намаг	11.5	5 жил
Хөрсний чийг	16.5	1 жил
Голын ус	2.12	16 хоног
Агаарын давхрага дахь ус	12.9	8 хоног
Биологийн ус	1.12	Хэдэн цаг

Усны тухай хууль тогтоомжууд

- 1995.3.30 Байгаль хамгаалах тухай хууль
- 1995.5.22 Ус рашаан ашигласаны төлбөрийн тухай хууль
- 1998.1.22 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай
- 1998.5.7 Ариун цэврийн тухай хууль
- 1999.5.28 Далай ашиглах тухай
- 2000.1.28 Байгалийн нөөц баялгийг ашигласаны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах арга хэмжээний тухай
- 2002.6.13 Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай
- 2002.11.7 Рашааны тухай
- 2003.1.28 Усан замын тээврийн тухай
- 2004.4.22 Усны тухай гэх мэт.

► зорилго буюу.

“Оюутолгой” компанийн зэс баяжуулах үйлдвэр хоногт 110 мянган тонн ус хэрэглэх тооцоо бий. Балгасын улаан нуурын ордоос 40176 тонн ус олборлоход 25 жил ашиглана. Өмнийн говь 25 жилийн дараа ямар байдалтай үлдэх бол. Газрын гүний усаа соруулсан говь нутагт хүн, мал тогтох уу. Дорноговь аймагт “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор барихад усны асуудал босож ирнэ. Усны үндэсний төвийн захирал Ж.Далай “Хэрлэн говь”, “Орхон говь” төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд “Хэрлэн говь” төслийн үр дүнд Чойр, Сайншандыг цэвэр усаар хангах, Замын-Үүдийн усны асуудлыг шийдэх боломжтой” гэсэн юм. Мөн Сайншандаас зүүн хойш орших Бор хөөврийн говьд усны хайгуул хийх төслийг боловсруулж байгаа юм байна. Говийн бүсийн бүтээн байгуулалт усны асар их хэрэгцээ дагуулах нь мэдээж. Уул уурхайг усаар хангахын тулд “худаг” гаргах уу.

Дэлхийн банкны судалгаагаар манай орны өмнөд бүсийн усны хэрэглээ ойрын жилүүдэд 350 мянган шоо метр болох аж. “Уул уурхайд өнөөдөр 95 сая шоо метр усны хэрэгцээ даруй 10-20 дахин нэмэгдэхээр байна” хэмээн Усны газрын үйлдвэр эрхэлсэн орлогч дарга Ц.Сосорбарам ярьсан юм. Уул уурхай бол усыг тонн тонноор ууна. Гэтэл өнгөрсөн 20 жилийн дотор уул уурхайн олборлолтын явцад 29 гол хэт бохирдсон хэмээн бүртгэгджээ. Тэд нэг литр гүний усанд 15 төгрөг, нэг шоо метр усанд 150 төгрөг л төлдөг байна. Гэтэл алт олборлоход нэг секундэд 500 литр ус хэрэглэдэг гэсэн тооцоо бий.

Дэлхийд хамгийн хямд үнээр гүний цэвэр ус хэрэглэж буй улаанбаатарчууд

хоногтоо л 160 мянган шоо метр ус зарцуулж байна. Хэмнэж, гамнах ухаанд эртнээс суралцсан бол бид Монголын ирээдүй болсон хойч үедээ хэчнээн литр ус хадгалж чадах байсан бол оо. Мөн бид нийтээрээ усны үнэ цэнийг мэдрэхэд ийм хойрго хандах байсан гэж үү. “Томоохон хот суурин газруудын нийт хүн амын 22 орчим хувь нь крант нээхэд л цэвэр ус гоожих усны аман дээр амьдарч байна” хэмээн Ус сувгийн удирдах газар/УСУГ/-ын дарга Б.Пүрэвжав хэллээ.

Цоргоноос гоожих усан дусал бүр мөнгөөр хэмжигдэж буй энэ үед усыг юман чинээ бодохгүй байгаа нь бидний зөв үйлдэл мөн үү. “Улаанбаатар хотын газрын гүний ус бохирдож, нөөц дундрахад зуслангийн айлууд томоохон үүрэгтэй оролцож байгаа” хэмээн Усны газрын орлогч дарга З.Батбаяр тайлбарласан билээ. Учир нь, айл бүр “ОО”-той, хашаандаа гүний худагтай байгаа нь Сэлбэ гол ширгэж, Дунд гол мөхөж, Улиастайн гол тасалдаж, Туул жилээс жилд дундрахад нөлөөлсөн гэв.

Манай өмнөд хөрш усны нөөцийг олохын тулд Гурван хавцлын усан сан гэсэн дэлхийд хамгийн томд тооцогдох цахилгаан станц барьж бөмбөрцгийг алмайруулсан. Хатан гол хэмээн нэрлэдэг Шар мөрний үерийн усыг хуримтлуулах замаар Хойд Хятадын усны асуудлыг шийдсэн тус станцын тухай манай сэтгүүлийн дөрөв дэх дугаарт “Гурван хавцлын гайхамшиг” гэсэн сонирхолтой нийтлэл гарсан билээ.

“Манайх цас мөс үерийн усаа ашиглаж чаддаггүй. Уг нь бол ийм усыг ашиглахын тулд бид инженерийн байгууламж барих шаардлагатай” хэмээн



Эх сурвалж: Усны газар

Ц.Сосорбарам дарга учирласан. Хэдий манай улс усны гачаалд өнөөдөртөө өртөөгүй ч маргааш ийм зовлон ойрхон байна. ■

Мэргэжлийн хүний үг

3.Батбаяр: Ус уул уурхайгаас илүү ашиг өгөх учиртай

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын орлогч дарга З.Батбаяртай ярилцлаа.

Ус эдийн засгийн шинж чанараа алдсан

-Дэлхий нийт усны асуудалд маш чухлаар хандаж байна. Харин манайд уул уурхай, улс төр л ярьж байна.

-Монголчууд тэр тусмаа улаанбаатарчууд хамгийн үнэ цэнэтэй усыг хэрэглээндээ зарцуулж байна. Өвөг дээдсийн хэлдэг дөрвөн уулын дундахь Алтан тэвшийн хөндийгөөс гарч буй ус чанарын хувьд үнэхээр сайн. Ийм

усаар л бид хоолоо хийж, шалаа угааж, “ОО”-доо татаж байна байна шүү дээ.

Газрын доорх ус бол бас нэгэн баялаг. Үүнд ямар нэгэн нэмэгдэл боловсруулалт ч хэрэггүй. Ерөнхийдөө усны хэрэглээний асуудал замбараагүй байгаа нь үнэн. Гэтэл эдийн засгийн хувьд хамгийн гол бүтээгдэхүүн ус. Усанд үнэлгээ тогтоогоогүй. Үүнээсээ болоод эдийн засгийн шинж чанараа алдсан.

-Та усыг үнэ төлбөргүй гэлээ. ►

► **Гэтэл хэрэглэсэн хэмжээгээрээ литр тутамд төлбөр төлж байгаа шүү дээ. Яагаад үнэгүй гэж?**

-Усанд өөрийнх нь үнэ байхгүй. Манайхан өнөөдөр нэг литр усыг нэг төгрөгөөр авч байна. Хувийн худаг гаргасан айлууд литр тутамд аравхан төгрөгийн төлбөр төлж байгаа. Гэтэл энэ чинь усны үнэ биш. Бид усанд төлбөр төлөөгүй. Өөрөөр хэлбэл, усны зардлыг төлөөд усаа үнэгүй хэрэглэж байгаа гэсэн үг. Энэ нь эргээд худагт ус хүргэж байгаа жолооч, тухайн худагт ажиллаж байгаа хүний цалин зэрэгт зарцуулагдах жишээтэй. Өнөөдөр манай гэр хорооллынхон нэг литр усанд нэг төгрөг төлж байгаа бол орон сууцанд амьдарч буй иргэд 25 мөнгө төлж байгаа юм.

-Усны үнийг тогтооход төрөөс ямар бодлого баримталж байна вэ?

-Уул уурхайн компаниуд нэг шоо метр усыг 150 төгрөгөөр худалдан авч байна. Харин үүнд жинхэнэ усны үнэ яваад байгаа юм. Усыг бид ингэж л үнэлж байна. Үнийг нэмэх боломжтой. Талхыг үнээр худалдаж авч иддэг хэрнээ ундаалах усаа огт үнэгүй хэрэглэнэ гэж байж болох уу. Үүнийг л манайхан ойлгох хэрэгтэй. Гэхдээ өнөөдрийн үнэлгээ хангалттай биш. Гэр хороолол болон орон сууцанд амьдарч байгаа иргэдийн усны хэрэглээний үнийг нэмэхээс илүүтэй усыг түгээхэд гаргаж буй зардлаа багасгахад анхаарах бодлого барьж байгаа. Ийм тохиолдолд усны үнэ одоогийнхоос буурах боломжтой. Харин уул уурхайн компаниудад ус ашиглалтын үнийг нэмэгдүүлэх ёстой. Одоогийн 150 төгрөгийг 4500 төгрөгт хүргэж болно. Мөн зайлшгүй нэмэх шаардлагатай төлбөрийн нэг нь ус бохирдуулсны төлбөр. Зарчим нь хэн хэдий чинээ усыг бохирдуулна тэр төдий чинээ төлбөр төлнө. Ус бохирдуулсны төлбөр бага гарах тусам бид баяртай байна. Яагаад гэвэл ус бохирдохоо больж байна гэсэн үг.

-Гэр хорооллынхон болоод орон сууцны иргэд усны төлбөрт бас л харилцан адилгүй үнэ төлж байна. Энэ нь дээр таны хэлсэн усны өөрийн зардалтай холбоотой байх. Манайд хэчнээн тооны худаг байдаг вэ?

-Орон сууцанд байгаа иргэнд усыг хүргэхэд зардал нь харьцангуй бага. Хоолойгоор дамжуулна. Насос ажиллана тэгээд л болоо. Харин гэр хороололд бол арай өөр. Манайд гурван янзын худаг бий. Цэвэр усны хоолой дээр барьсан худаг байгаа.



Энэ тохиолдолд зөвхөн хоолойныхоо крантыг нээх хаах л төдий үйлдэл хийнэ. Ийм худгийн усыг нэг төгрөгөөр өгч байгаа. Тиймээс ийм төрлийн худагны усны зардал болох үнийг бууруулах боломжтой. Жишээ нь, ийм худаг нийслэлд хаана байгаа вэ гэвэл Дөлгөөн нуурын зүүн талд байна. Хоёр дахь нь өрөмдөж гаргасан худгууд орно. Ийм худаг Улаанбаатарт харьцангуй цөөхөн. УСУГ-аас зуслангуудын амуудад энэ төрлийн худаг гаргасан. Гурав дахь нь усан сан буюу ус хадгалах савтай худгууд бий. Хотын хэмжээнд нийтдээ ийм 370 гаруй худаг байдаг.

Бид усны их боломжит зах зээлийн крант дээр сууж байна

-Ус бохирдуулж буй газартай хэрхэн хариуцлага тооцож байна вэ. Усны бохирдол хэзээ бүрэн арилах бол?

-Төлбөр төлөхгүйн тулд өөрсдөө байгальд ээлтэй, нэгдүгээр технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлэх шаардлагатай. Нэгдүгээрт, ус бохирдуулж буй газрууд өөрсдөө цэвэршүүлэх байгууламж барих хэрэгтэй. Ингээд цэвэршүүлэх байгууламжтай болоод ирэхээр ус бохирдуулсны төлбөрт санаа зовохгүй болно. Хоёрдугаарт, усаа цэвэршүүлсэн тохиолдолд эргүүлээд арьс ширний үйлдвэртээ ашиглана. Тэгвэл цэвэр усанд төлбөр төлөхгүйгээр эдийн засгийн хэмнэлттэйгээр үйлдвэрлэлээ явуулаад байх бүрэн бололцоотой. Түүнээс биш, Усны газрын бид нар ашиг олох гээд төлбөр авах гээд

байгаа юм биш ээ.

-Энэ хэрээр усны хэмнэлт, эдийн засгийн зардал буурах нь мэдээж. Гэтэл Туул голын усны түвшин харсаар байтал багассаар байна шүү дээ.

-Ус бохирдох бүрт нөөц дундарч байдаг. Мөн замбараагүй хэрэглээнээс болоод Туул голын өнөөгийн байдал дэндүү эмгэнэлтэй, эмзэг байдалд хүрлээ. Туул гол бохирдоод загасихээр үхлээ гэхэд хэн хариуцлага хүлээх вэ. БОАЖ-ын Сайд огцрох уу. Хотын дарга огцрох уу, эсвэл Усны газар ажлаа өгөх ёстой юу. Хариуцлагын асуудал ойлгомжтой байх ёстой. Улаанбаатар хотод бий болж буй бохирдол Туул голд үзүүлсэн нөлөөлөл нь Төв аймгийн Алтанбулаг, Өндөрширээт суманд илэрч байна. Тухайлбал, Алтанбулаг сумынхан Улаанбаатар хотын иргэдээс бид ус бохирдуулсны нөхөн төлбөр авах ёстой гэсэн санал тавьж байгаа. Учир нь, Туул голоос хүн байтугай мал ундаалахад бэрх болсон талаар хэлж байна билээ. Бохирдлын хувьд шүү дээ. Байдал ийм л байна

-Туул голоос гадна Сэрүүн Сэлбийн гол сэтгэл өвтгөсөн хэвээр байна. Магадгүй усны замбараагүй хэрэглээний үр дагавар гэж үзэж болох уу?

-Сэлбэ голын хувьд борооны усаар 60 хувь тэжээгддэг боловч сүүлийн жилүүдэд үндсэн тэжээл нь багассан. Модыг нь огтолсон. Усны эх хэсгээр ахуйн зориулалттай гүний худаг хэт олныг гаргасан. Сүүлийн үед зуслангийн айл бүр хашаандаа худаг гаргаж байгаа байдал нь Сэлбэ гол тасалдахад нөлөөлж байгаа юм. ►

Нийслэлийн зуслангийн айлуудаас хашаандаа худагтай нь хэд вэ гэхээсээ худаггүйг нь тоолж гаргахад амархан болсон байж ч магадгүй хэмжээнд очихоод. Гэтэл тухайн гудамжинд нэг худаг байхад л хангалттай баймаар.

-Цэвэр усны нөөцөөр Монгол дэлхийд толгой цохидог. Харин усаа “цэнхэр алт” болохыг нь хэр мэдэрсэн гэж бодож байна вэ?

-Уул уурхайн салбар Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн түлхэц юм бол усных нь асуудлыг бүрэн шийдвэрлэх ёстой. Усны асуудлыг шийдвэрлэхдээ усны нөөц, бохирдол талаас нь анхаарах хэрэгтэй. Ус хэнийх юм бэ гэдэг нь ойлгомжтой байх нь чухал. Бид зөвхөн усаа үнэлээд, усаа зараад суугаад байхад л Оюутолгойн зэс, Тавантолгойн нүүрснээс хэд дахин илүү ашиг олохоор харагдаж байна. Ингэж ярихаар хүмүүс хэт туйлширч байна гэж бодох байх л даа. Манайх уул уурхайг хөгжүүлэхгүйгээр усны компаниудыг түлхүү хөгжүүлээд Өвөр Монголын уул уурхайн усан хангамжийг бариад байх боломжтой. Өөрөөр хэлбэл, монголчууд усны зах зээлийн боломжит крант дээр сууж байгаа гэсэн үг.

Би нэг түүх цухас өгүүлэе. 1965 онд Ю.Цэдэнбал дарга Хятадад айлчлаад Мао Зидун даргатай уулзсан юм билээ. Энэ үеэр Мао Монголын гол, мөрнүүдээс ус татаад Хятадын хойд хэсэг буюу Цагаан хэрмээс хойших нутгийг усаар хангах төслийн саналыг анх тавьж байсан гэж тэмдэглэсэн байдаг. Энэ нь тухайн үедээ эдийн засгийн ач холбогдол гэж харахаасаа илүүтэй цэвэр улс төрийн болоод үндэсний аюулгүй байдлаа харгалзан үзээд цааш нь хэлэлцээр хийх хэмжээнд хүртэл нь дэлгэрүүлж яриагүй юм билээ.

-Манайд Өвөр Монголын уул уурхайн компаниудын усан хангамжийг бариад байх хэмжээний тийм их усны нөөц бий гэж үү?

-Бид нийт ашиглаж болох усныхаа дөнгөж хоёрхон хувийг л хэрэглэж байна. Ашиглаж буй усны 80 хувь нь гадаргын ус. Тиймээс усан сан байгуулах, борооны болон шар усны үерийн усыг цуглуулж хадгалах хэрэгтэй. Үүгээр газар тариалангаа дэмжээд явах бүрэн боломжтой. Ийм зүйл хамгийн хөгжих боломжтой аймагт жишээ нь Говь-Алтайг нэрлэж болно.

Монголчууд хүн төрөлхтний өмнө асар их үүрэг хүлээсэн

-Манайх дэлхийн усны экосистемд ямар байр суурь эзэлж байна вэ?

-Дэлхийн цэвэр усны нөөцийн 25 хувь нь Байгаль нуурт хамаардаг. Байгаль нуурын гол онцлог нь юу вэ гэхээр Монголын голуудаар тэжээгдэж байдаг. Энд усаа цутгадаг нь Сэлэнгэ мөрөн. Эргээд дэлхийн томоохон мөрнүүд Байгаль нуураас эх авч байна.

Байгаль нуур нь Монголын голоор тэжээгдэнэ гэхээр монголчууд хүн төрөлхтний өмнө ямар их үүрэг хүлээж байгаа нь эндээс харагдаж байгаа юм. Мөн дэлхийн цэнгэг усны нэг хувь нь Хөвсгөл нуурт бий.

-Томоохон гол, нууруудын усны түвшин буурч байна гэсэн сэтгэл түгшээсэн судалгааны дүн жил бүр гардаг. Та Монгол орны усны нөөцийн хэмжээг тоо баримтаар сонирхуулахгүй юу?

-Улсын хэмжээнд аваад үзвэл усны нөөц хангалттай бий. Гэхдээ Монгол өргөн уудам нутагтай учраас усны хүрэлцээ хангамж харилцан адилгүй. Жишээлбэл, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн усны нөөцийг аваад үзэхэд дэлхийн аль нэг улсын дундаж хэмжээнээс харьцангуй их. Гэтэл говийн аймгуудын усны нөөц дэлхийн дунджаас хэд дахин бага байгаа юм. Монгол Улсын хэмжээнд ашиглаж болох усны нөөц 610 гаруй шоо км. Үүний 80 хувь нь гадаргын ус, 20 хувь нь газрын гүний ус. Монголчуудын усны хэрэглээний 80 хувь нь газрын гүний ус, 20 хувь нь гадаргын ус. Харин Улаанбаатар хотын усан хангамжид 99 хувь нь газрын гүний усыг ашиглаж байгаа нь эргээд нөөц багасахад нөлөөлж байгаа.

Зүйр үгсээс “Хар ус харамладаггүй” гэдгийг хасах хэрэгтэй

-Усны асуудал бол мөнхийн сэдэв. Монголчууд эртнээс хар ус гэж ярьсаар ирсэн нь өнөө болтол биднийг чандмань эрдэнэ гэгдэх усны үнэ цэнийг мэдрэхгүй, мэдрэх хүсэлгүй болгож хувиргасан байх талтай юу.

-Дэлхийн хэмжээний “Их-20” уулзалтаар өмнө нь валют, цөмийн зэвсэг ярьдаг байсан бол өнөөдөр усны асуудлыг л ярьдаг болсон. Ус бол хэн нэгний өмч биш, нийт хүн төрөлхтний өмч юм байна гэсэн ойлголттой болж байна. Гэтэл монголчууд мөнөөх л байдгаараа усыг огт тоодоггүй хэвээрээ.

Монголын олон сайхан зүйр цэцэн үг байдаг. Гэхдээ тэндээс “Хар усыг харамладаггүй” гэсэн үгийг авч хаях хэрэгтэй. Харин ч хамгийн харамлах ёстой зүйл нь ус болоод байна. Гэтэл Улаанбаатар хотоор жишээ авахад, газрын доорх усны нөөцдөө үнэхээр хайнга хандаж байгаа. Уг нь газрын доорхи ус нэгдүгээрт, маш цэвэр, байгалийн шүүлтүүртэй. Хоёрдугаарт, нөхөн сэргээгдэх чадвар нь удаан. Бидний хийсэн судалгаагаар голын ус жилдээ 18 удаа ус нь солигдоод цэвэршдэг бол газрын доорх ус 500 жилийн хугацаанд бүрэн цэвэршдэг гэсэн дүгнэлт гарсан. БНСУ-аар жишээ авахад тэнд 20 мянган том, жижиг нийлсэн усан сан байна. Усан сандаа бороо, үерийнхээ усыг цуглуулаад л хотынхоо болоод хүн амынхаа усан хангамжийн асуудлыг бүрэн шийдсэн. Ингээд үзэхээр Монгол Улс усаа огт үнэлэхгүй байгаа нь үнэхээр харамсалтай л санагдаад байгаа юм.

-“Ус” үндэсний хөтөлбөр хэрэгжиж байна вэ?

-Хөтөлбөр 2021 он хүртэл хэрэгжинэ. Жил жилдээ ажлаа төлөвлөөд явж байгаа. “Ус” үндэсний хөтөлбөрийн давуу тал нь 2021 он хүртэл усны салбарт юу хийх хэрэгтэй, үүнд хэдэн төгрөг шаардлагатай гэдгийг гаргаж ирсэн. Хөтөлбөрт заасны дагуу өнгөрсөн онд Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг боловсруулаад УИХ-д өргөн барьсан. 2012 онд Туул гол дээр усны нөөцийн цогцолбор барих ТЭЗҮ-ийг хийнэ. Усны төлөвлөгөөний дагуу улс орны хөгжил явдаг. Одоо гэхэд Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулж байна.

-Усаа хэмнэж, гамнах нь эцсийн дүндээ иргэн бүрээс хамааралтай. Та иргэдэд хандаж юуг уриалах вэ?

-Ус бол бид бүгдийнх. Усны асуудал Усны газар, БОАЖЯ, би, чи, бидний хүүхдэд ч хамаатай зүйл. Тэгэхээр өөрөөсөө эхлээд усаа хайрлаж гамнах алхмыг хийж эхлэх хэрэгтэй. 36 жил шүдээ угаах усаараа нэг жилийн дотор л шүдээ угаачихаж болохгүй. Энэ нь бид үр хойчийнхоо ууж хэрэглэх уснаас хулгайлж буй хэрэг. Эдийн засгийн хамгийн гол зорилго нь бага зардлаар их ашиг олох. Үүнтэй адил албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх бүр дор бүрнээ усаа хэмнэхэд суралцаасай гэж уриалах байна. Хэмнэж, гамнахыг хаана хаана л хийцгээе. ■

Сурвалжлага

Хаагаарай

Э.Зоригт

Идэр насны хүдэр эр, гурван есийн хүйтнийг үл хайхран энгэр заам нь задгай байх агаад “Хаагаарай” хэмээн хашгирна. Удалгүй түүний ард дугаарласан 60 гаруй насны эмэгтэйн усны саваа дүүргэх ээлж ирлээ. Эмэгтэйн ард ээлжээ хүлээн зогсох арав орчим насны жаал хүү аниргүйг эвдэн “Ах аа, хоёр цэнхэр” гээд мөнгө сарвайх аж. Дахиад л “Хаагаарай” хэмээх дуу хадаж, жаал хүү урагшиллаа. Энэ мэт арав гаруй хүн өөрийн ээлжээ хүлээх. “Хаагаарай” гэж дуу гарах бүрийд дараалалд зогсоо хүмүүс баярлана. Өвлийн хүйтэн, зуны халуунд худгийн ойр орчимд хөл хөдөлгөөн үл тасарна. Жаалууд насандаа ахадсан савтай ус өргөх нь бий. Гэр хорооллын иргэдийн хувьд ус гэгч чандмань эрдэнийн төлөө уртаа гэгч дараалалд, нас үл харгалзан дугаарлаж зогсох үе цөөнгүй. Гэхдээ тэд худгаас ус авахдаа савныхаа гадуур халиулж асгахдаа огт санаа зовдоггүй.

Худгийн ус асгарсаар

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Х хорооны 54 дүгээр ус түгээх газар буюу худгийн ойр орчим мөсөнд хучигджээ.

Дээрх худгийн ажилтан, үйлчлүүлэгч нарт хандан “Та нар усаа хаа гээд олигтойхон хэлэл дээ, хүн хэлээд байхад чинь” хэмээн бухимдах ажээ. Хэдийгээр ус авч байгаа иргэд “Хаагаарай” гэж хашгирах хэдий ч өндөр даралтаар гарч буй ус хүүе хаая гэхийн зуургүй савыг дүүргэж, гадуур нь асгаж орхино. Худгийн ус түгээгчээс устай холбоотой зарим зүйлийг сонирхлоо.



-Сайн байна уу Та. Худгийн ойр орчим тэр чигтээ нэлээд зузаан мөстчихөж. Хагалсан мөс ч зөндөө байна. Усыг асгахгүй хийж болдоггүй юм уу?

-Харин тиймээ, манайхан усыг арай л дэндүү асгаад байх юм. Ажиглаад байхад томчууд нь бүр илүү асгана шүү. Харин жаахан хүүхдүүд ус авахаараа бараг л асгахгүйг боддог. Эвийг нь олоод байдаг юм. Худгаас ус авахад бас арга туршлага хэрэгтэй. Ус авч сураагүй томчууд хүүхдүүдээсээ илүү гадуур нь асгана.

-Хэрэглэгчид ойролцоогоор 30 литр ус авлаа гэж бодоход хэдий хэр ус асгаж байна вэ?

-За би тав зургаан жил худагт ажиллаж байна. Хараад байхад хоёр гурван литрээр бол асгчихдаг. Гэхдээ хүн бүр тэгж асгадаг гэж хэлж болохгүй. Савны ам, ус авч байсан туршлага зэргээс их хамаарна л даа. Бас худаг ажиллуулж байгаа бид нар гарынхаа баримжаагаар усны крантыг хэр нээхээ тохируулдаг болохоор надаас бас шалтгаална гэсэн үг. Үйлчлүүлэгч ирээд “За нээгээрэй” гэхэд огцом нээчихвэл сав нь дүүрэхээр хальж асгарах усны хэмжээ их л байх болно.

-Одоо гадаа хагалсан мөсийг яах вэ Та өөрөө зөөх үү?

-Хагалахыг нь ч би аль эсвэл манай нөгөө ээлжийн ажилтан маань хийчихнэ. Хоёр өнжөөд л гаднах мөсөө хагалдаг. Хагалаад бэлдчихээр цаад байгууллагаас ирээд ачаад аваад явдаг юм.

-Цаанаас гэдэг нь хаанаас машин ирж ачдаг гэж. Тэгээд тэр их мөсийг ашигладаг болов уу?

-Ашигладаггүй байх аа. Юунд л ашиглав гэж дээ. Мөс ачсан машин их л хурдан буцаад ирдэг шүү дээ. Хотын зах руу гаргаад хаядаг биз.

-Ойролцоогоор хэчнээн машин болох вэ?

-Нэг тоннын даацтай ачааны тэргээр хоёр удаа л зөөнө дөө.

-Таны бодлоор хүмүүс, усны үнэ цэнийг хэр мэдэрч, ойлгодог юм шиг санагддаг вэ?

-Үнэ нь бага болоод ч тэр үү, их л хайнга хандаад байх шиг. Ядаж литр тутмын үнийг таван төгрөг болговол хүмүүс арай л хямгатай хандах байх. Одоо чинь литр ус нэг төгрөг ш дээ. Арай л хямдхан болохоор үнэ цэнэгүй санагддаг байж магадгүй юм.

-Худгаар үйлчлүүлж байгаа хүмүүс “Хаагаарай” гэж хашгираад байгаа хэрнээ ус хальж асгарах юм. Энд үр дүнтэй арга юу байх вэ?

-Өө миний хамгийн хэлэх дуртай үг “Хаагаарай” болсон байх/инээв/. Хүмүүс ч энэ үгэнд дуртай, үнэн сэтгэлээсээ ханддаг болчихвол усаа гамнах байх аа.

/Ус авах хүмүүсийн дараалал улам уртсаж, түүний ажлын ачаалал ихэслээ. Тийм болохоор цаашаа ярилцах боломжгүй болов/. ▶



Фотог зохиогч

► Харин IX дүгээр хорооны иргэдийн бодлыг сонирхлоо.

Мөнхбат “За бензин, мах, гурил гээд бүх юмны үнэ нэмэгдээд байхад усны үнийг бас нэмээд хэрэггүй биз дээ. Манайхан чинь эртнээс “Ус чандмань эрдэнэ” гээд их хүндэлдэг байсан. Булгийн эхэнд хир буртаг угаахгүй, сүү дусааж болохгүй гээд дэг ёс ихтэй. Энэ нь усны үнэ цэнийг мэддэгийн нэг шинж байх. Бидний үеийнхэн энэ заншлаар л хүмүүжсэн. Гэхдээ байрны айлууд, манай таван ам бүл цай чанаад уучих хэмжээний цэвэр усыг “00”-доо нэг удаа татаад л бохирын хоолойгоор урсгачих юм байна шүү дээ. За тэгээд усанд орох, шүдээ угаах гээд урсгаад л байдаг. Тэд нар бидэн шиг худгаас ус авч үзвэл л ойлгох байх” гэсэн юм. Мөнхбатын гурван ам бүл өдөртөө 20 орчим литр ус хэрэглэдэг аж.” Ж.Дэлгэрцэцэг “Усны үнийг нэмэх юм бол усанд хандах хандлага арай л дээрдэх байх даа. Гэхдээ иргэдийн гэхээсээ илүү ус ихээр хэрэглэдэг аж ахуйн нэгж, үйлдвэрийн замбараагүй хэрэглээг багасгахын тулд үнийг нэмж болно” гэв.

Томоо тэргэн дээр 100 литрийн сав тавьчихсан, жаахан охин мөсөн дээр хальтарчихгүйг хичээн худаг тийш яарах аж. Ойр хавийнхны нэрлэдгээр “Усчин охин” ирж яваа нь энэ аж. 13-хан настай хэдий ч 500 гаруй метрийн цаанаас ус авахаар өдөр бүр ирдэг энэ охиныг өхөөрдсөндөө энэ нэрийг өгөө биз ээ. Нийслэлийн дөрөвдүгээр сургуулийн 86 ангид сурдаг “Усчин охин” худагт ирээд усаа хийлээ. Савныхаа гадуур ус асгасангүй. Цаанаа л нэг эвлэгхэн. Уг нь “Усчин охин”-ы нэрийг С.Хонгорзул гэдэг аж. Хэзээнээс ус авдаг болсон талаар асуухад “Мэдэхгүй ээ, аваад л байдаг ш дээ” гээд инээнэ. Тэрбээр долоо хоногтоо хоёроос гурван удаа 100 литр ус авдаг аж. Харин гэрийнхэн нь түүний зовж авдаг усыг хэтэрхий хайр гамгүй хэрэглээд байх шиг санагддаг байна. Гэхдээ тэр хэзээ ч ус харамлаж аав, ээждээ уурлаж чаддаггүй гэнэ. Тиймээс “Нүүр гар угаах, аяга угаах гээд өөрийнхөө хийдэг ажил бүр дээр ус хэмнэхийг боддог. Тухайлбал, аяга угаасан усаар алчуураа угаагаад, түүгээрээ шалаа угаадаг” гэв. Өвлийн хүйтэнд хичээн чармайн байж ус авдаг болоод ч тэр үү монголчуудад төдийлэн байдаггүй ус хэмнэж гамнах ухаанд өсөх наснаасаа суралцаж байгаа “Усчин охин” тэрэгтэй усаа түрээд бараа нь алсарлаа. Хүүхэд бүр түүн шиг багаасаа ус хайрлахад суралцвал тун сайнсан.

“Хаагаарай”, “Ах аа, хоёр цэнхэр” гэх дуу алсарч багадаа худгаас ус авдаг байсан үе минь бодогдоно. 25 литрийн хоёр шар савыг өргөж ус авдаг болсон тэр үедээ өөрийгөө чухам л чадалтай болсон мэт сэтгэдэг байсансан... Нэг мэдэхнээ ажлынхаа үүдэнд ирчихэж. Ажил дээрээ ирээд усны талаар интернэтэд “Дэлхий дээр нэг минут тутамд усны хомсдолын улмаас нэг хүүхэд нас барж байна” гэсэн мэдээг хараад сэтгэл тавгүйтэв.

“00”-ын өрөөнд орлоо. Гараа угаах гээд усаа нээхдээ, өөртөө “Хаагаарай” гэж үнэн сэтгэлээсээ хэлээд, сэтгэл хангалуун гарч ирлээ. ■



Фотог Ү.Одбаяр

Эргэцүүлэл**Үнэ цэнэтэй “Хөх сувд”****Б.Алтай**

Дорнын тэнгэр бүртийх үүлгүй дээр цэлийж, бүтэн сарыг бүлээн усаараа угаасан Буйр нуурын мандал долгиотно. Халхын гол хатиран бидэртэж мяралзсаар Баянцагааны нурууны өмнүүр жирэлзэхэд нь эх оронч голын үүх түүх санагдах ажээ. Дайны жилүүдэд усны гачаалд ороогүй дорныхон хөх тэнгэр, талын тэнгис, мөрөнтэйгөө энд л ханьсана. Ялалт, яруу алдарыг угаасан эх орны минь сүү, нулимс нь ус юм шүү дээ гэж бодохоор л сэтгэл минь өмөлзөн гунигт автах юм. Усыг бид ямар үнээр, ямар ялалтаар, ямар их уй гуниг, гаслан зовлонгоор авсан юм бэ. Үүнийг өнөөдрийн бид мэдэхсэн бил үү. Бэлэвсэн эмэгтэй, аавгүй хүүхэд, хүүгүй аав ээжийн өмөрсөн сэтгэлийг золиослон байж авсан бус уу. Он жилийн гуниг зуусан аялгуу нь Халхын голын урсгал чимээ мэт. Урсгал чимээнд нь уужран бид тайтгардагсан. Ус, ус... гэж амиа алдсан цэрэг дайчдын уй гуниг хайлааст манхан, хамар даваанаас сонсогдох шиг болно.

Мэнэнгийн талаас мэлтэсхийн манхайх нар Халхын голыг зүлгэн байж, Буйрын торгон мандалыг эвхэн эвхэн нар ус энд л болздог. Өөр хаана ч байхгүй тал, ус, тэнгэрийн “үлгэрийн цаг” дорно зүгт л бий. Үүнийг л үзэх гэж “устай” газрын ус үзээгүй хүмүүс ирдэг юм гэнэ лээ. Буйр нуурын элсэн эргэнээс тэртээд манантах их усны цаад

захыг харах гэж л нүдээ бүлтийтэл ширтэнэ. Тэглээ гээд тэнгэрт буй усыг л үзэхээс захыг нь үл олж харнам. Дорнодод Буйр нуур, Халхын гол байгаагүй бол гэж бодохоос нуруу арзасхийнэ. Байгаа нь бидний аз, Монголын их хувь заяа юм даа. Үүнийг даан ч бид хэр мэддэг юм бол. Хэрхэн хайрладаг юм бол оо.

Өвс мэхийх дорнын шар талд яагаад Орос, Хятад, өнөөдөр ч гэсэн япончуудын сэтгэл нь хоргодоод байдаг юм бэ. Төрсөн нутаг нь биш, төрүүлсэн аав ээж, эцэг өвгөд нь энэ нутагт байгаагүй хэрнээ л элэгтэй гэдгийг нь яана. Халхын гол, Буйр нуурыг бараг л монголчуудаас илүү хайрлах гээд байгаа юм уу даа. Гэтэл монгол хүн ийм уудам тал нутгаасаа Улаанбаатарыг зорин нүүн шилжиж, уйдаж байхад шүү дээ. Буйр нуурын эргээс Улаанбаатарыг “хайрлан дуулсаар” гэр орноо ачаална. Ийм байхад Халхын гол, Буйр нуураа сахиж хэдэн застав л үлдэх бололтой. Тайван цагийн цэрэг эрс Халхын голд шумбаж, Буйр нуурт усанд орж, загасчлан цэргийн албаа хааж байна.

Байгаль нуурыг оросуудад өглөө гэж Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал агсныг хэчнээн их баалсныг түүхээс харж болмоор. Гэтэл бид усаа хайрлаж чадаж байна уу. Хамгаалсан уу?

Туулаас цэвэрхэн Халхын гол, Буйр нуураа ►►

► байлдаж олсон юмсан. Гэтэл жуулчилсан болгон нь хог тарьж, ул мөрөө үлдээнэ, ууж идсэнээрээ ч тамгална. Халхын гол, Буйр нуураа хайрладаг, уул усаа бүтэн хамгаалдаг сэтгэлтэн хаана байна вэ?

Уульг нь ухаж, нураана. Усыг нь ууж, уусгаж, урсгаж, хордуулж наадна. Үхэл тэмцлээр олж авсан гол мөрөн уг нь үнэ цэнэтэй баймаар. Халхын гол дорныг эмжин, дорноос өрнө рүү урсаж байхад Халх гол сумынхан шилжиж нүүгээд сумын төв нь багийн төв болсон байна билээ. Тэд хөрс нь дээд зэргээр бохирдсон, газрын доорхи усаа бараг л шавхаж буй дөрвөн уулын хавчиг хавцал руу юунд яарна вэ?

Тэгш дүүрэн холын бараатай дорнын талд буй Халхын голоос дөрвөн уулын хатан Туул цэвэр гэж үү. Туулын ус тунгалаг, дүүрэн байсныг Дорнын их яруу найрагч Б.Явуухулан “Туулын урсгал шөнөдөө сайхан” хэмээн өнгөрсөн зуунд бичсэн.

Дэлхийд ганцхан хувь Хөвсгөл нуур

Сантын уулс нуурын цаана “нойрмоглоно”. Харин Хорьдол сарьдагийн нуруу өлийн даваа шиг тээр дээр харагдана. Угаасаа ч Дархадын уулс өндрөөс өндөр. Ийм өндөрт л идэр шувууд дүүлж сурсан байх гэж бодогдмоор холд шүү. Тийм болохоор л энэ нуруунаас эх аван 70 метрийн өндрөөс Арсайн голд буух хүрхрээ байдаг байх. Уран дөшийн нуруу хэзээ ч бэлийн салхи хүрмээргүй алс буйд цоройно. Оройдоо олон жилийн мөнх цастай дүнхийнэ.

Зун очиход ийм л байдаг юм. Дэлхийд ганцхан хувь Хөвсгөл нуурын эргэн тойрон нээж олсон шинэ тив мэт сонин. Нээж олсон шинэ тивийг үзэхээр газар газрын жуулчид ирчихсэн байдаг. Харин нуурын эрэгт байсан өвгөн мод л хэвээрээ. Нуурын ус ч янзаараа салхитай байвал шуугин давалгаална. Урсгал намуухан давалгаанаас нь уулын цэцэгний үнэр ханхийнэ. Буцаад л тув тунгалаг, түүний нүд

шиг санагдана. Нуураа бараадсан уулсын өлмийгөөр өтгөн манан хононо. Өтгөн мананг дагаж өрнө, дорнын шувууд энд цугларна. Зүс үзээгүй олон шувууд нуурын дөрвөн аралд өчнөөн жилээр саатаж ирсэн биз ээ. Хадан хүй, Модон хүй гээд нуурын арал нь их усны амьсгалдаг амсар болов уу гэмээр.

Монголын баруун, төв, зүүн хэсэгт гурван том нуур буй. Төвд байгаа нь Хөвсгөл. Баруун талынх нь Увс, Зүүн нь Буйр билээ. Эх орны минь хойд хэсэгт Оросын хилийн ойролцоо орших цэнгэг устай нуураа бид далай ээж хэмээн дууддаг. Дэлхийн цэнгэг усны 0.4 хувь нь Хөвсгөл нуурт буй. Нуурт 96 гол горхи цутган, ганцхан Эгийн гол эрх танхил боргио үүсгэн Сэлэнгэ мөрнийг зорино. Мөрнөөр дамжин Байгаль нуурт хүрнэ. Бид л танайх, манайх гэж Байгаль, Хөвсгөл нуурыг хилийн шугамаар заагласан болохоос усанд хил гэж байна уу.

Цэвэр усаараа баянд тооцогдох манай орныг Хөвсгөл нуураар нь олон гадаадынхан мэднэ дээ. Ус ийм үнэ цэнэтэй аж. Ус тийм л нэр хүндтэй юм байна. Хөвсгөл аймаг гэхээр Хөвсгөл нуур л санаанд бууна. Хөвсгөл аймгаас өмнө Хөвсгөл нуур үүссэн болохоор арга ч үгүй. Нуурыг тойроод нутгийн иргэдээс ч олон хүн, зочидтой жуулчны бааз байрлаж, тэнд үйл ажиллагаа явуулж байна. Хөвсгөл нуур байгаа болохоор л тэд энд буй хэрэг. Жуулчид Хөвсгөл нуурыг үзсэнийхээ төлөө Монголд хөрөнгө оруулж байна. Ус биднийг ундаалж, ан амьтан, ургамал цэцэг, уул тал, хангай говийг тэтгээд зогсохгүй, улс орны хөгжлийг ч түргэсгэж буй нь энэ. Усаар ганцхан жишээ татахад ийм байна. Үүнийг л үнэ цэнэтэй “хөх сувд” гэж хүн төрөлхтөн нэрлээд байгаа юм аа.

Хууль

Саарал усны ашиг

Б.Баяр

Саарал ус гэж юу вэ. Ахуйн хэрэгцээнээс гарсан бохир усыг саарал ус хэмээн Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулинд тодорхойлжээ. Үүнийг бид өдөр бүр амьдралдаа “үйлдвэрлэдэг”. Усанд орж, аяга, тавгаа угаасан саарал усыг шууд төв цэвэрлэх байгууламж руу урсгаж байна. Гэтэл манайхан саарал усаа бохир ус хэмээн тооцдог л хамаг учир байгаа аж.

Батаа өглөө бүр шүршүүрт орж, Дулмаа өдөр бүр аяга шанагаа угаахдаа саван хөөс төдийхнөөр бохирдсон хэчнээн литр цэвэр ус урсгадгаа мэдэх

болов уу. Магадгүй усны тоолуураас харж болох ч ус үнэтэй мөртлөө үнэгүйдэж буй нь энэ.

Гэр хорооллын айл Доржийнх хоногт 15 литр ус ашиглаж, үүнийхээ зургаан литр усаар хоол, цай, үлдсэнээ ахуйн хэрэглээндээ зориулж, саарал ус болгон хувиргадаг байна. Гэхдээ саарал ус ашиглалт гэр хороололд харьцангуй сайн байгаа нь энэ. Доржийнх амралтын өдрүүдэд 80-100 литр усаар хувцсаа угааж, мөн тооны саарал усыг муу усны нүхэндээ юүлдэг. Гэр хороололд ийм хэмжээний хэдэн мянган литр саарал ус хөрсөнд

шууд шингэж, Туул голд өдөрт хэчнээн мянган шоо метр өнгөө хувиргасан ус орон сууцнаас нийлүүлэгддэг болохыг сонирхоход харамсал төрөхөөр. Үүнийг л шийдэх үүднээс Саарал усны тухай хуулийг батлахаар зэхэж байгаа аж. Тиймээс удахгүй төрөх уг хуулийг манай сэтгүүл “Хууль” буланд аа онцоллоо.

Газрын гүний усаар машинаа угааж, хивсээ цэвэрлэж, “ОО”-доо татдаг “тансаг” хэрэглээгээрээ монголчууд өдгөө хөгжингүй орнуудын өмнө нь цохиж явна. Харин усны хэмнэлтээрээ дэлхийд сүүл хормойлох шинжтэй ►

▶ талаар холбогдох мэргэжилтнүүдийн амнаас чамгүй сонслоо. Жишээ нь шүршүүр, гал тогоонд хэрэглэсэн усаа цэвэршүүлэн эргээд ариун цэврийн өрөөндөө хэрэглэх боломжийг Саарал усны тухай хуулиар олгох юм байна. Усаа гаднаас импортолж буй Сингапур улс л гэхэд ийм хууль батлаад томоохон сургууль, эмнэлэг, зочид буудал, орон сууцандаа сүүлийн арван жилд өргөн хэрэглэж байгаа аж. Мөн Хонконг, Сингапурын жишгээр саарал усыг өргөн ашиглаж буй гэнэ. Хэчнээн хэмжээний ус хэмнэх нь ойлгомжтой. Харин бид холын жишээг ярихын зэрэгцээ өөрсдийн амьдралдаа ойртуулахын тулд өнөөдрийн саарал усны ач холбогдлыг тоочоод барамгүй.

Орон сууцанд амьдарч буй Батаад хоногт дунджаар 285 литр ус ногдож байгаа бол гэр хорооллын Доржийн хоногийн усны хэрэглээ 15 литр. Орон сууцны цэмбэгэр айл Батаагийнхаас гарч буй 275 литр усны ойролцоогоор 200 литр нь эргэн ашиглах боломжтой саарал ус тул эргүүлж ашиглаад эдийн засгийн хэмнэлт гаргаж болох юм гэдэг үүднээс Саарал усны тухай хуулийн хэрэгцээ шаардлага буй.

“Тус хууль хэрэгжсэнээр усны худалдаа бий болно. Усыг ашиглах үйлдвэрлэгчдийн зардал буурч, ашиг нэмэгдэнэ. Бидэнд ирж буй эцсийн бүтээгдэхүүний үнэ буурна. Экологи талаасаа байгаль орчинд маш эерэг нөлөө гарна” хэмээн Усны газрын орлогч дарга З.Батбаяр дүгнэсэн. Өөрөөр хэлбэл, нэг жишээ татахад, “Ээрмэл” компанитай хэдхэн метрийн зайд байрлах АПУ компани бүтээгдэхүүний сүүлийн дамжлагадаа 50 хэмд халаасан 0.2 хувийн хлортой ус бэлтгэхийн тулд цэвэр ус авч, халаадаг байна. Эцэст нь тус компанид үйлдвэрлэлд ашигласан усаа шууд урсгахгүйгээр 50 хэм хүртэл халаасан усаа бусдад зарж болох эрхийг Саарал усны тухай хууль олгож байгаагаараа давуу болохыг мэргэжилтнүүд хэлж байв.

Иймээс АПУ компани бүтээгдэхүүн угаасан усаа “Ээрмэл” компанид зарж болох нь. “Ээрмэл”-ийн хувьд 60 градус халсан усаар ноосоо угааж, задалдаг бөгөөд цэвэр ус аваад, түүнийг халаахын тулд багагүй цахилгааныг зарцуулдаг аж. Хоорондоо хэдхэн зуун метрийн зайтай хоёр компани тохиролцоод хоолой татаад усны дахин ашиглалтыг яруу тодоор харуулж болох юм байна. Ус, цахилгаан хэмнэх таатай зах зээлийн сул ашиг энд байгаа аж.

Цаашилбал, оёдлын үйлдвэрт хүнсний үйлдвэрийн хаягдал усыг бүрэн ашиглах боломжтой юм байна. Зарим хүнсний үйлдвэрийн технологийг тооцохгүйгээр хүнсний хаягдал усыг ашиглах өргөн боломжтой болохыг ч усны салбарынхан тайлбарлаж байв. Жишээ нь оёдлын үйлдвэрийн хаягдал усыг арьс ширний үйлдвэр ашиглаж болох нь. Үүнийг л саарал усны ашиг гэж нэрлээд байна. Энэ хууль хэрэгжсэнээр иргэдийн амьдралд яаж нөлөөлөх вэ. Албаны хүмүүсийн хэлж байгаагаар усны тоолуур дээр гарах сар бүрийн төлбөрийн хэмжээ багагүй хувиар буух боломжтой гэнэ. Ингэснээр усанд төлж буй танай өрхийн зарлага буурна. Улаанбаатарын хөрсөн дор буй гүний усны нөөцөд ч хэмнэлт гарах аж.

Нийт хүн амын усны хэрэглээ /хувиар/



Эх сурвалж: УСУГ

“Саарал усыг ашигтай үед хэрэглэдэг. Ус бол эдийн засгийн чухал бүтээгдэхүүн, усыг хаана зөв зүйтэй ашиглаж байна, тэнд эдийн засгийн хөгжил ирнэ” хэмээн З.Батбаяр дарга өгүүлсэн. УИХ-ын гишүүн Н.Батбаяр “Шинээр барих орон сууцны барилгад саарал усны шугам оруулах стандартыг ашиглах. Станцуудад цэвэр ус биш, саарал усыг ашиглах хэрэгтэй. Одоогоор тэд маш их цэвэр ус хэрэглэж байна. Орон сууц руу дөрвөн усны хоолой орж байгаа. Цэвэр, бохир, халуун, дулаан гээд. Тэгвэл халуун усыг өөрсдөө бий болгож болно. Халуун усны шугамын оронд саарал усны шугам оруулах гэсэн санал байна. “00”-д саарал ус хэрэглэх хэрэгтэй” гэв.

Уул уурхайн салбарт ч саарал усыг ашиглаж болно. Оюутолгой, Тавантолгойн төсөлд саарал усыг ашиглан бүтээн байгуулалтыг

түргэсгэж, цэвэр усаа хэмнэх, зардлыг бууруулах ашигтай боломж байгааг тэрбээртэмдэглэсэн юм. Ойролцоогоор Улаанбаатар хотод өдрийн 160 мянган шоо метр саарал ус асгаж байгаа бол Оюутолгой төсөлд 100 мянган шоо метр усны асуудал босож ирж байна. Саарал усны хоолойг өмнийн говь руу татаж болох шинэ төслийн санааг УИХ-ын гишүүн Н.Батбаяр хэллээ.

Ахуйн хэрэглээнээс үүдэлтэй бохир усаараа бид шавар ч зуурч байшин ч барьж үзээгүй улсын нэг. Энэ онд улаанбаатарчууд цэвэр усыг хэмнэх үүднээс саарал усыг эргүүлэн ашиглах системийг нэвтрүүлэх талаар Улаанбаатар хотын удирдлагууд мэдэгдэж байсан билээ. Ус боловсруулан цэвэршүүлэх систем нь хаягдал ус боловсруулах хамгийн сүүлийн үеийн технологи аж. Энэхүү технологи бохир усыг дээд зэргээр цэвэршүүлдэг бөгөөд хэрэглээнээс гарч буй нийт усны 45 хүртэлх хувийг эргүүлэн ашиглах, замаар хэмнэх боломжтой юм байна. Ийм усыг “00”, машин угаалгын газар, ногоон байгууламж, цэцэрлэгжилтэд ашиглах боломжтой. Цэвэрлэгээний технологийг Герман улсаас оруулж ирэхээр төслийн хүрээнд төлөвлөд байгаа аж.

УИХ-ын гишүүн Г.Баярсайхан “Ус ашиглаж байгаа бүх газар хэмнэлтийн технологид шилжих хэрэгтэй. Уул уурхайд хэрэглэсэн усаа дахин хэрэглэх, үүнийг ахуйн хэрэглээнд нэвтрүүлэх шаардлагатай” хэмээн ярьсан юм. “Бид дэлхийд байхгүй цэнгэг усыг ахуйн зориулалтаар хэрэглэж байгаа ард түмэн. Тиймээс гарсан саарал усыг бүрэн ашиглах нь усны нөөцийн хомсдолоос сэргийлэхэд чухал үүрэгтэй” хэмээн Усны газрын Үйлдвэрлэл эрхэлсэн орлогч дарга Ц.Сосорбарам онцлов.

Манай орны нийт ус ашиглалт, усны хэрэглээ жилд 500 сая шоо метр. “Ус” үндэсний хөтөлбөрт хаягдал бохир усны цэвэрлэгээний түвшинг дээшлүүлэх, эргүүлэн ашиглах чиглэлээр бодлогын түвшинд анхаарах юм байна. Хаягдал буюу саарал усыг цэвэршүүлэн хэрэглэхэд хялбар дэвшилт технологийг нэвтрүүлж, өдөр тутмын хэрэглээнээс үүсэх хаягдал бохир усны хэмжээг багасгахад үндэсний хөтөлбөр үр өгөөжөө өгөх биз ээ. Үүнд таны оролцоо ч хамгаас чухал гэдгийг цохон тэмдэглэе. ■

Дэлхий дахинд


“Усны алтан үе” дууссан

Б.Энхцэцэг

“Өнгөрсөн 100 жил усны алтан үе байлаа. Харин одоо ухамсаргүй усны баярхлаас ухаалаг усны хэрэглээнд шилжих цаг мөч бидэнд тулан ирээд байна” хэмээн “The big Thirst” номын зохиолч, сэтгүүлч Чарлес Фишмэн хэлсэн байдаг.

Америкийн дундаж өрхүүдийн усны төлбөр сардаа 34 ам.доллар. Өдөрт усны хэрэглээндээ нэг ам.доллар төлдөг гэж тооцоолж үзвэл бараг л үнэгүй гэсэн үг. Иймээс хэн ч устай холбоотой шийдвэр гаргахдаа үнэ хөлсийг нь бодож ариг гамтай хэрэглэе гэсэн санаачлага гаргадаггүй. Энэ бол чимээгүй сүйрэл. Үнэгүй юм хэзээд үнэ хүндгүй байдаг хойно хүмүүст “хязгааргүй их” гэдэг сэтгэлгээг өгч байдаг. Үйлдвэр, үйлчилгээ болон фермерийн аж ахуй эрхлэгчид хэзээ ч хэр хэмжээний ус хэрэглэж, хэр ухаалаг зарцуулж байгаа вэ гэж бодож үздэггүй. Учир нь, усны төлбөр нэхсэн цаас тэдэнд ямар ч арвилан хэмнэх дохиог өгч чаддаггүй. Харин ертөнцийн нөгөө хэсэгт ядуус ямар өндөр үнэ цэнээр балга ус олж авдаг вэ гэдгийг хэлье. Хэдэн зуун сая хүн өдрийн талыг ус авахын тулд олон км алхахын зэрэгцээ урт дараалалд хүлээдэг. Үүнийг эс тооцвол тэд усандаа үнэ хөлс төлдөггүй. Гэхдээ эдгээр хүмүүс өөрсдийн болон үр хүүхдийнхээ эрүүл мэнд, эдийн засгийн боломжийг үүний хариуд золиосонд гаргадаг.

Ус дуусвал амьдрал чинь дуусна. Дэлхий дээр ойролцоогоор нэг тэрбум хүн усны гачигдалд тушигдан амьдардаг бол 2,5 сая иргэн эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд амьдарч байна. Энэ байдал цаашид ч хүрээгээ тэлсээр. Дэлхий дээр хоёр төрлийн усны хомсдол байдаг. АНУ-ын Усны төслийн төрийн бус байгууллагынхны гаргасан тодорхойлолтоор найдвартай усны эх үүсвэр эрж олоход хөрөнгө мөнгө, цаг хугацааны бололцоогүй байдлыг эдийн засгийн хомсдол гэнэ. Харин усны хэрэгцээгээ бүрэн хангахад хүрэлцээгүй усны эх сурвалжтай орнуудын нөхцөл байдлыг физик хомсдолд оруулдаг байна. Энэ төрлийн хомсдол сүүлийн жилүүдэд



8 хүн тутмын 1 нь цэвэр усны хомсдолтой амьдардаг. /ДЭМБ/



дэлхийн олон оронд хүний хүчин зүйлээс үүдэн ихсэж байна. Үүний тод жишээ нь АНУ-ын Колорадо мужийн гол мөрний сав газрын усыг хэтрүүлэн, хяналтгүй хэрэглэснээс болж тус бүс нутаг онц ноцтой физик хомсдолд орчихсон байгаагаас харж болох юм.

- Дэлхий дээр хэвтэн эмчлүүлж буй нийт иргэдийн тал хувь нь усаар дамждаг өвчин туссан байдаг байна.

- Дэлхийн хүн амын гуравны нэг нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй орчинд амьдардаг

- Хөгжиж буй орнуудад гардаг нийт өвчлөлтийн 80 гаруй хувь усны болоод эрүүл ахуйн бохир орчин нөхцөлөөс үүдэлтэй

- Таваас доош насны хүүхдийн нас баралтын дөрвөн хүүхэд тутмын нэг нь устай холбоотой өвчний улмаас нас бардаг

- Хөгжиж буй орнуудад хүүхэд, эмэгтэйчүүд өдөр бүр усаа авахын тулд олон км явган алдаг. Тэдний

усаа зөөдөг сав нь ойролцоогоор 20 литрийнх.

- Олон тооны мөсөн гол төлөвлөж байснаас ч илүү хурдан хайлж байгаа нь усны түвшин доошлоход хүргэж байна

- Цэвэр усны амьтад өмнөх жилүүдтэй харьцуулбал 4-6 дахин хурдтай устан алга болж байна.

2050 он гэхэд нэг тэрбум иргэн цангана

АНУ-ын “Байгаль хамгаалал” байгууллагын судлаачид 2050 он гэхэд нэг тэрбум гаруй хүн тогтмол усны хомсдолтой орчинд амьдардаг болно хэмээн дүгнэжээ. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолтоор бүтэн өдрийн турш нэг хүнд ногдох нийт хэрэглээний ус 100 литрээс бага байх тохиолдлыг “Усны хомсдол” гэж нэрлэдэг байна.

Ирэх 40 жилийн хугацаанд дэлхийн


хүн ам гурван тэрбумаар өснө гэж тооцож байгаа. Тэгвэл яг одоогийн байдлаар 150 сая хүн жилдээ доод тал нь нэг сарын турш усны хэт хомсдолд ордог гэсэн судалгаа байдаг. Харин хөгжингүй орнуудад тухайлбал, Америкийн аль хэсэгт оршин суухаас шалтгаалан дунджаар өдөрт нэг хүний усны хэрэглээ 376 литр байдаг байна.

Уур амьсгалын өөрчлөлт дээрх нөхцөл байдлыг улам хүндрүүлж хурдасгагч хүчин зүйл болох хандлага байгаа юм. Хэрэв хойшид хотууд усаа гаднаас авч эхэлбэл усны хомсдол бий болж улмаар эрүүл ахуйн асуудлууд нэн түрүүнд босож ирэх агаад амьд байгаль, экосистемд маш том эрсдэлийг дагуулах аюултай. Усны гачаалд хүргэж болзошгүй томоохон хүчин зүйлүүдийн нэг нь хот суурин газарт шилжин суурьшиж байгаа нүүдэл суудлын асуудал гэдгийг ч судалгаа харуулсан байна. Хот тэлж, хүн ам өсөхийн хэрээр усны хэрэглээ ч нэмэгдэнэ. Энэ мэт амьдралын чиг хандлага ба уур амьсгалын өөрчлөлт нь 40 жилийн дараа гэхэд Энэтхэгийн Мумбай, Хятадын Бээжин тэргүүтэй томоохон 20 хотын тэрбум гаруй иргэн 100 литрээс бага буюу усны гачигдалтай орчинд амьдарна гэсэн дүгнэлт гараад байгаа юм. Хүм амын өсөлт, дэлхийн дулаарал гэсэн хүчин зүйлээс гадна цөлжилтийн асуудал ирээдүйд 100 сая гаруй хүнийг усгүй болгохоор нүүдэллэн айсуу. Хэрэв одоогийнх шигээ хотууд усаар наадсаар байвал 2050 онд зөвхөн хот суурин бус, гол мөрөн намаг балчиг гэсэн чийглэг газрууд болон цэвэр усны экосистемд нөлөөлж, устан үгүйрэх гэнэ. Хүн амын өсөлт, экологийн системээ тэнцвэртэй авч явдаг Энэтхэг улс өнөөдрийн байдлаар дэд бүтэцдээ өөрчлөлт хийхгүй бол тун бэрх цагтай нүүр тулах болж байна.

Дараах 20 улс 2050 он гэхэд усны гачигдалд орох аж. Эргэн тойрон 100 км газар нутгийн хэмжээнд тогтвортой гадаргын усны урсац болоод газрын гүний усгүй болохыг усны хомсдолд орсонд тооцно.

Вашингтонд төвтэй “Байгаль хамгаалал хүрээлэн буй орчныг хамгаалах” бүлгэмийн удирдагч Роб Макдоналд “Энэ тоог хувь тавилан бус биднийг сорьж буй шалгуур хэмээн хүлээж авах нь зүйтэй” гэжээ. Асуудлыг ойлгон хүлээж авна гэдэг түүнийг шийдвэрлэх арга замын 50 хувьтэй тэнцдэг гэдэг. Сайн мэдээ гэвэл асуудлыг шийдэх тоймгүй олон арга зам бий. Тэгвэл яагаад өнөөг хүртэл усны асуудал шийдэгдэхгүй харин ч дээрдэхийн оронд улам бүр

дордоод байна вэ? Үүнд тохирсон тодорхой хариулт гэвэл улс төр, эдийн засгийн олон саад тогтор юм. Хувийн ашиг сонирхол нийлж хамтын сүйрэлд хүргэдгийн нэг жишээ энэ. “Байгалийн нөөцийг хайрлан



Энэтхэг	Дели Момбай Калкутта Бангалори Хидрабад
Мексик	Мексик хот
Нигер	Лагос
Иран	Тегеран
Филиппин	Манилла
Бенин	Котоноу
Өмнөд Африк	Иохансбург
Хятад	Бээжин Шеньжень
Зааны ясан эрэг	Абиджан
Арабын нэгдсэн Эмират	Дубай, Абу Даби
Пакистан	Лахори
Саудын Араб	Эр-Рияд
Израйль	Тель Авив Иурисалим/ Хайфа

хамгаалахтай холбогдсон асуудлыг шийдэх цорын ганц итгэл найдвар нь хүн төрөлхтний санаа бодол үнэт зүйл дэх өөрчлөлт, шинэчлэлтэд оршино” хэмээн Америкийн зохиолч Барбара Кингсолвер бичсэн байдаг. Дэлхий дээрх усны хамгийн ангамал хэрэглэгчид болох үйлдвэрлэл болон газар тариалангийн усны хэрэглээг багасгах нь томоохон нөлөөг үзүүлэх юм. Өөрөөр хэлбэл, усанд ээлтэй газар тариалангийн туршлагыг хэрэгжүүлэх нь чухал байна. Гэхдээ зөвхөн энэ хангалтгүй. Хотуудад дэд бүтцийн эрс өөрчлөлт хийх хэрэгтэй авч энэ нь маш их хөрөнгө мөнгийг шаарддаг. Ингэхээр 2050 он гэхэд мөнгөгүй ядуу орнууд юу ч хийж чадахгүй байсаар хөөрхийлэлтэй байдалд орж мэдэх нь. Усны зарим нөөцөө ашиглах чадамжгүй аюулд орсон тэдгээр улсад өнөөдөр асуудал хяналтаас гарчихаас өмнө олон улсын дэмжлэг маш хэрэгтэй байна.

Шингэн хөрөнгө

Дэлхий дээр бидний хэрэгцээнээс давсан их ус бий. Бид зөвхөн хяналттай ашиглах л хэрэгтэй. Дэлхийн усны өдөр буюу өнгөрсөн оны гуравдугаар сарын 22-нд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мун усны өнөөгийн байдлыг гамшиг хэмээн нэрлэсэн бөгөөд шалтгааныг нь хэдхэн үгэнд багтаасан нь энэ. “Засаглалын сүйрэл, сулхан бодлого, дулимаг хяналт”. Бидэнд аль хэдийнэ усны гамшигтай тэмцэх хэрэгцээ шаардлага нь тулгарчихсан. Одоо харин өнөөх өндөр техник технологио амьдралд ажил хэрэг болгох хэрэгтэй байна.

Улирлын чанартай усны хомсдол ойрын жилүүдэд улам ихсэж байгаа юм. Тэгвэл үүнийг давахын тулд усны нөөц бүрдүүлэх шаардлагатай. Тогтмол усны хомсдолоос сэргийлж холоос ус зөөн хэрэглэхэд дэд бүтцийн өөрчлөлт хийж, тээвэрлэлтийн асуудлыг шийдэх шаардлага бий. Орчин үеийн технологийн ачаар далайн давстай усыг цэвэршүүлж болох болсон. Гэвч усыг давснаас салган авах үйл явцыг далайцтай хэрэгжүүлэхийн тулд энэ чиглэлд хөрөнгө оруулалтын хэмжээг ихэсгэх шаардлагатай байгаа юм. Хэрэглэсэн усаа цэвэршүүлж дахин хэрэглэх аргыг дэлхийн олон хот тэр дундаа манай урд хөршийн нийслэл Бээжин хүн амын өсөлтийн дарамтаас үүдэн ихээхэн түлхүү ашиглаж байна.

Давсыг нь ялгаад авчихдаг болжээ. Гэхдээ... Үнэнийг хэлэхэд усан цэнхэр гариг дээр усны хомсдол гэж байдаггүй. Харин цэвэр усны хомсдол л гэж бий. Орчин үеийн шинэ технологи давс хужрыг нь салгаад, цэвэр ус гаргаад авчихдаг болжээ. Өнөөдөр дэлхий дээр 300 сая хүн дэндүү их давстай далайн болон давсархаг гадаргын усыг аргагүйн эрхэнд хэрэглэж байна. Арван жилийн өмнө энэ тоо хоёр дахин их байсан билээ. Давсгүйжүүлэлт анх 1970-аад оны үеээс Зүүн азд хийгдэж үүнээс хойш дэлхийн 150 оронд тарсан. Ирэх зургаан жилийн хугацаанд өдөр бүр 13 тэрбум галлон буюу Колорадогын нэг голтой тэнцэх хэмжээний усыг давсгүйжүүлж, дэлхийн усны хэрэгцээнд нийлүүлэх аж. Гэвч ирээдүйд хүн ам өсөхийн хирээр газар тариалан, үйлдвэрлэл өргөжиж, ундны ус нэмэгдэнэ гээд бодоод үзвэл дээрхи арга нь амь тариа болохоос нөхцөл байдлыг сайжруулахгүй нь тодорхой. Мөн давсгүйжүүлнэ гэдэг тийм ч хямд төсөр технологи биш. Давс ихтэй байх тусмаа л илүү үнэтэй. Харин ч 20 жилийн өмнөхөөсөө хамаагүй хямд ▶▶

► болсон байгаа нь энэ. Ядуу буурай орны усны хомсдолтой иргэд энэ талаар мөрөөдөх ч хэрэггүй гэсэн үг.

Сайхан мэдээ бас байна аа!

...Энд нэгэн урам хайрлам жишээг онцломоор байна. Камбож улсын нийслэл Фном Пенх хот арван жил ч хүрэхгүй хугацаанд усны алдагдлаа 73 хувиас зургаан хувь хүртэл бууруулж чадсанаар Лондон, Парис болон Лос-Анжелес хотуудаас ч илүү хэмнэлттэй усны хэрэглээг бий болгожээ. Фном Пенх хотын Засгийн газрын харьяа Ус Түгээлтийн газрын дарга Сонн Чан 1993 онд ажлаа хүлээж авсан даруй эрс шийдэмгий томоохон цогц өөрчлөлтүүдийг хийж эхэлжээ. Тусламжийн байгууллага, хөгжлийн банкуудаар дамжуулан эвдэрч элэгдсэн усны шугам хоолойг шинэчлэн сольж, хээл хахуульд автсан ур чадваргүй ажилтнуудаа хайр найргүй халах замаар дэд бүтцийн асуудалдаа огцом эргэлт гаргаж чадсан байна. Ингэснээр хяналт, зохион байгуулалт сайжирч иргэд ундандаа цэвэр ус бүрэн хэрэглэж чадах болжээ.

Непал улсын сонирхолтой туршлагыг энд дурьдахгүй өнгөрч чадахгүй нь. Тус орны Байгаль орчин ба иргэдийн эрүүл мэндийн байгууллага анх 1997 онд Австри улсын Вена хотын, Байгалийн нөөц, Шинжлэх ухааны их сургуулийн дэмжлэгтэйгээр “Чийглэг газар систем”-ийг эмнэлэгт байгуулжээ. Энэ нь элс хайргаар хөрсөн давхарга хийж



түүндээ зэгсэн ургамал тарих явц юм. Энгийнээр үр ашгийг нь тайлбарлавал эмнэлгийн бохир ус хөрсөн давхаргад үеэрлэн орж ирэхэд зэгсэн ургамал түүнийг шүүж улмаар үндэс элс хайрга ёроолдоо тунаран үлдэх бол ус зайлуулах хоолой цэвэр усыг ялган авч явдаг аж. Энэ үеэс хойш Непал улсад дахин 12 чийглэг газар систем оршин суугчдын дунд байгуулагджээ. Аливаа зүйл энгийнээс эхэлдэг гэдэг. Тэгвэл бид энэ мэт энгийн мөртлөө үр дүн сайтай аргуудыг яагаад туршиж болохгүй гэж? Тухайлбал, Бээжин хот 2013 он гэхэд хэрэглэсэн бохир усаа цэвэршүүлж 100 хувь дахин ашигладаг

болохыг зорьж байна. Биднийг байгаль дэлхий уучилж өршөөдөггүй гэдгийг хатуу санах хэрэгтэй. Тэгэхээр бид түүний өсөн нэмэгдэж буй тааварлашгүй харгис хандлагатай хэрхэн зохицож амьдрах вэ гэдгийг сурахаас өөр аргагүй. Учир нь бидэнд энэ дэлхийгээс өөр үхэх газар очих ертөнц үгүй билээ.

Эх сурвалж: <http://futurechallenges.org>
<http://www.nationalgeographic.com/>
<http://economix.blogs.nytimes.com>
<http://www.un.org>
<http://thewaterproject.org>
<http://utopianist.com> ■

Ногоон хөгжил

Дотоодын нийт аз жаргал

Бутан улс нь дэлхийн хамгийн өндөр уулын зүүн төгсгөлд оршдог жижигхэн орон.

1960 он хүртэл засмал замгүй, 1970-аад онд аялал жуулчлал огт хөгжөөгүй, шинэ мянган хүртэл телевизгүй байсны зэрэгцээ харилцаа холбооны сүлжээ орж ирсэн дэлхий дээрх хамгийн сүүлийн орон гэдгээрээ онцлог сонин.

Хэн бүхний харааг булаах үзэсгэлэн гоо өндөрлөг газар энд бий. Хүрээлэн буй орчин нь хайранд өлгийдүүлж халамжаар бүүвэйлүүлдэг гэмээр сайхан. Учир нь, Бутан улс байгаль хамгааллын асуудлаа аз жаргалын дөрвөн тулгуурт баганын нэгт тооцдог. Дотоодын нийт бүтээгдэхүүнээс илүү “Дотоодын нийт аз жаргалыг” эрхэмлэн авч үздэг нь энэ орны иргэдийн санаа бодол ухамсар юм. Өөрчлөлт шинэчлэлийн салхинд туугдан, урагш алхсаар яваа Бутан улс байгалийн нөөцөө хэрхэн хариуцлагатай ашиглах вэ

гэдэг асуудалд хамаг анхаарлаа хандуулж байна. Ус бол энэ орны хамгийн арвин нөөц баялгуудын нэг.

Тус улсын гол мөрөн байгалиасаа их хэмжээний эрчим хүч үйлдвэрлэх өвөрмөц хэв маягаар тогтжээ. Үүнийг цэвэр эрчим хүч ч гэж нэрлэдэг. Дэлхийн сэргээгдэх эрчим хүчний хөгжилд нэрээ гаргасан энэ орны уснаас гаргаж авдаг эрчим хүч тус улсын цахилгаан эрчим хүчний хэрэглээний амин сүнс, үндсэн эх сурвалж нь юм. Гэсэн хэдий ч өөрсдийн боломжит хүчин чадлынхаа дөнгөж тавхан хувийг одоогийн байдлаар ашиглаж байгааг мэргэжилтнүүд хэлж байна. “2020 он гэхэд бид дахин 15 усан цахилгаан станцтай болох зорилт тавин ажиллаж буй. Үүний гурвынх нь бүтээн байгуулалтын ажил хэдийнэ эхэлчихсэн бөгөөд барилга угсралтын явц маш сайн байгаа” гэж Чуха хотын “Druk Green Power” корпорацийн гүйцэтгэх инженер Тензин хэлжээ.

Бутаны хамгийн анхны усан цахилгаан станц Чуха хотод ►►



байрладаг. Усны далан дээр Буддын шашны олон бурхадын дүрийг тэр дундаа усны бурхадыг үзэсгэлэнтэйгээр урласан байдаг нь сүр жавхлан сүсэг бишрэлийг хамтад нь илтгэх ажээ. Станцын энд тэнд ямар л хоосон хана, сул зай байна түүн дээр Буддагийн амьдрал өнгө өнгийн будгаар үзэмж төгс дүрслэгдсэн байдаг. Жирийн үед нэг л уйтгартай, хүйтэн хөндий өнгө аясыг илтгэдэг цахилгаан станцын хана зургаар амилж, халуун дулаан, сэтгэл татам мэдрэмжийг төрүүлдэг нь гайхмаар.

Бутанд усны эрчим хүч том бизнес болжээ. Ер нь бол хамгийн сайн хөгжсөн нь гэж хэлж болно. Энэхүү жижигхэн орны үйлдвэрлэсэн цэвэр эрчим хүчийг Энэтхэг улс худалдан авдаг. Газар нутгийнхаа хэмжээгээр Швейцар улстай дүйцэхүйц энэ орон Калифорни мужаас ч цөөхөн хүн амтай. Дотоодын нийт бүтээгдэхүүнийх нь 60 хувь сэргээгдэх хүчнээс бүрддэг байна. “Манай улсад эрхэлж болох хамгийн тохиромжтой бизнесийн чиглэл усны эрчим хүч юм” хэмээн Бутаны Ерөнхий сайд Жигмэ Тинли CNN мэдээллийн агентлагт хэлжээ.

Экологийн хувьд Бутан улс нь Хималайн нуруунд оршдогийн хувьд ихээхэн эмзэг бүс нутаг юм. “Үнэнийг хэлэхэд бид байгальд ээлтэй, экологийн системд маш бага бүр огт хохирол үзүүлэхгүй гэдэг үүднээс л голын урсгалын тогтолцоог ашиглан эрчим хүчээ гаргаж авах сонголтыг хийсэн билээ” гэж Ерөнхий сайд нь онцлон тэмдэглэжээ. Гэхдээ хүн бүр дээрх шийдвэрийг дэмждэггүй. Тухайлбал, Засгийн газрын зөвлөх Д.Дорж “Хэтэрхий олон далан барьснаар усны амьтдад хор хөнөөл учирч болзошгүй” хэмээн ихээхэн санаа зовниж байгаагаа илэрхийлсэн байх жишээтэй. Зорилго нь зөв боловч энэ бүх зүйл маш хурдан

өрнөж байна. Бүхий л гол мөрөндөө далан барихын оронд зарим нэгийг нь ч болтугай нь унаган байгалиар нь үлдээхсэн гэж тэрбээр боддог. Гэсэн ч агаар бохирдуулдаггүй эрчим хүчний эх үүсвэр олон талын ач холбогдолтой гэдгийг бас сайн мэдэж байгаа.

Тус улсын 80 хувь нь цахилгаан эрчим хүчинд холбогдсон бөгөөд 2013 он гэхэд улс даяараа цахилгаантай болох зорилгыг тавин ажиллаж байна. Энэхүү шаардлагатай эрчим хүчийг 100 хувь уснаас гаргаж авах гэнэ. Цэвэр эрчим хүч Бутаны олон тооны иргэдийн амьдралыг өөрчилсөн. Анх 2000 онд цахилгаан гэгч зүйлийг мэдэж, мэдэрч эхэлсэн фермер Занмо “Цахилгаан байгаагүй тэр он цагт бидний амьдралын бүхий л зүйл галаас хамаардаг байсан учир ихээхэн төвөг учирдаг байлаа” хэмээн дурсан ярьж байна.

Цахилгаан эрчим хүч нь бутанчуудын хувьд амьдралын баяр баяслыг бадраасан нь илт. Будаагаа хураасны дараагаар гэр бүлээрээ өдөр шөнөгүй олон цагаар будаа цайруулах ажил хийдэг байсан бол өнөөдөр товчлуур дараад л автоматаар нүд ирэмхийн зуурт чанартай цайруулаад өгчихдөг болжээ. Занмо эрчим хүч хэрхэн бий болдгийг мэдэхгүй боловч цахилгаантай байгаадаа маш их талархаж явдаг нэгэн. Үнэндээ түүн шиг олон хүн тэдний ажил төрөл, ар гэрийн амин сүнс болсон цахилгаан голын усаар бүтээгдэж, тэдний амьдралыг гэрэлтүүлдэг гэдгийг огт төсөөлдөггүй. Занмод усны урсгал таны гэртээ хэрэглэдэг тогийг гаргаж авахад тусалдаг гэж хэлэхэд, түүний нүд маш том болж, хэсэг хугацааны дараа ийн хэлсэн билээ. “Ус цахилгаан гаргадаг гэж бид ёстой зүүдэлсэн ч үгүй явлаа. Үнэхээр итгэмээргүй юм” гэж гайхжээ.

Эх сурвалж: *Chhukha, Bhutan (CNN)* ■

RIO+20+Монгол

Тогтвортой хөгжил өөд 20 жил хамтдаа



RIO+20

United Nations Conference
on Sustainable Development

Ирэх зургадугаар сарын 20-22-нд Бразилийн Рио-Де-Жанейро хотноо зохион байгуулах НҮБ-ын “Тогтвортой хөгжил” сэдэвт дээд хэмжээний уулзалтыг угтаж Манай сэтгүүл өмнөх дугаараасаа эхлэн “Rio-20+Монгол” гэсэн байнгын буланг нээсэн билээ. Энэ удаа бид уг уулзалтад Монгол Улс хэрхэн бэлдэж байгаа болон дэлхийн тогтвортой хөгжилтэй хөл нийлүүлж чадаж байгаа юу гэдгийг сонирхлоо.

Эхлэл буюу дэлхий дахины тогтвортой хөгжил

Дэлхийн эдийн засгийн үсрэнгүй хөгжил, түүнтэй зэрэгцэн гарч ирсэн техник, технологийн хувьсал хүнд үйлдвэрлэл, хүн амын хязгааргүй хэрэглээнээс үүдэж дэлхийн дулааралтай холбоотой байгаль орчны олон асуудал гарч ирсэн. Тиймээс дэлхий нийтээр байгаль орчин, нийгэм, эдийн засгаа тогтвортойгоор хөгжүүлэх чиглэлд анхаарлаа хандуулж эхэлсэн юм. Тодорхойлж хэлбэл, тогтвортой хөгжил гэдэг нь байгаль орчин, нийгэм, эдийн засаг гэсэн гурван асуудлыг нягт хамаарал шүтэлцээтэй авч үзэж байгалийн хишиг, нөөц, баялаг өгөөжийг зүй зохистой ашиглан, өнөө болон хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээхийн төлөө нийгмийг бүтээн байгуулах гэсэн утгыг илэрхийлдэг байна. Үүний эхлэл бол НҮБ-аас 1992 онд Бразилийн Рио-Де-Жанейро хотноо зохион байгуулсан “Байгаль орчин ба хөгжил” сэдэвт тогтвортой хөгжлийн дэлхийн чиг хандлага болон нийт үндэстэн бүрийн хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлсон явдал юм. Ийнхүү тус хурлаас дэлхий нийтээр 20 жилийн турш дагаж мөрдөж буй “Дэлхий дахины XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийг батлан гаргасан аж. Хөтөлбөрт нийгэм, эдийн засгийн асуудал, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хүрээлэн буй орчны асуудал, нийгмийн үндсэн бүлгүүдийн хамгааллыг дээшлүүлэх нь, тогтвортой хөгжлийн тогтолцоог хэрэгжүүлэх арга хэрэгслүүд гэсэн үндсэн дөрвөн бүлгийг улс орнуудад тогтоон өгсөн аж. Үүний дагуу улс орнууд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр XXI зууны хөгжлийн хөтөлбөрөө боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг даалгаврыг хүлээн авсан байна. НҮБ-аас “Дэлхий дахины XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр бол бодит үйл явц бөгөөд тогтвортой хөгжлийн үндэсний стратегийн тулгын чулуу мөн. Тиймээс нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван салбараа уялдуулан удирдаж сурснаар бид уламжлалт арга барилаа орхиж чадна гэж үзжээ.

Рио+20 буюу алдаа оноогоо цэгнэх мөч

1992 онд Бразилийн Рио-Де-Жанейро хотноо болсон “Байгаль орчин ба хөгжил” сэдэвт хуралд тухайн үеийн Монгол Улсын Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн тэргүүтэй төлөөлөгчид оролцсон аж. Тэд улс орныхоо тухайн үеийн нөхцөл байдлыг дэлхий дахины сонорт хүргэн, даянд дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл санаанд нэгдэж буйгаа илэрхийлсэн түүхтэй. Ийнхүү Монгол Улс Рио-гийн байгаль орчны тунхаглалд нэгдэн, 1998 онд тогтвортой хөгжлийн үндэсний стратегийг боловсруулан,

Засгийн газраас баталжээ. Өөрөөр хэлбэл, манайх энэ цаг мөчөөс нийгэм, эдийн засгийн голлох салбарууддаа тогтвортой хөгжлийн үзэл санааг тусган ажиллаж ирсэн тухай албаны хүмүүс хэлж байна. Энэ талаар 20 жилийн хугацаанд манай улс тогтвортой хөгжлийн бодлогоо ямар чиглэлд түлхүү хандуулж ирсэн талаар БОАЖЯ-ны Тогтвортой хөгжил, стратеги төлөвлөлтийн газрын дарга Ц.Банзрагчаас сонирхлоо. Тэрбээр “НҮБ-аас тогтвортой хөгжлийн дөрвөн чиглэлийг тогтоосон байдаг. Үүнд эрчим хүч, хүнс хөдөө аж ахуй, байгаль орчин, дэд бүтэц багтаж байгаа юм. Манай улс тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрөө гаргаснаас хойш дээрх салбаруудад уг үзэл санааг түлхүү тусгахыг зорьж ирсэн. Тухайлбал, байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт, хэрэглээг эдийн засаг нийгмийн бодлоготой уялдуулах, тухайлбал ногоон өсөлт, экологийн хувьд үр ашигтай байх зарчмыг бодлогодоо тусгасан” хэмээн хариуллаа.

Ийнхүү манай улс 20 жилийн турш хэрэгжүүлсэн Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийнхөө хэрэгжилт, үр дүнг ирэх зургадугаар сард Рио-Де-Жанейро хотноо болох Рио+20 дээд хэмжээний уулзалтын үеэр тайлагнаж, ойрын жилийнхээ тогтвортой хөгжлийн хандлага, чиг баримжаагаа энэ үеэр тогтоож авахаараа ихээхэн ач холбогдолтой гэдгийг холбогдох хүмүүс дурдлаа.

Монгол Улс “Рио+20”-д хэрхэн бэлдэж байна вэ

1992 оноос хойших 20 жилийн хугацаанд Монгол Улс Тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрийн дагуу юу хийж бүтээсэн, ямар үр дүнд хүрсэн талаар цаашид юуг анхаарах талаар Ц.Банзрагч дарга “Ирэх гуравдугаар сар гэхэд тайлангаа нэгтгэн дүгнэж, “Рио+20” уулзалтаас өмнө буюу зургадугаар сард эцсийн байдлаар бүрэн гүйцэд хийж дуусгана” гэж онцоллоо.

“Рио+20” уулзалт нь улс орнуудын тогтвортой хөгжлийн чиг баримжааг илүү тодорхой болгох, олон улсын тогтвортой хөгжлийн бодлогын чиг баримжааг гаргахаараа маш өндөр ач холбогдолтой гэдгийг НҮБ-аас онцолсон аж. Тус уулзалтаар нэгдүгээрт, тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах хүрээний ногоон эдийн засаг, хоёрдугаарт, тогтвортой хөгжил засаглалыг бэхжүүлэх чиглэлийг голлон анхаарч хэлэлцэх юм байна.

Манай улс Рио+20 уулзалтын бэлтгэл болгож ирэх сарын сүүлчээр улсын хэмжээний тогтвортой хөгжлийн чуулга уулзалтыг зохион байгуулах аж. Энэ үеэр тайлангаа хэлэлцүүлэхийн зэрэгцээ холбогдох хүмүүсийн санал бодлыг сонсох юм байна. Ингэснээр Монгол Улс Рио+20 уулзалтад ямар байр суурьтай оролцож, юуг анхаарах вэ гэдгээ тодорхой болгох гэнэ. Нэг үгээр хэлбэл, Рио+20 уулзалтад манай улс оролцоходоо, тогтвортой хөгжлийг өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монголын хөрсөнд хэрхэн нутагшуулсан байдалдаа бусад оронтой зэрэгцэж дүн тавиулана гэсэн үг. Түүнчлэн ирэх он жилүүдэд анхаарах төлөв чиглэлээ гаргахаараа ихээхэн ач холбогдолтой юм байна. ■

Нөхөн сэргээлт

Уурхайн цогц нөхөн сэргээлт: Эрээний уурхай ногоон бүс

Булган аймгийн Сайхан сумын нутаг дахь Эрээний нүүрсний уурхай байсан газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж, өвс ургамал бүхий эрүүл газар болгосон байна. Энэхүү нөхөн сэргээлтийн цогц арга хэмжээг “Пийбоди Энержи” компани дэлхийн өнцөг булан бүрт явуулдаг уул уурхайн үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байгаль орчны шилдэг стандартыг Монголд нэвтрүүлэх үүднээс “Пийбоди-Винсвэй Ресорсез” компани болон Монголын холбогдох байгууллагууд, мэргэжилтнүүдтэй хамтран гүйцэтгэжээ. Нөхөн сэргээлтийн энэхүү цогц арга хэмжээ нь Монгол Улсын хувьд ийм төрлийн анхны төсөл байсан бөгөөд нөхөн сэргээлтийн явцад үрсэлгээ хийж үүнээс хойш ганцхан жилийн дараа туршилтын журмаар хадлан авсан нь амжилттай болсон байна.

Өчигдөр

Одоогоос хоёр жилийн өмнө буюу 2010 оны есдүгээр сард “Уул уурхайн салбар дахь байгаль орчны нөхөн сэргээлт” тавдугаар үзүүлэх сургалт Булган аймагт болохоор товлогдож, тэндээс сурвалжлага бэлтгэв. Ашигт малтмалын газар, МХЕГ-ын Газрын байгаль орчны хяналтын улсын болон орон нутгийн байцаагч, уул уурхайн компанийн төлөөлөгч гээд 300 гаруй зочидтой улсын хэмжээний томоохон үзүүлэх сургалт болсон юм.

Булган аймгийн Сайхан сумын нутагт буй Эрээний уурхайн нөхөн сэргээлттэй танилцаж, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг шимтэн үзэж явлаа. Уурхайн хаалт гэхээр л харанхуй нүх, овоолсон шороо, сэвтсэн хөрс, сэргэж чадахааргүй болсон уул хөндий нүдэнд буудаг гэмтэй. Харин энэ бодол бараг л 360 градус өөрчлөгдсөн шүү. Уул уурхайн нөхөн сэргээлтийн талаарх хүн бүрийн төсөөллийг орвонгоор нь эргүүлж чадсан уул уурхайн компанийнхан бол “Пийбоди Энержи” болон түүний Монгол дахь хамтарсан компани болох “Пийбоди-Винсвэй Ресорсез”.

Уул уурхайн компанийн 300 гаруй



төлөөлөгчийн нүдэнд булаг, цөөрөм, бутлаг ургамал хамгийн түрүүнд буусан. Буух буухдаа үерийн хамгаалалт, ус зайлуулах хоолойтой нь төгс шийджээ. Хамгийн тод санагдаж байна, нөхөн сэргээлтийн гаднах талбайд үхэр бэлчээрлэж, энүүхэнд нь хаяа нийлэн малчин айл намаржиж байсан юм. Уул уурхай, хөдөө аж ахуй ийн зохицжээ.

Энэхүү нөхөн сэргээлтийн явцын үр дүнг сэтгүүлчдэд уурхайн дарга Б.Батмөнх танилцуулсан. Тухайн үед 15 га-д нь техникийн нөхөн сэргээлт, 18 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай өдгөө танигдахын аргагүй. Түүнчлэн ногоон бүтээн байгуулалт хийжээ. Орон нутгийн иргэдээс санал асуулга авч уурхайн хоосон орон зайд газрын хөрсний үе давхаргын дагуу системтэйгээр хөрсний дүүргэлт хийн үржил шимтэй хөрсөөр хучсан байв.

“Биологийн нөхөн сэргээлт бүрэн дууссаны дараа энэхүү талбай нь малын бэлчээр болно. Худаг, цөөрөм тавьсан энэ талбайд дөрвөн нэр төрлийн өвсний үр суулгасан” хэмээн тайлбарлаж байв. Мониторингийн тогтмол судалгаа явуулж, усны чанар, ургамлын шим, хөрсний чанарыг шалгана хэмээн 2010 оны есдүгээр сард хэлснийг тэмдэглэж явлаа. Нөхөн сэргээлтийн жилд 1,5 тэрбум төгрөгийн

хөрөнгө оруулалт хийснээ хэлж байв. Энэхүү өгүүлж буй нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа хоёр жилийн өмнөх үйл явдлын түүх шүү дээ. Харин одоо нөхөн сэргээлт үргэлжилжээ. Хоёр жилийн өмнө хийсэн гээд тэд энэ чигт нь үлдээгээгүй байгаа нь бусдад жишээ болохуйц жишиг юм уу даа.

Техникийн нөхөн сэргээлтийн талбайд 0.33 литр ус гүний усны ундаргатай худаг, 238 ам метр талбай бүхий жижиг цөөрөм бий. Худгийг өмнө нь зөвхөн дулааны улиралд хэрэглэдэг байсан бол өнгөрсөн онд орон нутгийн малчдын хүсэлтээр өвлийн улиралд ашиглах боломжтой болгожээ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд заасан долоон зорилтоо амжилттай хэрэгжүүлсэн байна. Энэхүү нөхөн сэргээлтийн төсөл нь 2011 онд MINING JOURNAL-аас зохион байгуулсан шилдэг ECO уурхай номинацид шалгарчээ. Товчоор хэлбэл уг нөхөн сэргээлтийн төсөл нь манай улсын хувьд уул уурхайн анхны ногоон төсөл гэж хэлж болно.

Өнөөдөр

Нөхөн сэргээлт нь байгаль өөрийн жамаар нөхөгдөх процессийг хурдасгаж буй нэг ёсны арга хэмжээ. Төслийг ▶

► гүйцэтгэгч багийнхны дүгнэлтээр Эрээний уурхайн нөхөн сэргээлт урьдчилан төлөвлөж байснаас хамаагүй хурдан нөхөн сэргээгдэж байгаа юм байна. Өнгөрсөн онд нөхөн сэргээсэн талбайгаас туршилтын байдлаар хадлан авч үзэхэд нэг га талбайгаас 8.5 тонн хадлан авсан бол хажуу талд нь байгаа жирийн талбайгаас хоёр тонн хадлан авчээ. Өөрөөр хэлбэл даруй дөрөв дахин илүү гарцтай байна. Мөн нөхөн сэргээсэн талбайд тарвага, туулай, жирх, зурам зэргээс гадна олон төрлийн шувуу үүрээ засаад, үдлэх болж. Төслийн баг энэ онд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шувуу болон жижиг хөхтөн амьтдын судалгаа хийлгэхээр төлөвлөөд байгаа ажээ.

Уул уурхайн нөхөн сэргээлтийг уурхайн төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлэх ихээхэн үр дүнтэй байдгийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн. Компанийнхан нөхөн сэргээлтийн санг тухайн жилийн нийт үйл ажиллагааныхаа зардлын төсөвт тусгадаг ажээ. Эрээний

уурхайн техникийн нөхөн сэргээлтэд ойролцоогоор нэг га-д 55 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтэд нэг га-д 17 саяыг тус тус зарцуулжээ. Харин орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нэг га-д ногдох зардал нь 2.5 сая төгрөг болж байгаа юм. Төслийн баг саяхан усны хоолойн аманд хунгарласан цасыг цэвэрлэхээр яваад иржээ.

Маргааш

Уурхай хаагдсан ч заавал хийх ёстой ажил бол нөхөн сэргээлт болохыг хэн хүнгүй мэднэ. Харин мөрдөж буй нь даан ч хомсхон. Энэ буруу зуршлийг өөрчлөх дэлхийн жишгээр үйл ажиллагаа явуулж буй “Пийбоди Энержи” компанийн санаачилсан нөхөн сэргээлтийг хэрэгжүүлэх төслийн баг маргааш нөхөн сэргээлтийн талбайдаа юу хийх вэ? Тэднийх орон нутгийн иргэдтэй хамтран ажиллахад нэлээд ач холбогдол өгдөг бөгөөд сайн түншлэлийн харилцааг бий болгох нь тэдний ажлын амжилт гэж үздэг. Орон нутгийнхан сэтгэл хангалуун, иргэний

хөдөлгөөнийхөн ч жишээ авч ярьж яваа хэчнээн уул уурхайн компани манайд бий билээ?

“Пийбоди Энержи” компанийн ТУЗ-ийн дарга бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал Грегори Бойс “Пийбоди Энержи компани тогтвортой хөгжлийн загварыг бий болгох байгаль орчны шилдэг стандартыг Монголд нэвтрүүлж байгаадаа бахархалтай байна. Бидний эрхэм зорилго бол уурхайн эдэлбэр газрыг наад зах нь өмнө байсантай нь адил, цаашилбал илүү сайжирсан байдалтайгаар хүлээлгэн өгөх явдал юм. Бид өндөр мэргэжлийн, чадварлаг багтай бөгөөд тэдний гүйцэтгэсэн нөхөн сэргээлтийн ажлууд дэлхийн өнцөг бүрт сайшаагддаг” хэмээн ярьсан юм.

“Пийбоди Энержи” компанийн тухайд дэлхийн хэмжээнд уурхайн эдэлбэр байсан нийт таван мянга гаруй акр талбайд нөхөн сэргээлт хийж, хагас сая гаруй модыг суулгасан бөгөөд 2010 онд газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтэд нийтдээ 245 сая ам.долларыг зарцуулжээ. ■



Л. Төр-Од

/Ногоон эдийн засгийн өсөлт ТББ-ын Удирдах Зөвлөлийн гишүүн/

-Та ногоон хөгжлийг юу гэж бодож байна?

Маш тодорхой бөгөөд товч хариулбал “ногоон” буюу байгальд ээлтэй, хүрээлэн буй орчинд халгүй эдийн засгийн өсөлтөөс өөр хөгжлийн загвар хувилбар нийт дэлхийн улс орнуудад огт байхгүй болоод байна. Учир нь сүүлийн арван хорин жил үргэлжилж буй цаг уурын өөрчлөлт, хоол хүнсний хомсдол, эдийн засаг ба санхүүгийн хямралууд ихэнх улс орнуудад хөгжлийн альтернатив загвар илэрхийлэхэд шууд түлхэц өгч, эх дэлхий эко-системийг хамгаалаад зогсохгүй, ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бодитой бууруулахад ногоон эдийн засагт шилжихээс өөр замнал байхгүйг харууллаа.

-Ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд ухамсрыг олон нийтийн дунд юу бий болгох вэ?

Цаг уурын өөрчлөлтийг зогсоож, байгаль орчноо хайрлан хамгаалах, агаар бус хөрсний бохирдлыг багасгах гол хүчин зүйл нь “ногоон” эдийн засгийг хөгжүүлэх, ийнхүү ойлголт ухамсрыг ахуйн түвшнүүд

ард иргэд, олон нийтийн дунд суртчилан таниулах, соён гэгээрүүлэх ажлын зохион байгуулах хэрэгтэй. Энэ нь хамгийн энгийн зүйл болох хувь хүний үр ашиггүй хэрэглээг багасгах, хүлэмжийн хийг хамгийн их үүсгэж буй амьтны гаралтай хүнс бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бууруулах, улмаар цагаан болон ногоон хоолтны төлөв рүү эргэн орох нь хүмүүн төрөлхтөний байгалийн жам ёсны ирээдүй гэж хувь хүний хувьд үзэж байна.

-“Ногоон эдийн засгийн өсөлт” ТББ-т ямар үүрэг оролцоо байх вэ?

Манай байгууллагын хувьд хоёр үндсэн ажиллагааны чиглэл нь олон нийтийн ногоон эдийн засгийн талаар ерөнхий ойлголт өгөх, тайлбарлан таниулах, соён гэгээрүүлэх нөгөөтэйгүүр эрдэмтэн судлаачид, шинжээч мэргэжилтний түвшинд “хүрэн” эдийн засгаас “ногоон” эдийн засаг руу шилжих таатай орчныг хэрхэн яаж бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, хэлэлцүүлэг өрнүүлэн шийдэл гаргахад туслах явдал юм.



Сэргээгдэх эрчим хүч

Монголд сэргээгдэх эрчим хүчний төсөл хэрэгжүүлэх сонирхолтой байна

“Женерал Электрик” компанийн дэд Ерөнхийлөгч Жон Райсыг Монголд ирж, “Салхит” салхины станцын техник тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээнд гарын үсэг зурах үеэр уулзаж ярилцсан юм.

-Монголд сэргээгдэх эрчим хүчний салбар хөгжих боломжийг Та хэрхэн харж байна вэ?

-Өнгөрсөн жил Нью Йорк хотноо болсон НҮБ-ын Ерөнхий ассамблейн чуулганы үеэр би Монгол Улсын Ерөнхий сайдтай уулзсан юм. Үүний дараагаар Монгол Улсад анх ирсэн. Танай орны Ерөнхий сайдтай уулзаад, Монголд салхин парк байгуулах талаар санал солилцож байсан минь ердөө нэгхэн жилийн дараа бодит ажил хэрэг болж, томоохон гэрээнд гарын үсэг зурсан маань туйлын сайхан хэрэг. Монголд салхины станц байгуулах гэж байна. Энэхүү төсөл бүрэн хэрэгжсэнээр Монгол Улс нийт цахилгааныхаа таван хувийг сэргээгдэх эрчим хүчний салбарын технологиор үйлдвэрлэх боломжтой. Энэ боломж ирэх оны

эцсээр бий болох юм. “Женерал Электрик”, “Ньюком”-ын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй “Салхит” салхины станц ирэх оны есөөс арванхоёрдугаар сарын хугацаанд үйл ажиллагаагаа эхлүүлнэ гэж үзэж байна.

Бүх зүйл маш богино хугацаанд хэрэгжиж байна. Төсөл хэрэгжих гэж байхад өргөтгөлийн тухай яриад эхэлчихсэн.

Монголын өмнөд хэсгээр, ялангуяа говийн нутгаар салхины хурдны үзүүлэлт ихээхэн сонирхол татам гарсан. Тиймээс бид Монголд салхины станцын төсөл хэрэгжүүлж, хөрөнгө оруулах сонирхолтой байгаа.

-Монголд өөр ямар салбаруудад төсөл хэрэгжүүлэх сонирхолтой байгаа вэ?

-Салхины эрчим хүчнээс гадна био түлш, сэргээгдэх салбарт тооцогддог бусад технологийг хөгжүүлэх сонирхолтой байгаа. Нүүрснээс метан гаргах, үүгээр цахилгаан эрчим хүч гаргах талаар Монголын удирдах түвшний хүмүүстэй санал солилцоно гэж төлөвлөж байгаа.

Мөн нарны эрчим хүч, цахилгаан хуримтлуулах технологи, төмөр зам, нисэх онгоц, тийрэлтэт хөдөлгүүр зэрэг олон чиглэлд хамтран ажиллах боломж байна гэж боддог.

-Монголын эрс тэс уур амьсгалтай нөхцөлд томоохон хэмжээний салхин турбин ажиллахад хүндрэл учирч мэдэх юм. Та юу гэж үзэж байна вэ?

-Монгол орны эрс тэс уур амьсгалд манай технологи зохицоно гэдэгт би бүрэн итгэлтэй байна. Монголчуудтай хамтран ажиллаж буйн гол давуу тал нь бидний энэ салбарт зүтгэсэн 30-аад жилийн туршлага юм. Ийм чиглэлээр 4-5 жил үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд бий. Гэхдээ тэдний технологи танай өвлийн улирлыг давж чадах уу гэдэг нь асуудалтай. Хоёрдугаарт, “Женерал Электрик”-ийн салхин турбин 15-20 жилийн турш найдвартай ажиллана. Хямд үнэтэй төхөөрөмж сонгосноор 4-5 жилийн дараа хэрэглэгч нь харамсах тохиолдол бий.

-Салхины эрчим хүчний төслийн хувьд өөр ямар нэгэн эрсдэл харж байна уу? ▶

► -Би өөр эрсдэл олж харахгүй байна. Тухайн төслийн технологийг цаг хугацаанд нийлүүлэх нь чухал. Манай нийлүүлэлтийн сүлжээ маш сайн ажилладаг.

-Монгол Улс эдийн засгийн өндөр өсөлттэй явж байна. Энэ талд таны бодлыг сонсоё?

-Хэрвээ та нар өөр өндөр хөгжилтэй улсын жишээг харах юм бол бүх улсад хөгжлийн замд нь тодорхой бэрхшээлүүд учирсан байдаг. Тухайлбал, байгаль орчны хэтийн төлөв, зам тээвэр, хүн амын шилжин суурьшигтай холбоотой асуудлуудыг хэлж болно. Монгол орны хувьд гол асуудал нь төрийн удирдлагууд эдийн засгийн энэхүү өсөлтийг үр дүнтэй зарцуулж чадах уу гэдэгт чиглэж байна гэж бодож байна. Миний бодлоор хариулт нь "Тийм". Танай төр, засгийн удирдлагууд эдийн засгийн өсөлтийг ард түмэндээ ашигтайгаар зарцуулж чадна гэж бодож байна. Гэхдээ ямар ч хөгжлийн замд бэрхшээл тулгардаг юм.

-Танай компанийн хамгийн сүүлийн үеийн технологийн ололтоосоо хуваалцахгүй юу?

-Бид нэг бүр нь 3 МВт-ын цахилгаан үйлдвэрлэх хүчин чадалтай салхин турбин үйлдвэрлэхээр зорьж ажиллаж байна. Салхин турбины технологийн тухайд гэвэл, турбины байрлалыг зөв тааруулах нь чухал байдаг. Далбан урт байх тусам илүү их эрчим хүч үйлдвэрлэнэ. Одоогоор салхин турбинд суурилуулж буй 50 метрийн урттай далбан хамгийн уртад тооцогдож буй. Энэ салбарт ажиллаж буй байгууллагуудын хувьд далбангийн бүтэц, хэмжээ, турбины аюулгүй болон урт хугацааны ажиллагааг сайжруулах нь хамгийн том шалгуур байдаг юм.

-2050 он гэхэд дэлхийн эрчим хүчний эрэлтийн 80 хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангах тухай НҮБ-ын нэгэн тайланд дурдсаныг та хэр боломжтой зүйл гэж үзэж байна вэ?

-Энэ бол тун түрэмгий шинжтэй тайлан болсон. Өнөөдөр дэлхийн эрчим хүчний 50 хувийг нүүрсний салбар түшиглэн хангаж байна. Хэрэв НҮБ-ын илтгэл дэх зорилгод хүрье гэвэл одоо ажиллаж, бүх нүүрсний цахилгаан станцыг нар, салхины сэргээгдэх эрчим хүчний технологиор солино гэсэн үг. Харин үүний оронд нүүрсийг яаж аль болохоор байгаль орчинд нөлөөлөл багатай хэлбэрээр ашиглах вэ гэдэг тал дээр анхаарал хандуулах хэрэгтэй.

-АНУ-ын Байгаль хамгаалах агентлаг агаарын чанарын стандартыг сайжруулах зорилтыг ойрын таван жилд энэ улсын олон ДЦС хаагдахаар

болоод байна. Энэ талд таны бодол?

-Ойрын жилүүдэд АНУ-ын цахилгаан станцууд хаагдчихна гэж харахгүй байна. Харин ДЦС-ууд хорт бодисын ялгаруулалтынхаа хэмжээг багасгах технологийг нэвтрүүлэх ажлыг илүү хэрэгжүүлэх байх. Миний харж буй асуудал гэвэл цөмийн цахилгааны салбартай хамаатай. Одоо АНУ-ын эрчим хүчний нийлүүлэлтийн 17 хувийг цөмийн эрчим хүчний салбар үйлдвэрлэж байна. Тодруулбал, 100 орчим реактор ажиллаж байна. Одоо ажиллаж буй реакторууд 2040 он гэхэд 60 жил ажилласан байх болно. Тухайн үед эдгээр реакторыг солих эсвэл зогсоох хэрэгтэй болно. Өнөөдрийн тооцоогоор одооноос эхлэн 2040 он хүртэл жилд гурван реактор барьж байж ирээдүйд хаагдах эдгээр реакторын орон зайг нөхөх тооцоо гарч байгаа юм. Гэвч Америкт энэ үйл

ажиллагаа хэрэгжихгүй байна. Тиймээс бидний хувьд хийн түлш, нүүрсийг ээлтэйгээр ашиглах болон сэргээгдэх эрчим хүчний технологийг онцгойлон анхаарах хэрэгтэй болж байгаа юм.

-ДЦС-уудад шатааж буй нүүрсний шаталтаас ялгарах нүүрсхүчлийн хийг багасгах CCS технологийг дэлхийн улс орнууд хөгжүүлж байна. Таны хувьд энэ технологийг юу гэж үздэг вэ?

-Техникийн хувьд энэхүү технологи нь бүрэн боломжтой. Нэг асуудал байгаа нь өртгийн асуудал. Нүүрсний шаталтаас ялгарах нүүрсхүчлийн хийг ангилан ялгаж технологийн хувьд бүгд боломжтой. Гэвч энэ боловсруулах үйл явцын өртөг нь өндөр болоод байгаа юм. Бас нэг асуудал нь ДЦС-аас ялгарч буй нүүрсхүчлийн хийг газар дор хэр зэрэг удаан хадгалж болох вэ гэдэг нь асуудал байгаа юм. ■

Сурталчилгаа

Дэлхийн шилдэг Делойтт компани Монгол Улсад үйл ажиллагаагаа эхэллээ

Үндэсний шилдэг аудитын компани Онч-Аудит ХХК нь Делойтт Туш Тохмацу Лимитед компанийн Монгол дахь гишүүн болох гэрээнд гарын үсэг зурлаа.

Делойтт Онч компани нь 2012 оны нэгдүгээр сарын 1-нээс үйл ажиллагаагаа эхэлсэн ба Онч-Аудит ХХК-ийг үүсгэн байгуулагч Дэндэвсамбуугийн Ончинсүрэн манлайлан удирдах болно.

Делойтт Онч нь дэлхий дээрх хамгийн хурдан өсч буй эдийн засагтай Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагууд, харилцагчиддаа аудит, татвар, бизнес санхүүгийн зөвлөх үйлчилгээг багтаасан нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн иж бүрэн үйлчилгээг дэлхийн стандартын түвшинд хүргэх болно. Делойтт Онч нь одоогоор 50 шахам мэргэжлийн боловсон хүчинтэй бөгөөд Их Британи, Канадын арвин их туршлагатай мэргэжилтнүүд хамтран ажиллаж байна.

"Делойтт"-ийн гишүүн компани болсноор Делойтт Онч ХХК нь дэлхийн 150 гаруй оронд салбартай, "Делойтт"-ийн 182,000 гаруй боловсон хүчний нөөцтэй холбогдож байгаа юм. Делойтт Онч ХХК нь Монгол Улсын хурдтай өсч буй салбаруудад ялангуяа эрчим хүч, байгалийн баялгийн салбарт амжилттай ажиллах нөөц бололцоотой болж байна. Делойтт нь уул уурхайн салбар хөгжсөн орон бүрийн туршлагатай боловсон хүчнийг нэгтгэсэн Дэлхийн уул уурхайн салбарын баг ажиллуулдаг ба манай уул уурхайн компаниуд тэдний үнэ цэнэтэй туршлага, мэдлэгээс хүртэх хуваалцах бололцоотой боллоо.

"Делойтт"-ийн Монгол дахь гишүүн компани болсноор бид маш их баяртай байна. Дэлхийн жишигт нийцсэн үйлчилгээ, шинэ санаачилга, ёс зүйгээрээ дэлхийд танигдсан байгууллагад элсэж байгаадаа маш их бахархаж байна. Эрхэм харилцагчид та бүхэнд өөрсдийн мэдлэг, туршлагаа үргэлжлүүлэн хүргэхийн зэрэгцээ дэлхийн хэмжээний боловсон хүчний нөөц дэмжлэгтэйгээр та бүхний хүлээлтийг давуулан биелүүлсээр байх болно гэж Д.Ончинсүрэн захирал тэмдэглэж байна.

Зөвлөгөө

Та үүнийг мэдэх үү ?

Жил црэх тусам дэлхийн усны нөөц хомсдож, бохирдсоор байгааг эрдэмтэд сануулдаг. Хүн бүхэн дор бүрнээ усаа ариг гамтай хэрэглэж сурвал таны ирээдүйдээ хийж буй томоохон хөрөнгө оруулалт болох юм. Тиймээс одооноос дараах зөвлөмжийг өдөр тутмын амьдрал ахуйдаа мөрдөөрэй.

Гэртээ:

1. Ус дулаад салдаггүй цорго болон хоолойг засах. Секундэд нэг дусал ус гоожих нь жилд 9000 литр усны алдагдахад хүргэдэг байна
2. Мөн шүршүүрийн толгой, суултуурын татуурга зэрэгтээ байнга анхаарал хандуулах хэрэгтэй. Усны цоргонд тохируулагч суурилуулахад гэмгүй. Ус тохируулагч нь усны хэрэглээг 60 хувь хүртэл бууруулдаг
3. Усаа хүйтэн болохыг нь хүлээн, гоожуулж зогсохын оронд хөргөгчинд хөргөөж болох мэргэн санаа өвөртөл
4. Шүдээ угааж байх үедээ цоргоо хааж бай
5. Усаа гоожуулж аяга тавгаа цоргон дор барьж угаахын оронд угаалтуураа усаар дүүргэн угаа
6. Аяга тавгаг угаагч, угаалгын машинаа угаах зүйлээр дүүрсэн үед л ажиллуулж байх

Гадаа:

1. Бараг бохирдоогүй эсвэл бага зэрэг хэрэглэсэн усыг бусад зорилгоор ашиглах боломжтой байдаг. Усаа гоожуулж халуун болохыг хүлээх зуураа хувин сав тосож цэцэг ногоо услах усаа тосон авч болно. Мөн өөрсдийн хэрэглэж байсан уух юмныхаа үлдэгдэл, өндөг, гоймон гэх мэт зүйлийг болгоход хэрэглэсэн усаар гадаах ургамал ногоогоо услахад ч хэрэглэж болно.
2. Зам талбай цэвэрлэхдээ ус биш шүүр хэрэглэх.
3. Машинаа угаахдаа хувинтай ус ашиглах эсвэл цэвэр усаар шүрших хүртлээ усны хоолойгоо хаах
4. Ус бага ордог эсвэл унаган байгалиараа ургамлын төрөл зүйл тарих
5. Ижил хэмжээнд ус хэрэглэдэг цэцэг ногоог сонгон тарих
6. Зүлэг ногоогоо өглөө эрт эсвэл үдшийн бүрийгээр услах

Эх сурвалж: -Абби Типтон
<http://ngm.nationalgeographic.com>



Гэр бүлийн хүрээнд

Бид шүд угаахдаа зарцуулах усны хэмжээгээ хэрхэн хэмнэж чадах вэ?

Усны цоргыг хаалгүйгээр нэг удаа шүдээ угаахад дунджаар 5-10 литр ус зарцуулдаг гээд бод доо. Хэрвээ та усаа шилэн аяганд хийж шүдээ арчилбал 250-500 грамм ус буюу жилд 90-180 гаруй литр, 10 жилд 900-2000 орчим литр усыг хэмнэх аж. Ингэснээр та ус болон мөнгөө ч хэмнэх боломжтой.

Харин нэг удаа ариун цэвэр сахихад хэдий хэмжээний ус зарцуулдаг бол?

Эрдэмтдийн судалгаагаар хүн баннаа дүүргэж биеэ угаахад 150-180 литр ус зарцуулдаг бол 15 минут шүршүүрт ороход 200-250 литр ус ашигладаг байна. Тиймээс хүн бүр дор бүрнээ биеэ савандаж байх үедээ усаа хааж занших хэрэгтэй юм. Ингэснээр хоёр дахин бага буюу 100-125 литр ус хэмнэж чадна.

Тэгвэл аяга тавгаа хэчнээн хэмжээний усаар угаадаг вэ?

Бохир аяга, тавгаг, сав суулгыг ойролцоогоор 10 минут крантаа хаалгүйгээр угаахад 43 литр ус зарцуулдаг гэнэ. Хэрвээ угаалгын шингэн ашиглах үедээ крантаа хааж, цэвэр усаар зайлахдаа усаа гоожуулбал 25 орчим литр ус хэмнэх боломжтой юм.

Авто машинаа цэвэр байлгахад хэдэн литр ус шаардагддаг вэ?

Авто машиныг даралттай усаар угаахад цагт 500 литр, ус зөөж угаахад 50 литр ус зарцуулагддаг байна. Машинаа бохирдсон үед нь даралттай усаар угаалгахаас татгалзаарай.

Эдгээр зөвлөгөөг зочид буудлынхан хамгийн түрүүнд хэрэгжүүлж хэвшүүлбэл үрдүн сайтай. Жишээлбэл, “Зочин та шүдээ угаахдаа зориулалтын шилэн аяганд усаа хийж угаана уу”, “Зочин та биеэ савандаж байх үедээ усаа хаахаа бүү мартаарай” гэх мэт бичгийг хэрэгтэй гэж үзсэн газраа наагаарай. ■



Уншигчийн булан

Ж.Жаргалсайхан /Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын орлогч дарга/:

- Сүүлийн жилүүдэд манай улсын эдийн засаг өндөр өсөлттэй болж, “халуун” сэдвийн нэг болсоор байгаа. Нөгөө талаас малчны хотноос эхлээд иргэн бүр л энэ чиглэлийн мэдээллийг сонирхож, чих тавин анзаарах болсон. Энэхүү орон зайг нөхөж, та бүхэн эдийн засгийн төрөл бүрийн нарийн чимхлүүр мэдээлэл сайтай, энгийн, уншууртай сэтгүүл гаргаж байгаад уншигчийнхаа хувьд их талархаж, баярлан хүлээн авч байгаа билээ.Түүнчлэн өнгө дизайн сайтай, график,

хүснэгт ашиглаж мэдээллийг цогцоор нь хүргэж байгаа нь энэ их мэдээллийн эрин зуунтай хөл нийлүүлэн алхах боломжийг олгож байгаа гэж хэлж болно. Одоогоор манайд эдийн засгийн чиглэлийн мэргэшсэн сэтгүүл танайхаас өөр байхгүй байх шиг анзаарагддаг. Тиймээс эдийн засгийн мэдээ мэдээлэл, нийтлэлийг илүү боловсронгуй, мэдээлэл судалгаа сайтай, энгийн хялбаршуулсан хэлбэрээр олон нийтэд хүргэх үүрэг одоогоор та бүхэнд байна гэж бодож байна.

С. Ганбаатар**/МУЭХ-ны ерөнхийлөгч/:**

-Эдийн засгийн их өсөлтийн энэ цаг үеийг соргоогоор мэдэрч, зайлшгүй шаардлагатай байсан орон зайг нөхөж гарч ирсэн та бүхэнд юун түүрүүнд баяр хүргэе. Өнөөдөр эдийн засгийн цаг үеийн бодитой мэдээ мэдээлэл жирийн худалдаачнаас эхлээд төрийн эрх баригчдад хүртэл зайлшгүй шаардлагатай байгаа юм. Ялангуяа ард иргэд, өрх гэрийн цаашлаад улс орныхоо эдийн засаг, төсөв мөнгөний асуудал, хувьцаа, цалин, тэтгэвэр зэргийн ач холбогдол

нарийн учрыг нь сайн ойлгож, ухаарч байж амьдралаа зөв зүйтэй залж, өөд нь татах үүд нээгдэх учиртай.Тиймээс мэргэжлийн түвшинд мэдээлэл, үндэслэл сайтай эдийн засгийн болон улс орны чухал асуудлуудыг хөндөн гаргаж байгаад уншигчийн хувьд их баяртай байна.

Мөн танай сэтгүүлийг 14 хоног тутмынх болж байгаа гэж сонссон. Тиймээс мэдээллээ илүү чанаржуулж, түргэн шуурхай хүргэж байгаарай гэж хүсье.

Э.Одбаяр**/МХБ-ийн Хэвлэл мэдээллийн албаны менежер/:**

“Mongolian Economy” сэтгүүлийн байнгын уншигчийн хувьд сэтгэгдлээ илэрхийлэхэд, нийтлэлийн бодлого болоод нийтлэгдэж байгаа материалын агуулга, чанарын хувьд ч таалагддаг. Өнөөдөр монголчуудад ямар нэгэн байдлаар улс төржөөгүй цэвэр эдийн засаг, санхүүгийн чиглэлийн үнэн бодитой мэдээлэл маш чухал байгаа. Энэ хэрэгцээг хангахад чиглэсэн нь танай сэтгүүлийн бусдаас ялгарах давуу тал гэж ойлгож байна.


Сүүлийн үед Монгол Улсын Засгийн газрын зүгээс хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхийн тулд ихээхэн анхаарал

хандуулан ажиллаж байгаа. Иргэн бүрт хувьцаа эзэмшүүлэх ажлыг ч хийлээ. Гэхдээ хамгийн гол нь иргэдийн энэ зах зээлийн талаарх мэдлэг үнэн бодит мэдээлэл хөгжлийн гол суурь нь байх болов уу. Тиймээс энэ зах зээлийн талаарх мэдлэг өгсөн мэдээлэл иргэдэд ус, агаар мэт хэрэгтэй байна. Тиймээс цаашид “Mongolian Economy” сэтгүүлийн зүгээс уншигчдын хамгийн эрэлттэй сэдэв болоод байгаа хөрөнгийн зах зээлийн талаар системтэй мэдээллийг бодит эх сурвалжаас нь цувралаар хүргэж байвал хэрэгтэй зүйл болно байх гэж бодож байна.

Л.Ариун**/Хумуунлэгийн ухааны их сургуулийн экологийн сэтгүүл зүйн багш/:**

-Эдийн засаг, уул уурхай, байгаль экологи, аялал жуулчлал зэрэг уншигчдын эрэлт хэрэгцээг соргог мэдэрч бичиж байгаа нь “Mongolian Economy” сэтгүүлийн онцлог, давуу тал юм. Үүгээрээ бүх төрлийн мэдээ, мэдээллийг хаман бичдэг бусад сэтгүүлээс ихээхэн ялгаатай. Тодорхой сэдвээр төрөлжин эдийн засгийн мэдээллийг сонирхогч бүлэг хүрээнийхэнд цэгцтэй мэдээлэл хүргэдэг нь тус сэтгүүлийн бас нэг онцлог юм. Сэтгүүлчдийнх нь бичих ур чадвар сайн, тухайн сэдвийн хүрээнд няхуур судалгаа хийж мэдээлэл цуглуулдаг нь нийтлэлүүдээс тодорхой харагддаг. Надад хамгийн их таалагдсан нийтлэлүүд гэвэл

уул уурхайн нөхөн сэргээлтийг харьцуулан гаргаж ирсэн “Яг л байснаараа”, “Монголын байгаль уйлж байна” мөн “Уул уурхай утаагүй үйлдвэрлэлийг сөнөөх нь”, “Монголын элсэнд зөвхөн ашигт малтмал байна гэж үү” зэрэг болно. Мөн танай сэтгүүл Монгол орны бахархах түүх, шинэ залуу үеийнхнийг сурталчилан таниулсан булан хөтөлдөг нь туйлаас таалагддаг. Тухайлбал, “Гадаадад гайхагдсан монгол чадвар”, “Made in Mongolia” булан юм. Сэтгүүлийн хамт олонд цаашдаа улам чанартай нийтлэл олныг бичээрэй хэмээн захиж, өндөр амжилт хүсье.



Хүнд аж үйлдвэр

Төмөртэй хүн баяждаг

Б.Тогтох

Манай үеийнхэн багадаа төмөр утсаар дугуй түрж нааддаг байв. Тэр үед төмөр утас ч элбэг олддог байж. Энэ үеэс л төмөр утас ямар чухал болохыг анх мэдэрсэн гэх үү дээ. Гэтэл өдгөө манай улс төмрийг өмнөд хөршөөсөө импортолж байна. Саяхан л хог шиг хөглөрдөг байсан төмөр утас яагаад ийм үнэ цэнэтэй болчихов. Ерээд оноос хойш төрсөн банди нар төмөр утсаар дугуй түрж тоглохыг бараг мэдэхгүй байх. Төмөр ч үнэд орсоор. Манай улсын хувьд төмөр утасны түүхий эд болох төмрийн хүдрээ 2005 оноос урд хөршдөө экспортолж эхэлжээ. Ашигт малтмалын газар /АМГ/ -ын мэдээлснээр өдгөө манайд төмрийн хүдрийн 26 ашиглалтын лицензийг гадаадын хөрөнгө оруулалттай 20 гаруй компани эзэмшиж байгаа аж.

Манай сэтгүүл өмнөх дугаартаа “Экспортын татвар эдийн засгийг эмчилнэ”, “Төмрийн хүдэр төрсөн нутагтаа тоосоо шилгээн, өмнө зүг рүү урссаар” гэсэн нийтлэлүүдээрээ уул уурхайн зарим бүтээгдэхүүнд экспортын татвартай болох төмрийн хүдэр, төмөр боловсруулах үйлдвэрийг байгуулах асуудлыг хөндсөн. Цаашид Монгол Улс төмрийн хүдрээ өнөөдрийнх шиг тонн тонноор нь экспортын татвар ч үгүй зөөгөөд л байх хэрэг үү. Төмрийн хүдрээ түүхийгээр нь экспортлох эхний бөгөөд эцсийн шалтгаан нь юу вэ. Үйлдвэржилтийн хар хайрцагны бодлого гэж байна уу?

Манай улсын экспортын 90 орчим хувийг ашигт малтмалын бүтээгдэхүүн эзэлж байна. Тиймээс уул уурхайн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин, экспортод гарч буй зарим нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүнд экспортын

татвар ногдуулах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх бодлогыг Гаалийн ерөнхий газар баримталж байгаа юм байна. 2012 оны төсвийн орлогыг бүрдүүлэхэд татварын бодлогоор ийн хамжилцах аж. Мөн ГЕГ-ийн мэргэжилтнүүд “Ашигт малтмалын нөөцийг урт удаан хугацаанд үр өгөөжтэй ашиглах, төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэхийн тулд экспортын татвар зайлшгүй тавих шаардлагатай” гэв.

Баримт 1

Дэлхийн төмөр экспортлогч гол дөрвөн орны нэг болох Энэтхэг улс жилдээ 200 гаруй сая тонн төмрийн хүдэр олборлож, агууламж багатайгаа Хятадад экспортолдог байна. Үүнийг нь Хятад улс дээд зэргийн агуулга бүхий хүдэртэй хольж, нэмүү өртөг шингээн үйлдвэрлэлдээ ашигладаг аж. Энэтхэгийн Парламент Түүхий эдийн аюулгүй байдлын тухай хуулийг баталжээ. Тус хуулинд улс орныхоо стратегийн чухал түүхий эд болох төмрийн хүдрийг дотооддоо гүнзгийрүүлэн боловсруулалт хийж, ажлын байр бий болгон нэмүү өртөг шингээх, хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллийг багасгах зэрэг заалтыг шинээр оруулж өгчээ.

Хуулийн зорилго нь эдийн засгаа дэмжсэн, аж үйлдвэрийн салбараа хөгжүүлэх бодлогыг өвөртөлсөн нь өдгөө үр дүнгээ өгч байгаа аж. Манай улсаас ялгарах нэг онцлог нь энэтхэгчүүд төмрийн хүдэртээ экспортын татвар ногдуулдаг байна. Энэтхэгийн эрх баригчид бүтээгдэхүүний үнэ өндөр байхад экспортын татвараа нэмэгдүүлж, үнэ буурахад татвараа бууруулдаг уян хатан бодлого баримталдаг байна. Тиймээс төмрийн хүдрээ бүрэн боловсруулах аж үйлдвэрийг ▶

► байгуулахаар шинэ төслийн техник эдийн засгийн үндэслэл ч одооноос тодорхой болж байгаа юм байна. Мөн өнгөрсөн оны гуравдугаар сараас экспортын төмрийн хүдрийн төмөр замын тарифаа долоон хувиар нэмжээ.

Баримт 2

Манай улстай хамгийн ойр буй Казахстан улсаар жишээ татъя. Тус улсын төмрийн хүдрийн нөөц 16.6 тэрбум тонн буюу дэлхийн нөөцийн зургаан хувийг эзэлж байна. Тус улс нь хар, өнгөт төмөрлөг ба ховор металлын нөөц олборлолт, үйлдвэрлэлтээрээ дэлхийн 170 гаруй орноос арваннэгдүгээр байрт жагсжээ. Манайхтай зэрэг зах зээлийн шилжилт хийсэн улсын нэг. Тус улс 2003-2009 онд л гэхэд 9.34 тэрбум ам.долларын хар, өнгөт төмөрлөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортод гаргажээ. Гэтэл аж үйлдвэржилт нь яралзтал хөгжиж байхад тус улсын эдийн засаг манайх шиг 20 хувиар огцом өссөнгүй. Казахстаны “Казахмыс”, Хятадын “Gichuan Group LTD” хамтран Хятадын хөгжлийн банкны хоёр тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтаар жилдээ 25 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийн комплекс барьж, ирэх 2014 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Хувьсгал гэдэг үгийг эдийн засагтай холбон ярих дуртай болсон улстөрчид болоод холбогдох байгууллагынхан аж үйлдвэрийн хувьсгал хэрхэн хийдгийг хаяанд буй Казахстанас бэлээхэн харж болох нь.

Баримт 3

Төмрийн хүдрийн арвин нөөцтэй гэж андуурсан уу, бид. Мэргэжилтнүүдийн тооцоолсноор дэлхийн төмрийн хүдрийн нөөц 1998 онд 213 тэрбум тонн байсан бол өнөөдөр 140.6 тэрбум тонн болтлоо буурчээ. Эсрэгээрээ төмрийн хэрэгцээ ч өссөн дүнтэй гарч. “Дэлхийн төмрийн хүдрийн нөөцийн 91 хувиас илүү нь 10-хан оронд төвлөрч байгаа нь төмөр үнэд орохын шинж” хэмээн “Металс Монголиа-2011” чуулга уулзалтын үеэр Японы “Кобе Стийл” компанийн ахлах менежер Шохэй Яоида онцолсон билээ. Ази тивд төмрийн хүдрийн 17 хүртэлх хувь нь ногдог байна. Монгол Улсын хувьд төмрийн хүдрийн батлагдсан нөөц 600 гаруй сая тонн буюу дэлхийн нөөцийн 0.5 хувийг эзэлдэг. Энэ нь тийм ч өдөр шөнөгүй зөөгөөд байхаар арвин нөөц биш

Уул уурхайн өнөөгийн байдал



Эх сурвалж: АМГ


юм. Монгол Улс нэгэнт төмрийн хүдрийн бага нөөцтэй учраас экспортыг зогсоочих хэрэгтэй гэдэг санааг ч Иргэний танхимд болсон “Монгол Улсын төмөрлөгийн аж үйлдвэрлэлийн хөгжлийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” нээлттэй хэлэлцүүлгийн үеэр оролцогчдын олонх нь тэмдэглэж байсан юм. Манайх энэ оны аравдугаар сарын байдлаар л гэхэд 4.8 сая тонн төмрийн хүдрийг “шороогоор” нь экспортолсон байна.

“Өнгөрсөн онд манай улсын төмрийн хүдрийн экспорт 2005 оныхоос 20.1 дахин өсч, нэг тонныг нь дунджаар 68 ам.доллараар буюу дэлхийн зах зээлийн үнээс 2.4 дахин хямд борлуулсан” хэмээн Монголын төмөрлөг, машин механизм үйлдвэрлэлийн үндэсний холбоо/МТММҮҮХ/-ны ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн Г.Батхүү ярив. Монголчууд бараг бүгдээрээ “Оюутолгой”, “Тавантолгой”-д анхаарлаа хандуулж буй энэ үед хар төмөрлөгийн үйлдвэрийн төрийн бодлого алдагдсанаас арван сарын хугацаанд л бид 671.9 сая ам.долларын ашгаа алдах жишээний байна гэж тэрбээр нэмж хэлсэн. Манай улсын гангийн болоод төмрийн бүтээгдэхүүний жилийн хэрэгцээ 300-гаад мянган тонн боловч үүнийхээ 80 гаруй хувийг өмнөд хөршөөсөө импортлох болжээ. Бүтээн байгуулалтын томоохон хөтөлбөрүүд хөрсөн дээр буугаад ирэхээр төмрийн хэрэгцээ нэг сая тоннд хүрч, барилгын арматурын хэрэгцээ одоогийнхоос 70 хувь өсөхөөр байгаа аж.

Баримт 4

Төмөрлөг боловсруулах аж үйлдвэрлэлийн салбар уналтад орсон хэмээн Иргэний танхимд болсон “Монгол Улсын төмөрлөгийн аж үйлдвэрлэлийн хөгжлийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” нээлттэй хэлэлцүүлгийн оролцогчид хэлж байлаа. Манай улс 1980-аад оны үед төмөрлөг боловсруулалт, машин үйлдвэрлэлийн салбарын асуудлыг төрийн бодлогын хэмжээнд явуулж байсныг МТММҮҮХ-ны техник технологи эрхэлсэн захирал, Монгол Улсын зөвлөх инженер С.Арслан сануулсан. Сонирхуулахад, тухайн үед төмөрлөг боловсруулах томоохон 20 гаруй үйлдвэр, 400 орчим цех, тасагт 7000 гаруй суурь машин ажиллаж байжээ. Зөвхөн Улаанбаатар хотын Авто заводод л гэхэд жилдээ 800 гаруй автомашин, 15 мянган ширхэг ►

Уул уурхайн салбарын татварын орлогын өсөлт /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Сангийн яам

дугуйнд иж бүрэн засвар хийж, 880 орчим тонн эрэг, боолт үйлдвэрлэсэн байна. Мөн 450 гаруй тонн авто сэлбэг, резин техникийн эдлэл шинээр үйлдвэрлэн, ОХУ, Дорнод Сибирьт экспортолж байсан “сайхан дурсамж” тодрох ажгуу.

Гаалийн ерөнхий газрын сүүлийн гурван жилийн статистик мэдээллээс үзэхэд импортоор оруулж ирсэн нийт бараа бүтээгдэхүүний 40 орчим хувь буюу гурван тэрбум ам.доллар зөвхөн төрөл бүрийн төмөрлөг бэлдэц, цувимал утас, өндөр чанарын ган, машин механизм, авто машины техник, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги сэлбэг хэрэгсэл авахад зарцуулсан байна. Үүнийг бид өмнө нь үйлдвэрлэж, хэрэгцээгээ бүрэн хангаад зогсохгүй илүү гарснаа экспортолж байжээ.

Уул уурхайн олборлох үйлдвэрлэл нь хөрөнгө оруулалтын 65 хувийг эзэлж, үр ашиг нь 18 хувь байдаг бол төмрийн хүдэр баяжуулахад хөрөнгө оруулалт 20 хувь, ашиг нь 32 хувь. Харин боловсруулах үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт нь 15 хувь боловч үр өгөөж, нь 60 хувь байдаг болохыг Зөвлөх инженер С.Арслан сонирхуулав. Гэтэл манай улс дахин сэргээгдэхгүй байгалийн баялгаа гадагш нь зөөж, 80-60 гаруй хувийн ашгаа алдаж байгааг “Танан импекс” компанийн металл боловсруулалтын технологич инженер Ц.Ядамрагчаа ярилаа.

Баримт 5

“Болд төмөр Ерөө гол” компани нь Орос Монголын хамтарсан Улаанбаатар төмөр замаас ч олон вагонтой болж таарах нь. Тус компани нь өөрийн дөрвөн зүтгүүртэй бөгөөд жилдээ зургаан сая тонн буюу 1.2 тэрбум ам.долларын төмрийн хүдрийн баяжмал зөөх төмөр замын хүчин чадлыг бүрдүүлжээ. Хэрэв хоногт 500 вагоноор зөөгөөд байвал Баянголын ордод тогтоогдсон 110 сая тонн нөөцийг аравхан жилийн дотор бүрэн зөөж дуусахыг Эрдэс баялгийн үндэсний ассоциацийнхан яриу. Металлургийн салбарынхны ярьж буйгаар төмрийн хүдрийн ордуудын гол бүс нутаг нь Дархан, Сэлэнгийн бүс аж. Тиймээс Баянголын орд нь тус бүс нутагтаа томоохонд тооцогдох юм билээ.

Өнөөгийн байдлаар манай улсын төмөр замаар тээвэрлэж буй төмрийн хүдрийн баяжмал нь Улаанбаатар төмөр замын нийт ачаа эргэлтийн 30-аад хувийг эзэлж байгаа аж. Харин Замын-Үүдийн хилийн боомтоор урд хөрш рүү гарч байгаа ачааны 40-45 хувийг төмрийн хүдэр эзэлсэн байна. “Болд төмөр Ерөө гол” компани нь Баянголын орд газарт ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатайгаар авч хүдэр олборлон баяжуулж, бүтээгдэхүүнээ 100 хувь БНХАУ-д экспортолж байгаа юм.

Тус компани нь 98 км төмөр зам бүхий Хандгайт өртөөг байгуулж, хоногт 200-300 вагон буюу 12600-18900 тонн төмрийн хүдэр зөөж байгааг “Хатан Ерөө гол” орон нутгийн иргэдийн хөдөлгөөнийхөн ярилаа. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн ерөнхий технологич М.Авирмэд хар төмөрлөг боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх, тэр дундаа цутгуурын үйлдвэрийг Дархан Сэлэнгийн бүсэд хөгжүүлэх боломжтой болохыг тэмдэглэсэн юм. Түүний хэлснээр “Болд төмөр Ерөө гол” компани төмрийн хүдрээ боловсруулаад гаргаж болохгүй гэж үү?

Эрдэс баялгийн Үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал

Х.Владимир “Нүүрсээр ган хайлуулах технологи манай улсад хамгийн тохиромжтой нь. Германчуудтай хамтарч судалгаа хийсэн. Өнгөт, хар төмөрлөгийн цогцолборыг байгуулахад 1.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. Үйлдвэр ашиглалтад орсноор 2500-3000 ажлын байр бий болох урьдчилсан тооцоо гарсан” хэмээн сонирхуулсан юм.

Эцэст нь

Хүннү гүрний үед “төмөртэй хүн баяждаг” хэмээх хэлц үг анх бий болжээ. Хүннүчүүд Түрэгээс төмрийн татвар авдаг байсныг өдгөө түүхчид тайлбарлаж байна. Төмрийн хүдрийн орд газруудын хүдрийн доторх төмрийн агууламж 50 хувиас дээш бол “баян”, 25-50 хувь бол “хэвийн”, 25 хувиас бага бол “ядуу” хүдэр хэмээн нэрлэдэг аж. Манай төмрийн хүдэр агууламжаараа дээрх үзүүлэлтээр бол “баян” гэсэн ангилалд багтах аж. Баруун Европын ихэнх улсын орд төмрийн хүдрээр ядууд тооцогдож, Англи, Герман, Бельги 1980- аад оноос, Франц 1993 онд төмрийн хүдэр олборлохоо бүрэн зогсоожээ. Харин хойд Америкийн олборлож буй төмрийн хүдрийн чанар муудаж байгаа бөгөөд хүдрээ сорчлон олборлож байгаа гэнэ. Зөвхөн Канад, Мексик л 61-63 хувийн төмрийн агууламжтай хүдрээ олборлосоор. Дэлхий дээр жил бүр хоёр тэрбум гаруй тонн төмрийн хүдэр олборлож байгаагаас Хятад улс дангаараа дэлхийн олборлолтын 40 гаруй хувийг бүрдүүлж байна. Дэлхийн төмрийн хүдрийн хэрэгцээ цаашид өсөн нэмэгдсээр байгаа бөгөөд Хятадынх 68 хувь, Япон, Өмнөд Солонгос, Тайванийх 18 хувь, Баруун Европынх өсөн хувь болохыг шинжээчид дүгнэж байна.

Төмрийн хүдрийн олборлолт, экспортоороо тэргүүлэгч Бразил улс 2012 онд жилийн гангийн үйлдвэрлэлээ одоогийн боловсруулж буй 41 сая тонноо 59 сая тоннд хүргэж, цаашлаад 78 сая тонн болгох зорилт тавьжээ. Төмрийн хүдрийн түүхий эд нийлүүлэгч “BHP Billiton”, “Rio Tinto” компани нь баруун Австралид төмрийн хүдрийн орд газрууддаа 116 сая ам.долларын хөрөнгө оруулан Британи Австралийн “Найрамдал” хамтарсан үйлдвэр байгуулж, дэлхийн төмрийн хүдрийн нийлүүлэлтийн гуравны хоёрыг хяналтдаа авах ажилдаа ханцуй шамлан ороод байгаа нь төмөртэй хүн баяждагийн тод жишээ биз ээ.

Нүүрс, алт, зэсээр баян Азийн цээжинд орших Монгол агууламж өндөртэй ч нөөц нь харьцангуй бага төмрийн хүдрээ экспортлохын хэрэг байна уу. Хүссэн, хүсээгүй удахгүй төмрийн хүдрийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэх ажээ.

Мөн Төмрийн хүдэрт экспортын жишиг үнэ тогтоож, татвар ногдуулах зайлшгүй шаардлага байгааг мэргэжлийн байгууллагуудынхан хэлж байгаа билээ. Сангийн сайд С.Баярцогт хэлэхдээ “2012 оны улсын төсөвт уул уурхайн бүтээгдэхүүнд экспортын таван хувийн татвар тавьсан боловч уул уурхайн холбоод, МҮХАҮТ, аж ахуй нэгжийн хүсэлтээр тэглэсэн” гэлээ. Түүхэнд байгаагүй зарлагатай гэх төсөвт экспортын татвар “жийргэвч” болохгүй гэж үү.

Монголын төмрөөр “цангасан” бүтээн байгуулалтын төслүүд хэдийд ярайтал сүндэрлэхийг төмрийн хүдрийн эзэд л мэдэх бололтой. Төмөртэй хүн баяжих нь баараггүй, томрох нь тодорхой болохыг дээрх баримт, үйл явдлуудаас харж болох нь. Төмөрт төрийн бодлого үгүйлэгдэж байна. ■

Үзэл бодол

Амьдралын Америк зам хөгжлийн цорын ганц зөв зам мөн үү



Доктор /Ph.D./ Б. ЭНХМАНДАХ

Хөгжлийн загварын тухай цуврал №1 (Оршил нь өмнөх дугаарт)

Бид бүхний сайн мэдэх хөгжлийн загвар болох Амьдралын америк зам /American way of life/-ын талаар эхлээд авч үзье.

Энэ загвар нь нэг талаар дэлхий дахинаа чөлөөт хөгжлийн дээд үлгэр жишээ болж, Америк орныг ардчилал, зах зээлийн эдийн засгийн манлайлагч улс гүрэн болгоход хүргэсэн хөгжлийн нэг сонгодог загвар яах аргагүй мөн.

Амьдралын америк зам гэдэг ойлголт нь бүр 1776 онд Томас Жефферсоны бичсэн АНУ-ын Тусгаар тогтнолын Тунхаглалын гол үзэл санаа болсон “Амьдрал, Эрх чөлөө ба Аз жаргалын төлөө тэмүүлэл” гэсэн гурвал зарчмаас үүдэлтэй бөгөөд өнөөдөр “Америк мөрөөдөл”, “Америкийн онцлог” зэрэг ойлголтуудаар баяжсан АНУ-ын иргэн бүрийн амьдралын хэв маяг болон төлөвшсөн амьдралын загвар гэж хэлж болно.

Вилл Хэрберг “Протестант, Католик, Еврей” номондоо “Амьдралын америк зам” гэдгийг улс төрийн хувьд “ардчилал, чөлөөт зах зээл” гэдэг шиг Америкийн нийгмийн хамгийн “нийтлэг шашин” гэж үзэх нь зүйтэй гэсэн байдаг.

Амьдралын америк зам нь хувь хүний үнэлэмж, үнэт зүйлсийг дээдэлдэг хувийн шинж чанартай, хөгжил хөдөлгөөнтэй, прагматик шинжтэй төдийгүй бие даасан, нэр төртэй, бүхнийг шүүх ёс зүйг номлодог, хүмүүнлэг, үргэлж урагшаа харсан, өөдрөг үзэл гэж нэг талаас хэлж болно. Америкчууд өөрийгөө боловсруулах үйл явцад хэт итгэдэг учир боловсролын салбартаа хүртэл их фанатик байдлаар ханддаг. Ийм ч учраас Америк бол өөртөө итгэлтэй, нэр төрөө эрхэмлэсэн, бие даасан хүмүүсийн чөлөөт нийгэм. Энэ утгаар нь АНУ-ыг либертаричуудын “мөрөөдлийн эх орон” гэж хэлж болно.

Америкчууд их өгөөмөр, филантропик хүмүүс, тиймээс бусдын зовлон зүдгүүрийг эцэс төгсгөлгүй хуваалцахад бэлэн улс. Тиймээс “Бүх нийтийн сайн сайхны төлөө” бүхнээ зориулах ёс зүйг дээдэлсэн америкчуудыг нөгөө талаар идеалистууд ч гэж хэлж болно. Энэ ч утгаараа өнөөдөр АНУ-ыг дэлхий дээр “Ардчилалын өлгий нутаг”, “Ардчилалын эцэг” гэж нэрлэж байгаа нь хоосон зүйл биш ээ.

Гэхдээ Амьдралын америк зам нь хөгжлийн загварын хувьд улс орон бүрт тохирох загвар мөн үү, биш үү? гэдэг нь өөр асуудал юм.

Дэлхийн номер нэг эдийн засаг бүхий Их гүрний хөгжлийн агуу том загвар жижиг, буурай хөгжилтэй улс орнуудад тэр бүр зохицохгүй гэж юуны өмнө хэлж болохоор байгаа юм.

Газар газраас аз жаргалыг хайн ирсэн олон сая хүн амтай, АНУ гэдэг нэгэн Их гүрнийг 200 гаруй жилийн өмнөөс өнөөг хүртэл төвхнүүлэхдээ хувь хүний эрх, эрх чөлөөний салшгүй хэсэг “амьдрал, эрх чөлөө ба аз жаргалын төлөө тэмүүлэл” зарчмыг тунхаглаж, хувь хүний өөрийн болон бусдын өмнө хүлээх хариуцлагыг дээд зэргээр мэдрүүлсэн ч нөгөө талаар төрөөс хүний талаар авах бодлогыг хязгаарлаж өгснөөрөө Европын болон бусад нийгмийн баримжаат загваруудаас ялгагддаг нь тодорхой болсон зүйл.

“Уолл Стрийтийг эзэл” хөдөлгөөнийхөн ардчиллын үнэт зүйлийг үгүй хийж буй үндэстэн дамнасан корпорациуд, нүсэр бүтэцтэй банкууд, АНУ-ын санхүүгийн олигархиудын эсрэг тэмцэж байгаа хэмээн өөрсдийгөө тодорхойлж буй бөгөөд нас, хүйс, арьс өнгө, улс төрийн үзэл баримтлалаараа өөр хоорондоо эрс ялгаатай эдгээр хүмүүс өөрсдийгөө хүн амын “99 хувь” хэмээн тодорхойлж, улстөрчдийг сайн, сайхан нийгмийг бүтээн байгуулахыг хүлээж, тэдэнд найдах хэрэггүй гэдгийг сануулах, ойлгуулах, баялаг бүтээдэг жирийн хүмүүсийг эрх мэдэлтэй болгохыг зорьж байна.

Ийнхүү өнөөдөр америкчуудын зарим нь өөрсдөө тогтолцооныхоо гажуудлыг олж хараад, хөдөлгөөн өрнүүлж байна. Чөлөөт зах зээлийн эдийн засаг нь эдийн засгийн үсрэнгүй өсөлтийг хангадаг ч, зөөлрүүлж хэлэх юм бол, түүний үр дүнг олон түмэнд мэдрүүлэх тал дээрээ дутагдалтай. Өөрөөр хэлбэл, аливаа зохицуулалтгүй, чөлөөт өрсөлдөөний дүнд нэг талд нийгмийн баялгийн ихэнхийг гартаа төвлөрүүлсэн монополиуд, нөгөө талд уг баялгаас хүртэх “хувьгүй” олонхи үүсдэг байна.

Манайд ч нийгмийн шилжилтийн үеийн төгсгөлд яг ийм дүр зураг харагдаж эхлээд байгаа.

Тиймээс Амьдралын америк зам нь өнөө цагт дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлогч ардчилал, эрх чөлөө, зах зээлийн нийгмийн амьдралын үлгэр дууриалал, ерөнхий хэв хэмжээ болохоос биш, улс орон бүрийн хөгжлийн тодорхой арга зам болоход үнэхээр “томдох” хөгжлийн загвар бололтой. ■



Эх сурвалж: НҮБ-ын Ази Номхон далайн
Эдийн засаг, нийгмийн комисс

- Монгол 66.7%
- Хятад 43.8%
- Хонконг 31.5%
- Япон 29.2%
- Камбодж 64.7%
- Индонез 54%
- Лаос 66%
- Малайз 56.6%
- Филиппин 63.7%
- Сингапур 38.3%
- Тайланд 43.4%
- Вьетнам 53.4%
- Энэтхэг 58.3%

Хөдөлмөр эрхлэлт

Азийн залуус ба боломж

Б.Энхцэцэг

Дэлхийд залуусын тоогоороо тэргүүлдэг тив бол Ази. Амьдрал энд нэг л өөр.

Бямба гаригийн үдшийг Сингапурт Николь болон түүний найзууд хотын хамгийн үнэтэй орчин үеийн цэнгээний газарт бүдэг гэрэл, бүгчим халуунд бүжиглэн өнгөрүүлнэ. Хөгжмийн хэмнэл оргил цэгтээ хүрэх тэр агшинд сэтгэл нь хөдөлсөн 25 настай менежментийн зөвлөхийн ажилтай Николь өөрийн эрхгүй орчлонгоос тасарсан мэт бүжинэ. Николь болон түүний найзуудын адил олон залуу өнөөдөр Ази тивд төрснөөрөө бахархаж яваа. Эдийн засаг, нийгмийн хүнд үед хөлс хүчээ дуслуулж явсан өвөө эмээ, аав ээжийнхээ үеийг бодвол XXI зууны Азийн залууст гарашгүй оргил, хүрэшгүй мөрөөдөл гэж үгүй болжээ. Хуучин цагт санаанд ч саатаж үл зүрхлэм олон мөрөөдөл өнөөдөр бодитоор биелэх эсэх нь ямар ч аавын хүү, ээжийн охины хувьд заяа тавилан, угсаа гарал гэхээсээ илүүтэй сэтгэл зүтгэл мэдэх хэрэг болсон сайхан цаг.

“Дэлхий дээр хөгжлийн орон зай бага үлдсэн. Харин Азид бол бий. Өөдрөг үзэл, өсөх боломж энд байгаа. Хүмүүс том сэтгэж байна” хэмээн шөнийн цэнгээний газарт 1500 сингапур долларын такстай (1183 ам.доллар) тансаг зэрэглэлийн ширээний ардаас Николь өөрийн бодлыг хуваалцан сууна.

Халаас түнтийсээр

Нэгдсэн үндэсний байгууллагаас (НҮБ)-аас гаргасан эдийн засгийн төлөв байдлын үнэлгээнээс авч үзэхэд ирэх жилд Зүүн Өмнөд Азийн эдийн засгийн өсөлт долоон хувьд хүрэхэд тун ойрхон. Өр зээлэнд хүлэгдэж, өрөөл бусдыг төдийлэн анхаарах сөхөөгүй яваа Америк, Европынхныг азиуд эдийн засгийн өсөлтөөрөө ардаа хаян түрүүлж яваа юм.

Ази тивийн өнцөг булан бүрт хүмүүсийн амьдралын түвшин, ашиг орлого нэмэгдсээр. Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас гаргасан судалгаагаар 2009 оны

байдлаар Ази тивийн цалингийн дундаж өсөлт найман хувьтай гарсан бол энэ үзүүлэлт хөгжингүй орнуудад ердөө л 0,6-хан хувьтай байжээ. Сүүлийн таван жилийн хугацаанд залуусын ажилгүйдэл Азийн ихэнх оронд 15 хувиас доош гарч байгаа аж. Харин Итали, Испани зэрэг Европын улсад энэ тоо 30 хувиас давсан байдаг аж. Бусад тивийг бодвол Азийн залууст боломж өндөр байгаа нь эдгээр үзүүлэлтээс тодорхой харагдаж байгаа юм. “Азид амьдрал цэцэглэж байна. Өнгөрсөн 20-30 жилийг эргээд харвал хөгжлийн түвшний нэгдсэн үзүүлэлт дээшилсэн байгааг харж болох юм” хэмээн Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комиссын ажилтан Марко Ронкарати хэлжээ. Идэр насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд анхаарлаа хандуулах нь залуусынхаа тоогоор дэлхийд тэргүүлэгч Ази тивийн хувьд чухал асуудал юм. НҮБ-аас гаргасан судалгаагаар дэлхий дээрх 15-24 насны иргэдийн 62 хувь нь Ази тивд амьдардаг байна. Өөрөөр хэлбэл, манай гаригийн дээрх насны гурван хүн тутмын хоёр нь Азид аж төрдөг гэсэн үг юм. Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комиссын 2010 оны мэдээллээс үзвэл Азид 745 сая залуу иргэн амьдардаг гэсэн нь Ази тивийн 15-24 насны залуучууд хүн ам зүйн бүтцийн ихэнх хувийг эзэлдэг гэж үзэж болох нь. Тэр дундаа Филиппин, Камбож, Лаос, Монгол нь хамгийн залуу иргэдтэй улс бөгөөд залуусынх нь дундаж нас 22 аж. Харин Их Британи улсад залуусын дундаж нас 40 юм байна.

Хүлээлт

Өндөр хөгжил, өргөн боломж ч өөрийн гэсэн асуудлуудыг дагуулдаг. Азийн залуус өнөөдөр болмжиндоо амтшиж, амьдралаас улам ихийг хүсэж, тэр чинээгээр олон асуудал тэдний өмнө хөндөлсөх болжээ.



Хонконгийн иргэн 26 настай Ноорин өөрийгөө азтай нэгэнд тооцдог. Учир нь, тэрбээр Их Британи улсад бакалаврын зэрэг хамгаалсан юм. “Миний эцэг эх их сургуульд ч явж ▶▶

үзээгүй байхад би гадаадад боловсрол эзэмшиж чадсан” гэж бахархалтайгаар өгүүлнэ. Тэрбээр гадаадад боловсрол эзэмшсэнийхээ хүчинд ээж, аавынх нь үед мөрөөдөл байсан өсөн дэвжих боломж, илүү сайхан амьдралыг өөртөө бий болгох зэвсгийг эзэмшсэн хэрэг. Гэсэн хэдий ч Ноорины амьдралд биелэгдэх эсэх нь тодорхойгүй олон зорилго бий. Амьдралын өртөг улам бүр өндөрсөж буй нийгэмд тэрбээр наад зах нь өөрийн гэсэн орон байртай болж чадахгүй л явна. 30 нас хүрэхээсээ өмнө өрх тусгаарлаж өөрийн гэсэн хувийн амьдрал зохиохыг хүсэж буй ч Хонконг амьдарлын өртөг өндөртэй тул хэдийгээр ажил төрөлтэй ч гэсэн ганц бие хүн орон сууцтай болно гэдэг амаргүй зорилт. Тийм болохоор мөнгөн хуримтлал үүсгэхэд хэцүү байдаг тухай хэлжээ. Энэ

сүүлийн хоёр жилийн турш хийж байгаа. Сарын 5000 рупины (102 ам.долларын) цалинтай аж. “Надад мөнгө хэрэгтэй учраас л би энд ажиллаж байна. Миний цалин амьдралын хаана ч хүрэлцдэггүй” хэмээн тэрбээр хэлжээ.

(ОУХБ)-аас хийсэн судалгаагаар Зүүн Өмнөд Ази болон Хойд Африкийн бүс нутагт хамгийн олон ажил эрхлэгч ядуус амьдардаг болохыг тогтоожээ. Тус байгууллагын томъёолсон энэхүү нэршилд хөдөлмөр эрхэлдэг хэдий ч өрхийн хэрэглээ нь 1,25 ам.доллараас бага хүмүүсийг хамааруулдаг байна. Сүүлийн үеийн залуу иргэдийн дунд явуулсан судалгаанаас харахад, буурай хөгжилтэй орны ядуу залуус удаан хугацаанд ажилгүй суух ямар ч боломжгүй байдаг бөгөөд ямар ч хамаагүй ажил хийж, өл

Дэлхийн залуусын ажил эрхлэлтийн байдал



мэт амьдралын тогтсон дүр зураг Япон, Өмнөд Солонгос, Сингапур, Хятад зэрэг Азийн өндөр хөгжилтэй бусад оронд ч ажиглагдаж байгаа юм. Үүний зэрэгцээ хөдөлмөр эрхлэлт, худалдан авах чадвар өсөхийн зэрэгцээгээр ажлын байр, нөөц боломжийн төлөөх өрсөлдөөн ширүүссээр байгаа нь залуусын урам зоригийг мохоож, бууж өгөхөд хүргэж байгаа аж. Өөрөөр хэлбэл, хэдийгээр боловсролын түвшингээ дээшлүүлж, орлогоо нэмэгдүүлсэн ч гэлээ сая сая Ази залууд ахиж дэвших боломж улам бүр хязгаарлагдмал болж ирж байгаа юм. Ноорин “Энэ бол дэлхий нийтийн асуудал. Бүх л залуу амжилтад хүрэхийн төлөө өөдрөг тэмүүллийг өвөртлөн амьдардаг. Хөгжин дэвших орон зай үлдээгүй нийгэмд залуус цөхрөнгө байдалд ордог” хэмээн бодлоо хуваалцсан тухай тэмдэглэжээ.

Ажилтай тэгээд ядуу

Азийн залууст тулгамдаж буй олон асуудлыг тодорхой харж болох орон бол Энэтхэг. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр тэдний олонхийн амьдрал амьдрал сайжирч буй хэдий ч баян, ядуугийн ялгаа улам гүнзгийрсэн хэвээр. Түүнийг дагаад хоорондоо эрс тэс ялгаатай хувь тавилан бий болж байна. Энэ улсад 30- аас доош насны 714 сая иргэн амьдардаг.

Бямба гаригийн үдэш 21 настай Мумбай хотын оршин суугч залуу Мухамедын хувьд зугаалж явах цаг биш аж. Түүний үе тэнгийн олон залуу архи дарсанд хөлчүүрч, шөнийн клубт бүжиглэн цэнгэж байх зуур Мухамед ойролцоох ресторонуудад дугуйгаараа сүү зөөгөөд завгүй. Ахлах сургуулийн боловсрол эзэмшсэн тэрбээр энэ ажлаа

залгуулж өөрийгөө авч явах зайлшгүй шаардлага тэдний өмнө тулгардаг байна. Иймээс ч тэд нэг ажлын байранд тогтвор суурьшилтай байх нь ховор. Иймэрхүү төрлийн сул ажил эрхлэлт ажилгүйдлийн түвшинг доош чангаах мэдэх ч залуусын дорой буурай амьдралыг дээшлүүлэхэд төдийлэн үүрэг гүйцэтгэхгүй л болов уу.

Дэлхий дээр ажил хайж байгаа эсвэл ажилгүй гэхээсээ илүү хөдөлмөр эрхлэгч ядуусын ангилалд багтах маш олон залуу шар өдөр бор хоногийг амь зогоон өнгөрүүлж байна.

Сэхүүн зангийн цөхрөл

Сингапурын шөнийн цэнгээний газарт эргээд очъё. Николь болон түүний найзуудын цэнгээн үргэлжилсээр. Хэдийгээр түүнд амжилтдаа бялуур амьдрах таалагдаж байгаа ч Азийг нөмөрсөн өөдрөг үзлийн эрчит давалгаанд халхлагдсан олон асуудлуудыг давж гарах итгэл үнэмшил, сэтгэл зүтгэлээ алдахгүйн тулд ямар алхмууд хийх хэрэгтэйг тэр сайн мэдэж байгаа.

Олон нийтийн бухимдалт байдлыг бид үзэхгүй яваа нь энэ улс орон эдийн засгийн хувьд өсөж байна гэсэн мэдээллийн халхавчилж, тогтоон барьж буй хүч юм. Хүмүүсийн цалин нэмэгдэлгүй тогтонги байдалд орж, амьдралд үл нийцсэн бодит бус тоо болон хувирвал олон нийтийн дургүйцэл гээч зүйл нүдэнд үзэгдэж чихэнд хоногших хэмжээнд хүрнэ. Эцэст нь манай тивийн улс орнуудын Засгийн газар Азийн шинэ үеийнхний хүсэл тэмүүллийн зүг чигийг зөв тодорхойлж чадах уу гэдэг асуулт гарч ирж байгаа юм. Эс чадваас дэлхий дээрх нэг тэрбум залуу иргэдийн дөрөвний гурвын гомдол цөхрөл далай мэт эх захгүй давалгаа мэт дийлдэшгүй байх нь мэдээж. ■



Web: www.kmm.mn E-mail: info@kmm.mn Tel: 50111212, 99114716, Fax: 50111214

ALL-NEW
OPTIMA

NEW MONGOLIAN CHOICE



KIA MOTORS
MONGOLIA



Эдийн засгийн тулгын гурван чулууг ивлээ

Б.Баяртогтох

Манай хамт олон өглөө бүр тэнгис, далайг зорьдог ажгуу. Гатлах далай, туулах тэнгис, дайран өнгөрөх нуур, дөтлөх мөрөн даан ч их билээ. Мөсөн уул, хар салхи, цунами гээд бэрхшээл ч чамгүй. Харин энэ бүхний эцэст энүүхэнд Номхон далай налайж угтана. Тэртээд Атлантын далай анир үгүй дүнсийж хүлээнэ. Тиймээ, манай “Mongolian Economy” сэтгүүлийн эдийн засгийн хөлөг онгоц далбаагаа өргөж, алс далайд гарч буй нь энэ. Ингэж л сэтгэл зүрх минь догдлохуйд хөнгөн бийрийг хөших шалтгаан төрөв өө.

Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн “Mongolian Economy” сэтгүүлийн ажлын өдөр бусад хэвлэл мэдээллийн байгууллагатай адил өглөө бүр 9.00 цагтай уралдан эхэлж, бүрий болох үед сая амсхийж, гэр гэрийн зүг оддог. Харин манай редакцийнхан нэгэн өдрийг тууз хайчилж, баярын хундага харшууланхан ёслолын байдалтай өнгөрөөлөө. /2012.01.04/. Өглөөнөөс эхлээд л хөл хөдөлгөөн өрнөж, өмнө маань хийх ажил ч мундахгүй. Үйл явдал, мэдээ, сурвалжлагад гүйхээ түр азнаж, өөрсдөө мэдээний эх сурвалж болов.

Монгол Улс бөмбөрцгийн анхаарлын төвд ороод буй энэ үед эдийн засаг, санхүү, бизнесийн мэдээллийг олон нийтэд үнэн зөв, бодитой хүргэх цаг үеийн дуудлагаар “Mongolian Economy” сэтгүүл мэндэлсэн шигээ өдгөө Вэб сайт, ТВ студи байгуулж, албан ёсоор нээх үйл ажиллагаа болсон нь энэ. Тууз хайчлах хүндтэй үүрэг манай сэтгүүлийн эрхлэгч Д.Бэхбаяр, Орлогч эрхлэгч И.Отгонжаргал, “Синглтон” компанийн гүйцэтгэх захирал В.Баярсайхан, “Economy” студийн редактор Ц.Буянбат нарт ногдсон юм.

Хахир өвлийн жавар тачигнах цагаар “Mongolian Economy” сэтгүүлийн хамт олон www.mongolianeconomy.mn вэб сайт, “Economy” ТВ студи ашиглалтад оруулж, манай сэтгүүл “ихэр дүүтэй” боллоо. Эдийн засгийн мэдээ мэдээллийг нүдээр үзүүлж, гараар мэдүүлж, дуу хоолойгоор дүрстэй нь хамт хүргэх тулгын гурван чулууг Монголын хэвлэл мэдээллийн салбарт ийн ивлээ. Ийнхүү бидний Монголын эдийн засгийн

хөгжилд хувь нэмэр оруулах хийгээд үсрэнгүй хөгжих орны иргэдийн өмнө тулгамдаад буй эдийн засаг, санхүүгийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхийг зорьж буй ажилд амжилт хүсэж, баярыг маань хуваалцсан хүмүүст баярлалаа.

Тууз хайчлах ёслолын үеэр “Mongolian Economy” сэтгүүлийн эрхлэгч Д.Бэхбаяр “Өнгөрсөн оны энэ үед эдийн засаг, бизнесийн сэтгүүл гаргах зорилго маань цаасан дээр ч бууж амжаагүй, толгойд явж байлаа. Тэгвэл бид өнөөдөр арван дугаар буюу 1000 нүүр эдийн засгийн мэдээллийг уншигчдадаа хүргээд байна. Улс төрөөс хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл байж, эдийн засаг, санхүү, бизнесийн мэдээ мэдээллийг монгол-англи хэл дээр олон нийтэд хүргэх зорилгоо биелүүллээ. Бид нэг жил хүрэхтэй үгүйтэй богино хугацаанд сэтгүүлээ гаргаж, хөл дээр нь зогсоогоод зогсохгүй үйл ажиллагаа маань улам өргөжин тэлж өнөөдөр Вэб сайт, ТВ студитэй болж байгаадаа баяртай байна” хэмээн яриу.

Тогтсон уламжлалаараа манай хамт олон сүүн хундагаа өргөж, шинэхэн вэб сайт, ТВ студиэ хүлээн авлаа.

www.mongolianeconomy.mn вэб сайтыг мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэсэн мэдээлэл технологийн “Синглтон” компанийн захирал В.Баярсайхан “Бид өнгөрсөн хугацаанд цөөнгүй цахим хуудас хийж гүйцэтгэж ирсэн. Тус вэб сайтын хувьд эдийн засгийн гэдэг утгаараа бидний өмнө нь хийж байсан цахим хуудсуудаас нэлээд өөр онцлогтой болсон гэж бодож байгаа. Эрээн мяраан биш энгийн, тодорхой байх ёстой гэсэн шалгуурыг чухалчилсан” гэлээ.

Мөн энэ оноос эхлээд сар тутмын “Mongolianeconomy” сэтгүүл маань монгол-англи хэл дээр 14 хоног тутамд гарч байхаар болсныг хэлэхэд баяртай байна. Эдийн засаг, санхүү, бизнесийн мэдээ мэдээллийг бодитой мэдээллэхээс гадна иргэдийн эдийн засаг, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх нийгмийн шаардлага байгаа учраас www.mongolianeconomy.mn вэб сайт, “Economy” телевизийн студийг ашиглалтад оруулж байгаа тухай “Mongolianeconomy” сэтгүүлийн Орлогч эрхлэгч ▶



► И.Отгонжаргал онцолсон юм. Үйл ажиллагаа нь жигдрээд удаагүй хэдий ч өнөөдрийн байдлаар манай вэб сайт руу өдөрт дунджаар 1500 хүн ханддаг гэсэн статистик тоон мэдээ бий. Энэ тоог хэдэн зуу дахин өсөх цаг айсуй. Үүний төлөө л бид ажиллана бас зүтгэнэ.

Мэдээллийн эрин зуунд иргэдийг мэдээллээр бөмбөгдөхгүйгээр тухайн мэдээллийг судалгаа, анализтайгаар товч бөгөөд тодорхой хүргэх нь манай бусад сайтаас ялгарах онцлог хэмээн бид тодотгох дуртай. Үүнийгээ ч нээлтийнхээ үеэр онцолж, уншигчдадаа амласан болохоор чигийг алдахгүй ээ.

“Economy” студийн хүндэтгэлийн хойморт сэтгүүлийн шинэхэн дугаарууд зарларч, Дариа эгч тэргүүтэй манайхны чимэг болгож “урласан” улаан, цэнхэр бөмбөлөгүүд эдийн засаг, санхүүгийн мэдээллийн манай үндсэн өнгүүдтэй өнгө хоршоод тун ч донжтой хийгээд дулаан уур амьсгалыг бүрдүүлж байсныг хэлэхгүй өнгөрч болохгүй нь.

Талхны үнэ, тариа будаа, мах сүү гээд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн манай вэб сайт, студийн сэдэв. Мөнгө, төсвийн бодлого, экспортын татвар, эдийн засгийн өсөлт ч манайхны өнөөдөр, маргааш бичиж сурвалжлах ажил. Орон сууц, аж үйлдвэржилт, бүтээн байгуулалтын хөтөлбөрүүд хөндөх асуудлуудад багтана. Хөгжлийн банк, зээлийн хүү, хөрөнгийн бирж, хувьцаа, бондын арилжааг “Mongolian Economy” онцолсоор ирсэн. Цалин, тэтгэвэр тэтгэмж өнөөгийн амьдралын хөшүүрэг учраас туурвиж, тунгаах шаардлага их ээ. Энэ мэтчилэн эдийн засгийн дагнасан сэтгүүл, вэб сайт, студиэрээ бичиж, нэвтрүүлэх асуудал мундахгүй. Үүрэх ёстой ажлын маань далайц өргөжин тэлж байгааг нээлтийн үеэр олон хүн ярилаа. Вэб сайт, ТВ студийн нээлтэд ТӨХ-ны Төр, хувийн хэвшлийн түншлэл, Концессын газрын зөвлөх С.Бэхбат ах уригдаж, бидний ажилд амжилт хүслээ.

Сэтгүүлийг маань амтархан унших эрхэм уншигч, захиалагч Та манай вэб сайтаас эдийн засаг, бизнес, санхүүгийн цаг үеийн мэдээ, мэдээллийг цаг алдалгүй авах бүрэн боломжтой боллоо. Мөн буйдан дээрээ тухалж, “Economy” телевизийн студийн асуудал хөндсөн сурвалжлага, нэвтрүүлэг, сонин содон ярилцлагуудыг цэнхэр дэлгэцээрээ үзэх боломж танд нээгдлээ. Манай студийн мэдлэг, мэдээлэл өгсөн нэвтрүүлгүүд бусад телевизийн сувгаар танайд зочилно. Сэтгүүл, вэб сайт, ТВ студи гээд эдийн засгийн мэдээ мэдээллийг танд болоод танай гэрт хүргэх тулгын гурван чулуу ийн нэгэн дор бүрдлээ. Тулгын гурван чулуун дээр тавьсан цай буцалж, чанасан хоол болдог гэдэг. Сүүн ерөөлтэй вэб сайт, ТВ студийн нээлтийн үйл ажиллагаанд маань цаг нартай уралдаж, байнгын завгүй гүйдэг мэргэжил нэгт сэтгүүлч нөхдүүд маань хүрэлцэн ирж, бидний шинэхэн үйл ажиллагааг дэмжин олон нийтэд мэдээлсэнд талархаж буйгаа илэрхийлье.

Mongolianeconomy.mn вэб сайтыг ашиглалтад оруулах их ажлын голыг нь нугалсан “Mongolian Economy” сэтгүүлийн дизайнер Ш.Оюундарь эгчийнхээ баярын сэтгэгдэлийг нь сонирхлоо.

“Синглтон” компанийн хамт олонд баярлалаа

-Студи, вэб сайт харьцангуй богино хугацаанд ашиглалтад орж байгаа нь манай хамт олны хүч хөдөлмөр юм. Манайх эдийн засгийн мэдээллийг уншигчдадаа цаг алдалгүй хүргэх зорилготой учраас бусад сайтуудаас өнгө төрх, чанартай мэдээ мэдээллээрээ ялгарч, таны байнга зочилдог вэб сайт байх болно. Мөн манай сайт англи- монгол хэл дээр хийгдсэн нь зөвхөн дотооддоо төдийгүй дэлхийн хэмжээнд танигдана гэж итгэж байна.

Сайтыг өнөөдөр хүлээж авах хүртэл сайжруулж жигдрүүлэл бараг хоёр сарын хугацаа орсон. Вэб сайт гэдэг бол зүгээр уншигчийн нүдээр харахад бол компьютерийн товчлуурууд дарах төдий үйлдэл хийгээд хүссэн мэдээллээ уншихад амархан санагддаг боловч яг мэргэжлийн түвшинд хийхэд их ур чадвар, техник шаардсан хүнд ажил байдаг юм байна. Бидний зүгээс анх гарсан хар зургийг ийм тийм болгоё гэсэн санал хүсэлтийг цаг тухай бүрт нь уриалгахан хүлээн авч, нягт хамтарч ажилласан “Синглтон” компанийн хамт олонд баярлалаа.

“Economy” студийн редактор Ц.Буянбат: Ногоон эдийн засгийг түлхүү сурталчилна

-Эдийн засгийн хөгжил хурдацтай явагдаж байгаагийн хэрээр нийгэмд ялангуяа иргэдэд эдийн засаг, бизнесийн мэдээлэл ихээр үгүйлэгдэж байна. Уул уурхай, хөрөнгийн бирж, үнэт цаасны зах зээл, Тавантолгойгоос иргэдэд тараагдах 1072 хувьцааг хэрхэн авч, өсгөх гадаад дотоодын хөрөнгийн биржийн арилжаанд шууд оролцох гэх мэт Монголын эдийн засагт хөрөнгө, санхүүгийн хөгжилтэй холбоотой шинэлэг үйл явдал олон өрнөж буй. Энэ бүхэнтэй холбоотой мэдээллүүдийг манай “Economy” студи цаг алдалгүй хүргэх болно.

Эдийн засаг, бизнесийн хамгийн чухал шинэ мэдээллийн орон зайд бид шуурхай хурдтай ажиллахыг гол зорилго болгож байгаа бөгөөд мөн ногоон эдийн засгийг түлхүү сурталчилна.

МҮХАТ-аас манай сэтгүүлийн зорилго, хүсэл тэмүүлэл, үйл ажиллагааг үнэлж Хэвлэл мэдээллийн салбарын 2011 оны онцлох entrepreneur буюу шилдэг сэтгүүлээр шалгаруулсанд урам зориг дүүрэн шинэ онтой золгож байна. Бидний уран бүтээл ч өрнүүн байгааг мэргэжил нэгт нөхдүүд маань хэлж, урмын үгээр шагнаж байв. ■

Амьдрал

Сүүлийн үед ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн тухай хүн бүр ярьдаг болсон. Гэвч энэ талын ойлголт, мэдлэг манайханд маруухан тул “ногоон” гэдгийг зөвхөн сурталчилгааны үг

болгон хэрэглэх нь цөөнгүй. Тиймээс манай сэтгүүл энэ удаагийн “Амьдрал” буланд аа ногоон хөгжилд хувь нэмрээ оруулж олонд үнэлэгдсэн хүмүүсийн тухай бичиж байна.

Ногоон амьдрал бэлэглэе



угаахад ашиглах хэрэгтэй гэнэ. Ононгийн ногоон хөгжилд хувь нэмрээ оруулах санаачлага цөөнгүй. Гэртээ байнгын нарийн ногоо тариална. Удахгүй цонхныхоо тавцан дээр төмс тариалах гэж байгаа гэсэн. Түүнчлэн хогоо ангилаад уутанд хийнэ. Онон маш эртэч тул үүр цайж, үнэгэн харанхуй хорвоог нөмөрч байх үеэр босдог ч гэрлээ үл асаах аж. Энэ бол түүний амьдралын хэв маяг. Үүнийг дэлхий нийт сүүлийн 20-иод жилийн өмнөөс “Ногоон амьдрал” гэж нэрлэдэг байна.

Ногоон амьдралыг цогцлоож чадсан энэ бүсгүйн хувьд Монголын хөрсөнд хараахан идээшиж амжаагүй байгаа ногоон хөгжлийн талаар өдгөө л нэр томъёо өгч яриад байгаа болохоос биш, дэлхий нийт тэр дундаа монгол уламжлалд энэ ойлголт эртнээс байсаар ирсэн гэж үздэг байна. Тэрбээр “Өнөөдөр дэлхий нийт шимт хөрснийхөө 80 хувийг бохирдуулж, шавхагдашгүй гэж үздэг байсан ус, агаар, хөрс гээд бүх зүйлийг шавхагдах хэмжээнд аваачсан хойноо ногоон хөгжил, эдийн засаг, боловсролын талаар яриад байна. Уг нь энэ бүхэн байсан ойлголт. Тэр уламжлалаа сэргээх л хэрэгтэй.

Өнөөдөр дэлхий дээр долоон тэрбум гаруй хүн амьдарч байна. Харин ирэх 15 жилийн дотор 15 тэрбум болтлоо өсөх талаар судалгаа гарсан. Гэтэл эх дэлхийн маань одоо буй нөөц боллоцоо 10 тэрбум хүнийг арай ядан тэжээх чадвартай. Өнөөдөр дэлхий дээр нэг минут тутамд нэг хүүхэд өлсгөлөнгийн улмаас нас бардаг гэдэг. Тэгвэл ирэх 15 жилд дээрх өлсгөлөнгөөр үхэж байгаа хүний тоо хэд дахин нэмэгдэнэ. Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд бид юу хийх ёстой вэ. Хамгийн нэгдүгээрт, хэмнэх ёстой” гэсэн юм. Түүнийг найз нар нь эмэгтэй хүн атлаа элдэв чамин алт мөнгөн эдлэлд шунадаггүй, хэтэрхий энгийн амьдардаг гэж шүүмжилдэг ажээ. Харин Д.Онон Үдлээд буцах хорвоог Үүрдийн юм шиг санаж. . . ганц олдох амьдралдаа ууж идэх, унтаж хэвтэхээс илүү бусдад хэрэгтэй сайхан зүйлд хувь нэмрээ оруулах хэрэгтэй талаар зөвлөдөг байна. Хүүхдүүдээ ч мөн өөрийн энэ үзэл санаагаараа хүмүүжүүлдэг аж. Саяхнаас ярьж эхэлсэн “Ногоон боловсрол” гэж үүнийг хэлэх биз ээ.

Д.Онон ажилдаа гарлаа. Тэрбээр өдгөө МҮХАҮТ-аас гурав гаруй жил хэрэгжүүлж буй “Органик Монгол” хөтөлбөрийн ерөнхий зохицуулагчийн ажлыг хийж байна. Хар багын л мод тарьж, хог цэвэрлэж, ургац хураалтын ажилд оролцож явдаг байсан учраас дотнын хүмүүс нь түүнийг “Манай байгаль хамгаалагч” хэмээн дууддаг байсан талаар найз нар нь дурсан ярина. Багын найзууд нь онож хочилжээ. Онон өдгөө ч Монгол орныхоо хаа нэгтээ мод, ургамал тарьж, ногоон үйлсийн талаар уриалж, ухуулан таниулж явна. Индианчуудын дунд “Бид энэ газар шороо, эх дэлхийгээ эцэг өвөгдөөсөө уламжилж бус ирээдүй

Д.Онон
/“Органик Монгол” хөтөлбөрийн ерөнхий зохицуулагч/

Өчигдөр шөнийн орсон борооны үнэр, өглөөний цэнгэг агаар, мандаж буй нарны хурц гэрэл, шувуудын жиргэх, моддын сэрчигнэх таатай мэдрэмж төрүүлнэ. Энэ бүгд Д.Ононгийн багын дурсамж. Түүний аз жаргалын ертөнц ийм л байсан ийм ч байлгахыг хүсдэг. Тэрбээр өөрийг нь хорвоод уйлж ирэхэд, дуулж тоссон тэр л үзэсгэлэнт сайхан байгаль дэлхийнхээ унаган төрхийг алдуулахгүйн төлөө хөдөлмөрлөж, бусдыг уриалан дууддаг нэгэн. Тиймээс тарьсан цэцэг нь дэлбээлэхэд баярлаж, гундвал санааширдаг тухайгаа хэлсэн.

Өглөө эртлэн босож хоёр хүүхдээ усанд оруулж усаа шууд бохирын шугаманд нийлүүлэхийг хүсдэггүй. Тухайн усанд алчуур энэ тэрхэн базаад асгах нь ч учир дутагдалтай. Хүүхдээ угаасан усаар ядаж шалаа

► хойчоосоо зээлж авсан” гэдэг үг байдаг. Тийм ч учраас бид үр хүүхдүүддээ цэцэгт ногоон тал, цэлмэг тэнгэр, тунгалаг ус гээд байгалийн сайхнаа үлдээх нь зайлшгүй шаардлага юм. Үүнийг “Ногоон ирээдүй” гэж нэрлэдэг болов уу.

Харин Ононгийн амьдралын болоод “Органик Монгол” хөтөлбөрийн уриа нь “Үр хойчдоо ногоон ирээдүйг өвлүүлэе”. Тэгвэл ногоон амьдралтай, ногооныг

хөгжүүлэхийн төлөө зүтгэж яваа энэ эмэгтэйн ярианд гарсан бүгдийг цогцоор нь буюу өргөн утгаар нь авч үзвэл “Ногоон хөгжил” болох нь мэдээж. Д.Ононгийн ногоон хөгжилд оруулсан хувь нэмрийг ногоон хөгжлийг ойлгодог, энэ чиглэлээр багагүйг хийхийг зорьдог холбогдох газрынхан үнэлж “Байгальд ээлтэй баатарлаг үйлстэн”, “Green Entrepreneur-2011” зэрэг нэр хүндтэй шагналын эзнээр тодруулжээ.

Гадныхныг гайхшруулсан нь

Р.Баярбат

/НҮБ-ын “Дэлхийн тогтвортой хөгжлийн баатарлаг удирдагч” шагналын эзэн/ :

Яг одоо шөнийн 02:00 цаг болж байна... Чишш, чимээгүй. Тэр нам гүм дунд ганцаараа сууна. Нүдээ аниад амьдралынхаа утга учрыг бясалгана. Тэрбээр сүүлийн 10 гаруй жил шөнө бүр бясалгаж байгаа аж. Эрдэмтдийн тогтоосноор хүн хоногт, найман цаг унтаж амрах нь тохиромжтой гэдэг. Үүнийг ч дэлхий нийт дагаж мөрдөх нь бий. Харин Р.Баярбат гэх 50 гаруй настай энэ эр сүүлийн 10-аад жилийн турш 24 цагт 30 минут л нойр авдаг байна. Гэхдээ ямар нэгэн өвчин аль эсвэл гаж нөлөөллөөс ангид өөрийн оршихуйдаа ойртож, шөнө бүр унтах цагийнхаа ихэнхийг бясалгал үйлдэхэд зориулдаг ажээ. Тэрбээр “Би асуултынхаа хариуг олох гэж бясалгадаг. Амьдралын хэмнэл, амьд байхын учир, үнэ цэнэ, эх дэлхийгээ яаж аврах гээд энгийн хэрнээ олон асуултын хариуг өөрөөсөө хайх нь миний хувьд аз жаргал” гэсэн юм.

Өнгөрөгч сард болсон НҮБ-ын Уур амьсгалын эсрэг дэлхийн нийтийн хурлын хүндэт индэр дээр АНУ-ын тэргүүн хатагтай Мишель Обама, “Битлз” хамтлагийн гишүүн ноён Жамес МкКартни, Төгс гэгээрсэн Их багш Чин Хай зэрэг дэлхийд танигдсан хүмүүстэй Р.Баярбат мөр зэрэгцэн зогсож шагнал авсан. Тэрбээр “Дэлхийн тогтвортой хөгжлийн баатарлаг удирдагч” шагналыг хүртэж, Монгол Улсын нэрийг гаргасан нь энэ. Тэрбээр “Би энэ шагналыг авах талаар огт мэдээгүй байсан. Хурлын өмнөх долоо хоногт албан бичиг ирж, баярт мэдээг хүлээж авсан даа. НҮБ-аас “Дэлхийн тогтвортой хөгжлийн баатарлаг удирдагч” шагналын эзнийг тодруулахдаа тусгай баг гаргаад дэлхийд нэрд гарсан оюун санааны хөтөч, уран бүтээлч, хүмүүнлэг үйлстэн, байгаль дэлхийд ээлтэй үйл ажиллагааг дэмжсэн, бусдад үлгэр жишээ болсон 21 хүнийг сонгон шалгаруулах үүрэг өгдөг юм байна билээ” гэж тодотгов.

Баярбат “Веган” буюу ногоон хооллолтыг эх орондоо сурталчилан таниулж, дэлхийн дулаарлын эсрэг үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан учир түүний хөдөлмөрийг үнэлсэн нь энэ ажээ. Эрдэмтдийн тогтоосноор нэг удаа “Веган” буюу ногоон хоол идэх нь дунджаар 340 гаруй литр ус хэмнэж, 170 мод тарьж, 1350 хүүхдийг



өлсгөлөнгөөс аварч байгаатай тэнцэх хэмжээний тусыг хүргэдэг аж. Одоогоор Р.Баярбат 2000 гаруй монгол хүнийг ногоон хоолтон болоход тусалсан байна. Түүнийг шагнал авахад, Өмнөд Африкийн бүгд Найрамдах Дурбан хотноо болсон Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг олон улсын бага хурлын зочид мэл гайхсан гэнэ. Тухайлбал, монгол хүнийг мах иддэг болохоос ургамлын гаралтай хоол өдөр тутам хэрэглэж, энэ нэр хүндтэй шагнал авах хэмжээнд очсон гэдэгт итгэж ядаж байсан аж. Олон улсын сэтгүүлчдэд Р.Баярбат “Монгол гэдэг үндэстэн өмнө нь одоо ч дэлхий нийтийн анхаарлыг татаж байна. Энэ удаа дэлхий нийтэд үлгэр дууриал болохуйц сайхан үйлээр дахин бөмбөрцгийн хүмүүсийн анхаарлыг татлаа” гэж омогшиж амжжээ.

Тэрбээр өмнө нь ганзагын наймаа хийж, хааяа найз нартайгаа нийлж, мах идэж, сархад зооглон найрладаг байсан үе бишгүй байсан тухайгаа цухас дурдсан. Харин өнөөдөр өдөртөө ганц удаа л ногоон хоол идэж, архи тамхи огт хэрэглэхгүй амьдарч байна. Өдгөө Р.Баярбат нь “Loving hut” цагаан хоолны, олон улсын сүлжээ рестораны Монгол дахь салбарын захирал. Төгс гэгээрсэн Их багш Чин Хайн “Олон улсын нийгэмлэг”-ийн Монгол дахь төвийн тэргүүн зэрэг албыг хашиж, мод тарих, эрүүл хүнс үйлдвэрлэх гээд ногоон хөгжилд өөрийн гэсэн хувь нэмрийг оруулж байна. ►►

► Хүй нэгдийн үеийнхнээс бид юугаараа илүү байгаа юм бэ

Д.Энхбат
/ШУТИС-ийн харьяа инновацийн газрын дарга/:

“Нар гар буугаа гарган CO₂-оор буудсан. Харин хүмүүс их буу гаргаж илүү их CO₂-оор буудаж байна” /“Халуун хавтгай хавчигдмал дэлхий” номоос ишлэв/.



Д.Энхбат профессор ногоон хөгжилд хувь нэмрээ оруулж CO₂-ын ялгарлыг өчүүхэн ч гэсэн багасгаж байгаадаа сэтгэл хангалуун хотын гудамжаар алхана. Эрдэмтэд сүүлийн 670 мянган жилийн турш CO₂ ихэсвэл уур амьсгал дулаарч, багасвал хүйтэрдэг гэдгийг тогтоосон байдаг. Д.Энхбат “Дэлхий дулаарсаар байна. Тэгвэл хүн төрөлхтөн юу хийх вэ. Хариулт нь маш энгийн ногоон хөгжилд хувь нэмрээ оруулах хэрэгтэй. Ногоон хөгжил гэдэг хамгийн энгийн бүгдээс эхэлдэг. Тухайлбал, илүүдэл хэрэгцээгээ багасгах ч байж болно” гэв. Онц шаардлагагүй бол гэрлээ унтраах, хогоо зориулалтын саванд хаях, мод, ургамал тарих, цагаан хоол идэх, усыг хэмнэж хэрэглэх, бясалгал хийх, явган алхах энэ бүхэн түүний хувьд ногоон хөгжилд хувь нэмрээ оруулж байгаа томоохон тус аж.

Өнөөдөр дэлхийн дулааралд нөлөөлж байгаа гол хүчин зүйлүүдийн нэлээд дээгүүрт мал, амьтны бааснаас ялгарч байгаа метан хий аж. Харин өдгөө хүн төрөлхтөн мах идэж, гутал хувцас хийхийн тулд жилдээ 56 тэрбум мал, амьтан нядалж 275 сая тонн мах хүнсэндээ хэрэглэдэг байна. Энэхүү хэрэглээгээ хангахын тулд мал, амьтныг хэмжээнээс нь ихээр өсгөж, өсгөхийн тулд бэлчээрийн даацаа хэтрүүлж, аль эсвэл химийн аргаар бордон хөрсийг хордуулж буй аж.

Энхбат дарга ч бусад ногоон хөгжлийг эрхэмлэгч үйлстнүүдийн адил үүрийн таван жингээр нойрноос сэрж, буян нүглийн талаар эргэцүүлдэг. Мөн өдөр бүр ногоон хоол иддэг ч өнөөдөр бүр мацаг барихаар шийджээ. Энэ нь Та өдөрт нэг килограмм мах идэхгүй мацаг барьж байгаа бол 40 тн ус хэмнэж байгаа хэрэг аж. Эрдэмтдийн судалгаагаар нэг тугалыг мах бэлтгэлд явуулах хүртэл 40 гаруй тн ус зарцуулдаг байна. Тэрбээр “Хүн төрөлхтөн өдгөө долоон тэрбум болтлоо өссөн. Гэхдээ хэрэглээний хувьд долоон их наяд хүний хэрэглэх хэмжээний бараа бүтээгдэхүүн болоод биет, биет бус хэрэглээг хэрэглэж

байна гэсэн судалгаа байдаг. Тиймээс бид илүүдэл хэрэглээгээ багасгах хэрэгтэй” гэлээ.

Түүхийн явцад шашин, шинжлэх ухаан хоёр нэгнийгээ үгүйсгэж ирсэн. Харин Д.Энхбат шинжлэх ухааны талын хүн боловч Монгол зан заншил, бурхан шашин, шинжлэх ухаан гурвыг нягтлан, хоорондын адил төсөөтэй болон нэгнийхээ дутууг нөхөж чадах эсэхийг шинжилж байгаа аж. Түүний хэлснээр, шинжлэх ухааны аргаар, дэлхий дулаарч байгаа, хөрсний бохирдол аюултай хэмжээнд хүрлээ, цэвэр усны нөөц хомсдолоо энэ бүхэн болохгүй бүтэхгүй зэрэг талаар сануулж, нээн илрүүлсэн хэрэг. Зарим талаар эдгээрийн эсрэг шинжлэх ухааны үндэслэлтэй арга хэмжээ авдаг гэхдээ үр дүн бага, зарим асуултынх нь хариу олдохгүй байна. Харин бурхан шашны хувьд нүгэлийг тэвчих, буян үйлдэх. Монгол зан заншлын тухайд булагийн эхэнд хиртэй хувцсаа угаахгүй байх, нүүхдээ бууриа заавал цэвэрлэх ёстой зэрэг нь ногоон хөгжлийн энгийн жишээ бөгөөд дээрх олон асуултын хариулт, гарц юм. Нэгэнтээ Алберт Эйнштейн “Шинжлэх ухаангүй шашин сохор, шашингүй шинжлэх ухаан доглон” гэж хэлсэн нь бий.

Тэрбээр “Бид хүй нэгдлийн үед амьтны махаар хооллож, хог новшоо хаа нэгтээ замбараагүй хаядаг байсан. Харин өнөөдөр бид XXI зууны соёлт нийгэмд амьдарч байгаа. Гэхдээ өдгөө хүртэл амьтны мах идэж, арьс ширээр нь хувцаслаж, хогоо замбараагүй хаяж, модоо огтолж, газраа ухаж байна. Тэгэхээр бид хүй нэгдлийн үеийнхээс юугаараа илүү байгаа юм бэ. Товчхондоо бид хэрэглээгээ хангахын тулд зохион байгуулалттай, эх дэлхийдээ хортой үйл ажиллагаа явуулаад байна” гэсэн юм.

Харин Энхбат доктор ингэж амьдрахыг хүсдэггүй. Тиймээс хүн бүр хэрэглээгээ багасгаж, буруутай үйлдлээ зогсоох нь байгаль орчноо хамгаалах хийгээд ногоон хөгжилд оруулж буй бидний хувь нэмэр билээ. ■

Эрсдэлийн менежмент

“Хэрвээ ингэвэл яах вэ” гэдэг асуултад хариулж чаддаг бол

“Мандал Женерал даатгал” компаниас эрсдэлийн удирдлагын форум зохион байгуулсан билээ. Дөрвөн хэсэгтэй болсон тус форумын эхний хэсэгт төрийн байгууллагуудын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд хийж буй арга хэмжээ болон цаашдын чиг хандлага ямар байх. Эрсдэлийн менежментийн хэрэгжилт, ахиц дэвшил бизнесийн салбарт ямар ашиг тус үзүүлэх вэ? Улсын эрсдэлийг багасгахын тулд төрийн болон хувийн хэвшлийнхэн хэрхэн хамтран ажиллах нь зүйтэй гэх мэт асуудлаар илтгэл тавьж, тухай бүрд нь хэлэлцүүлэг

өрнүүлж, санал бодлоо илэрхийлэх боломж олгож байсан. Харин бусад хэсэгтээ бизнесийн салбарынхны эрсдэлийн менежментийг хэрэгжүүлж буй байдал болон тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлоход чиглэсэн илтгэлүүд тавьж, өөр өөрсдийн салбарынхаа эрсдэлийг тодорхойлж, багасгах тал дээр үйл ажиллагааны цар хүрээг танилцуулсан юм. Хурал зохион байгуулагчид болон оролцогчдын төлөөллөөс эрсдэлийн менежмент гэж юу болох, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх нь оновчтой болох талаар тодрууллаа.



Ө.Ганзориг



Д.Жаргалсайхан



Жон Вийдон



Стефен Клай

Эрсдэлийг алхамтайгаа нийцүүлэн нөлөөллийг нь бууруулж байх ёстой

Ө.Ганзориг/“Мандал Женерал даатгал”компанийн ерөнхийлөгч/:

-Хүний амьдралын алхам бүр эрсдэлийг дагуулж байдаг. Тухайн эрсдэлийг алхамтайгаа нийцүүлэн нөлөөллийн хүчийг нь бууруулж байх хэрэгтэй. Эрсдэл бидний амьдрал

байнга оршдог. Энэ бол иргэн хүнээс эхлэлтэй асуудал. Эрсдэлийг тооцно гэдэг бол үерийн аман дээр очоод гэрээ бариад суучихгүй байхыг хэлнэ.

Тухайн албан байгууллага бүр эрсдэлийн сайн удирдлагатай байснаар үндэстний хэмжээнд маш том ач холбогдолтой гэдэг үүднээс энэ форумыг зохион байгуулж байна. Монгол Улсын хувьд энэ хэмжээнд хүрэх арай болоогүй байна. Байгууллага болгон өөрийн үйл

► ажиллагаандаа тохирсон эрсдэлийн бодлого, чиглэл, мэргэжилтнүүдтэй байх хэрэгтэй. Сүүлийн үед төрийн байгууллагууд бие даасан хэлтэстэй болж байна. Нийгэм дэх эрсдэл бага байх тусам даатгалын компанид ашигтай шүү дээ. Төрийн нэгдсэн бодлого хэрэгтэй байна л даа. Одоо бидэнд тулгамдаад байгаа асуудал нь Төрийн мэдээллийн нэгдсэн санг байгуулах явдал юм. Ингэснээр олон асуудлын үүсвэрийг тодорхойлж өөрсдийн үйл ажиллагааны эрсдэлийг тооцоолно.

Төр эрсдэлийг бууруулах чиглэлээр ажиллахгүй байна

Д.Жаргалсайхан /Эдийн засагч/:

-Улс орон баяжихын хэрээр эрсдэл нэмэгддэг. Иймээс энэ бол тохиолдлын биш уулзалт юм. Эрсдэл нийгмийнх, компанийн гэх мэт олон төрөл байдаг. Аюулгүй байдлыг нэг хүн дээр тусгайлан бий болгож болдоггүй, бүхнийг хамардаг зүйл. Эрсдэл нь хүн бүрийн, айл өрх болгоны байгууллага төр, засаг бүгдийн анхааралдаа авах асуудал юм. Яг л эрүүл мэнд шиг урьдчилан сэргийлэх аргаа зөв сонгох хэрэгтэй. Бүх түвшинд хэрвээ ингэвэл яах вэ? гэдэг асуултад хариулж чаддаг болсон байх хэрэгтэй юм.

Төр хүний эрх, хөрөнгө, аюулгүй байдлыг хамгаална гэсэн үндсэн гурван үүрэгтэй. Аюулгүй байдлыг хамгаалах биш, болгохгүйн төлөө, болчихвол яах вэ гэдэг тал дээр төлөвлөж сурах ёстой. Онцгой байдлын албаны хүний тавьсан илтгэл дээр гарлаа шүү дээ. Гурван газар гал гарвал тэрэнд хүрэх хүн, хүч байхгүй тухай. Төр хийхгүй байна, хариуцлагагүй байна. Энэ бол бидний болон үр хүүхдийн маань амьдралын баталгаа шүү дээ. Иймээс бид шаардах хэрэгтэй.

Санхүүгийн эрсдэл гэдэг бол өөрөө мөнгө

Стефен Клай /ХААН банкны Эрсдэл хариуцсан захирал/:

-Банкны салбарт “Мөнгөө зээлээд дараа нь эргүүлж авч чадахгүй бол яах вэ” гэдэг л ганцхан эрсдэл байдаг гэж боддог л доо. Гэвч үүнээс гадна 22 төрлийн эрсдэл байдаг. Ямар ч эрсдэл байсан хамгийн түрүүнд эрсдэлийг таних хэрэгтэй. Дараа нь хэр хэмжээний нөлөөлөл үзүүлэх вэ гэдгийг тодорхойлж даван туулах чадварыг тогтооно. Тухайлбал, банкны өдрийн тайлан тэнцэл бараг байнга л зөрдөг. Гэвч тэглээ гээд банкны үйл ажиллагаанд хүчтэй нөлөөлөхгүй учир үүнийг ноцтой эрсдэлд тооцохгүй л дээ. Бидэнд томоохон эрсдэлд орвол яах вэ гэсэн төлөвлөгөө бий. Энэ нь бид эрсдэлийг хүлээж авах улмаар даван туулж хэрхэн хэвийн үйл ажиллагаандаа буцан орох вэ гэдэг байгаа юм. Санхүүгийн эрсдэл гэдэг бол өөрөө мөнгө. Мөн санхүүгийн бус эрсдэл гэж бий. Энэ нь өрсөлдөгчид болон мөнгөө хадгалуулагч болон зээлдэгчид байдаг. Эрсдэлийг хэр сайн тооцоолно тэр чинээгээр амжилтын баталгаа хангагдана гэсэн үг.

Монголд бизнесийн үйл ажиллагаагаа явуулж байгаа олон компани суурь сайтай ар талтай учир бүрэн утгаар нь хэрэгжүүлж эрсдэлийг хүлээж авч чадаж байна. Иймд хэдийгээр шинэ ойлголт хэдий ч томоохон гаднын хөрөнгө оруулагчдын олон жилийн арга туршлага ихээхэн тус болж байна гэж хэлж болохоор байна. Нартай өдрүүд байхад бороотой өдөр бас бий. Тэгэхээр хэцүү үеийг даван туулах бэлтгэлийг цаг сайхан байхад л хийх хэрэгтэй юм **100 хувь эрсдэлийг тооцож, давж гарна гэж байхгүй**

Жон Вийдон /“Оюутолгой” компанийн Эрсдэлийн удирдлага, хэрэгжилт хариуцсан менежер/:

-Эрсдэл гэдэг бол ерөөсөө л ирээдүйг тааварлах асуудал юм. Юун түрүүнд эрсдэлээ оновчтой зөв тодорхойлох шаардлагатай. Үргэлж яв цав тохируулсан төлөвлөгөө гэж байхгүй л дээ. Өөрөөр хэлбэл, эрсдэлийг 100 хувь тооцно, давж гарна гэж байхгүй. Гэвч ихэнх алдаа эндэгдлийг засан сайжруулна л гэсэн тооцоолол байдаг. Ирээдүйд Оюутолгой, Тавантолгойг дагасан олон өөрчлөлт гарах нь мэдээж. Үүний нэг нь энэ чиглэлийн эрсдэлийн удирдлагын хурдацтай хөгжлийн асуудал байх болов уу. Бидний хувьд хэдэн зуун том, жижиг эрсдэл бий. Бид урьдчилан томоохон эрсдэлүүдийн нөлөөллийг багасгах тал дээр ажилладаг. Тухайлбал, газар хөдлөлт боллоо гэж бодоход бидний бүтээн байгуулалт тэсэж чадах уу эсвэл болох нь тодорхой болвол хэрхэн урьдчилан сэргийлэх вэ гэдэг ч юм уу. Ирэх жилээс мэргэжилтнүүд авчрах бодолтой байна. Гэхдээ нэн түрүүнд энэ талын дотоодын боловсон хүчинг 2012 оны эхний улирлаас сургах, өөрийн мэдлэгээ шилжүүлэх тал дээр бэлтгэж байна. Өөрөөр хэлбэл, инженер хуульчдаас бүрдсэн цогц баг бий болгохыг зорьж байна. Эрсдэлийн удирдлага нь нэг, хоёр өдрийн дотор бүрэн утгаараа хэрэгжээд төлөвшчих зүйл биш л дээ. Дор хаяж хоёр гурван жил хэрэгтэй.

Эрсдэлийн удирдлагыг Монголдоо зөв нутагшуулах тал дээр ажиллаж байна

Д.Оюунчимэг/ ГЕГ-ын дэд дарга/:

Энэ форумгаар гаалийн байгууллага бизнесийн салбарыхантай хамт суугаад түншлэлийн замаар худалдааг хөнгөвчилж барааны эргэлтийг яаж түргэсгэх вэ гэдэг асуудлыг шийдвэрлэх боломжийг олгож байна. Бид эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж эхэлснээр үйл ажиллагаа илүү оюунлаг, шинжлэх ухааны үндэстэй болж ирсэн юм. Гэвч энэ нь бидний хяналт шалгалт суларна гэсэн үг биш л дээ. Барааг эзэнд нь олгочихоод дараагаар нь шаардлагатай гэж үзвэл бүрдүүлэлтийн дараах шалгалтыг хуулийн дагуу хийх боломжтой. Нүүр тулсан гаалийн байгууллагын ажилтны харилцаанд эрсдэлийн удирдлагыг оруулж ирснээр өөрчлөлт гарч байгаа. Учир нь, тэд системийн дохио өгсний дагуу л шалгах болсон юм.

Өөрөөр хэлбэл, хяналт шалгалтаа зөв зохистой явуулах, худалдааг хөнгөвчлөх гэсэн энэ хоёр үүргийг тэнцвэржүүлэх боломжтой болсон гэсэн үг л дээ. Дэлхийн гаалийн байгууллагын туршлагын дагуу эрсдэлийн удирдлагыг судалж Монголдоо зөв нутагшуулах тал дээр өөрсдийн ажлаа чиглүүлж байна.

Эрсдэлийн эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулна

Хурлын дараагаас Монголын эрсдэлийн институци байгуулахаар болсон юм. Монголын анхны хувийн хэвшлийн санаачлага хэдий ч төрийн болон олон улсын байгууллагууд дэмжигчээр оролцоно гэдгээ илэрхийлсэн байна. Тус байгууллага нь Монголын эрсдэлийн эрдэм шинжилгээний хүрээлэн хэлбэрээр ажиллах бөгөөд эрсдэл хаанаас үүсэж байна вэ, хэрхэн бууруулж болох вэ гэдэг асуудал дээр дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа аж.

Эрүүл мэнд

Чимээгүй тахалтай өдөр бүр тэмц



Гэр бүлээрээ анхан шатны ойлголттой болсон нь

Ээжээс минь дутуугүй ач, зээгээ энгэртээ тэвэрч өсгөсөн эмээ минь таван жилийн өмнөөс чихрийн шижинтэй гэж оношлогдсон юм. Турах, амархан ядрах, ам нь цангах гээд сахарын өвчний шинж тэмдэг бага багаар л илэрч байж. Тухайн үед өвчний хэлбэр далд байсныг нь даанч мэдээгүй. Сумын эмч төдийлэн анзаараагүй юм билээ. Мөнөөх л бидний хайхрамжгүй, хайнга, эрүүл мэндээ нэгт бус хоёрдугаарт тавьдаг зангаас болсон гэх үү дээ. Өөрөө өөртөө эмч байх нь бидний үүрэг болчихсон өнөө үеэс таван жилийн өмнөх нөхцөл байдал арай л өөр байсан юм. Чихрийн шижингийн өвчлөлийг бууруулахаар Эрүүл мэндийн яамны урсгал зардалд хөрөнгө мөнгө төсөвлөдөггүй байжээ. Орон нутагт бол сахарын өвчний талаар иргэд битгий хэл, эмч нар нь ч сайн ярьдаггүй байв.

Эмээ маань сахартай гэсэн онош тогтоолгон байнгын эмчийн хараа хяналтад байж, идэж, уухаа хүртэл цэгнэх болсон. Тэрбээр Улаанбаатар хотод шилжин ирээд, Чингэлтэй дүүргийн харьяат иргэн болсон юм. Тус дүүргийн эмнэлэг чихрийн шижинтэй тэмцэх гарын таван хуруунд багтах эмчтэй.

Эмээгийн идэх хоол нь хүртэл хэмжээ, хязгаартай. Хар талх, хоёрдугаар гурил, байцаа гэсэн хэдхэн төрөлд эргэлдэж түүндээ дасах гэж чамгүй ядарсан. Байнга уудаг сүүтэй цайг нь хүртэл хориглож байв. “Идэх юм олдохгүй юм аа, хүү минь. Бүгдийг болохгүй л гээд байх юм” хэмээн заримдаа очиход бухимдангуй суудагсан.

Энэ үеэс л манай гэр бүл чихрийн шижин гэх өвчний талаар “анхан шат”-ны ойлголттой болж, уг өвчний эсрэг гэр бүлээрээ тэмцэж эхэлсэн. Сахарын

хэмжээг их бага байгааг тогтоох тест, зүү, эм зэрэгт жилдээ 400 орчим мянган төгрөг зарцуулдаг болохыг дүү маань хожим тооцож үзсэн байна билээ. Чихрийн шижинтэй хүний идэхийг хориглосон хоол хүнсний жагсаалт дотор эмээгийн маань хамгийн дуртай хонины мах хүртэл багтдаг. Гэтэл хамгийн дургүй адууны махыг бага хэмжээгээр хэрэглэж болно гээд заачихаж. Тэгэхээр монголчуудын өөхтэй мах идэх нийтлэг хүсэл нийтээрээ чихрийн шижинтэй болоход нөлөөлж болзошгүй юм.

Ийм төрлийн өвчинтэй хүний хамгийн хатуу чанга мөрдөх зүйл нь хооллолт. Тийм болохоор хоол хүнсний хувьд таван жилийн өмнөхтэй харьцуулахад одоо харин сонголттой болжээ. Сахарын өвчинтэй хүнд зориулсан эмчилгээний зориулалттай бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэгчид үйлдвэрлэх болсон нь тун нүдээ олсон хэрэг. Сахартай хүнд зориулсан амттан шимттэнийг хүртэл манайхан импортлож байна.

“Чихрийн шижинтэй тэмцэх дэлхийн өдөр” жил бүрийн арваннэгдүгээр сарын 14-нд тохиодог. Энэ өдөр Төв талбайд ЭМШУИС-ийн оюутнууд тус өвчний эсрэг “Цэнхэр цагираг” жагсаал зохион байгуулж, өвлийн жаврыг үл ажран иргэдийг энэ аюулт өвчний эсрэг уриалсан юм. “Эрүүл мэндийг сонгоё” гэсэн ухуулах хуудас нааж яваа оюутнууд иргэдийн эрүүл мэндийн манаанд зогсох, ирээдүйн эмчийнхээ хөдөлмөрийг үүгээр нээсэн байх. Харин Улсын клиникийн төв эмнэлгийн Диабетийн төвөөс өөрийн байрандаа өдөрлөг зохион байгуулж, чимээгүй тахлын эсрэг тэмцсэн.

XIX зууны сүүлчээр “Diabetes mellitus” буюу чихрийн шижин өвчин дэлхий нийтийг айлгах болж. Хэт таргалалтын учир шалтгаан нь эл өвчинтэй холбоотой байна. Дэлхий дээр уг өвчнөөс болж найман секунд тутамд нэг хүн хорвоог орхиж байгаа гэсэн тоон мэдээлэл байна. Өдгөө тус өвчний тархалт дэлхийн хэмжээнд өсөж, өвчлөл нас баралтаараа зүрх судас, хорт хавдрын дараа орж байгаа гэсэн түгшүүртэй мэдээ бий.

ДЭМБ-ын статистикийн мэдээнээс үзэхэд чихрийн шижин өвчний тархалт 15 жил тутамд хоёр дахин нэмэгдсэн байна. 2010 оны байдлаар цэнхэр гариг дээр 285 сая хүн ийм төрлийн өвчнөөр өвчлөөд байгаа бол 2030 он гэхэд 436 саяд хүрэх магадлалтайг Олон улсын диабетийн холбооноос мэдэгдсэн ажээ. Дэлхий нийт уг өвчлөлийн хурдыг сааруулж, урьдчилан сэргийлэхийн тулд зохистой хооллолт, хөдөлгөөнийг илүүд үзэх болжээ. Их Британи улс чихрийн шижинтэй иргэддээ цусан дахь сахар хэмжих аппаратыг үнэгүй олгож, зөв хооллолт, хөдөлгөөнтэй байдлыг эрэлхийлэх болсон байна. Харин монголчууд чихрийн шижинтэй хэрхэн тэмцэж байгаа билээ. ▶▶

► Өвдөхгүйн тулд давсны хэрэглээгээ багасгаж байна



“Цусан дахь сахарын хэмжээг ихэсгэдэг бодисын солилцооны өвчнийг чихрийн шижин гэнэ” хэмээн Диабетийн төвөөс гаргасан эмхэтгэлд тэмдэглэжээ. ЭМЯ, Монголын мянганы сорилтын сангийн Эрүүл мэндийн төслөөс “Зохистой хооллолт, идэвхтэй хөдөлгөөн” олон нийтийн кампанит ажлын хүрээнд “Амьдралын зөв хэвшилд алхам алхмаар” зөвлөмжийг гаргажээ. Үүнд тэмдэглэснээр насанд хүрсэн хүн бүр хоногт 25 грамм эслэг бүтээгдэхүүн хэрэглэвэл зохимжтой хэмээн үзжээ. Эслэг бүтээгдэхүүнд хоёрдугаар гурил, хивэг зэрэг аль болох химийн найрлага төдийлэн ороогүй зүйл багтах нь. Мөн төрөл бүрийн жимс, хүнсний ногоо нь зохистой хооллолтын суурь бүтээгдэхүүн болохыг онцолсон байна. Өдөрт дор хаяж таван удаа жимс, ногоо идэх хэрэгтэй болохыг ч зөвлөжээ. Хэдий бид “хүнд хоол” буюу махан хоолыг түлхүү хэрэглэдэг ч эрүүл хооллолтод дадаж хэвших шаардлага тулгарч байна. Хар чавга, алим, лийр, өргөст хэмх, лууван, үзэм зэргийг хоол хүнсэндээ хэрэглэж байхыг ч эмч зөвлөж байна лээ.

Чихрийн шижин өвчнөөс урьдчилсан сэргийлэх зөвлөгөө

- 1.Идэвхтэй хөдөлгөөнтэй байх, өдөр бүр хамгийн багадаа 30 минут алхаж, гүйх. Спортоор тогтмол хичээллэж байх.
- 2.Хоолондоо давс бага хэрэглэж цайгаа давсгүй уух
- 3.Архи, тамхины хэрэглээг хязгаарлах
- 4.Хоолондоо мал, амьтны гаралтай өөх, тосыг бага хэрэглэж хэвших
- 5.Төмснөөс бусад ногоог хоолондоо түлхүү хэрэглэх
- 6.Биеийн жин хэвийн эсэхээ шалгаж байх

Яагаад чихрийн шижингээр өвчилдөг вэ?


Чихэр, сахар их идэж хэрэглээгүй атал яагаад чихрийн шижин өвчинтэй болдог билээ хэмээн иргэд гайхширдаг. Гэтэл уг өвчин нь чихэр, чихэрлэг бүтээгдэхүүн их хэрэглэхээс илүүтэй, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй болохыг эмч нар хэлж байна. Зохисгүй хооллолт, сэтгэл гутрал, таргалалт, удамшил, тамхи татах, архи хэтрүүлэн хэрэглэх, хөдөлгөөний хомсдол нь чихрийн өвчинд өртөх суурь шалтгаан болдог ажээ.

Хэрэв Та өвчилсөн бол дараах зөвлөгөөг анхаарна уу

“Нийгмийн бухимдал, хотжилт, ажлын стресс, хэт суугаа ажил эрхлэлт, ажилгүйдэл, хүнс тэжээл дэх байгалийн гаралтай хүнсний хэрэглээ багасгаж байгаа нь мөн л дээрх өвчний тархалт дэгдэхэд нөлөөлж байна” хэмээн Улсын клиникийн төв эмнэлэгийн Дотоод шүүрэл булчирхайн эмч Ц.Бодьцэцэг хэлсэн юм. Тэрбээр уламжлалт хооллолтын соёл алдагдаж байгаа нь сахарын өвчлөл нэмэгдэх шалтгаан болж байгааг санууллаа.

Бид өвдөж, ёолох үедээ л эмнэлэг, эмч хоёрыг санадаг. Унаж, сөхөртлөө ажиллаж, бодгаль биеэ төмөр мэт бодох нь энүүхэнд. Хожим нь эрүүл мэнд хэмээх том хөрөнгөө алдсан байх нь харамсаад ч барамгүй. Тиймээс өвдөхөөсөө өмнө эмнэлэг, эмч хоёртой “найз” баймаар санагдлаа. Чихрийн шижингээр өвчилсөн монгол хүний тоо өдгөө 20 дахин нэмэгдсэн байна. 1999 онд үндэсний хэмжээний тархалтын судалгаагаар хүн амын гурван хувь нь ийм төрлийн өвчтэй байсан бол 2009 оны судалгаагаар 6.5 хувьд хүрээд байгаа аж. Арван жилийн дотор уг өвчлөл эрүүл мэндийн тулгамдсан асуудал болсныг харуулах том тоо байгаа биз. Сүүлийн жилүүдэд эдийн засаг өсөж, иргэдийн орлого нэмэгдэж, цалин тэтгэвэр өссөн хэдий ч өвчлөл буураагүй 20 дахин нэмэгдсэн байгаа нь анхаарал татна. Олсон хэдэн төгрөгийнхөө хэчнээн хувийг нь бид эрүүл байхад зарцуулж байгаа билээ гэж бодоход хүрлээ. Хамрын ханиад хүрэхэд эм тан сурагласан болоод хагас дутуу эдгээх нь монгол зан байж мэдэх. Үнэт биеэ үнэгүй үрэх, үл хайрлах нь даан ч бидний дутагдал гэмээр. Өвдөхгүй л бол эрүүл гэсэн онош өөртөө тавьдаг. Идэх, идэхгүй хоол хүнс хэрэглэнэ. Болж өгвөл эмнэлгээс “зугатна”.

Эмнэлгийн үйлчилгээг муулж, чичлэхээсээ илүүтэй иргэд өөрсдийнхөө эрүүл мэнддээ анхаарах нь чухал болжээ. ■



Бизнес зөвлөгөө

Ногоон аж ахуйн нэгж- амжилтын үндэс

Хүн төрөлхтний улам бүр өсөн нэмэгдэх хэрэглээ, өдрөөс өдөрт буурах байгалийн нөөц баялаг, он жилээр үргэлжлэх эдийн засгийн хямрал дэлхийн хэмжээнд нүүрлэн айсуй. Гэсэн хэдий ч байгаль орчин ба өөрсдийн ирээдүйдээ хөрөнгө оруулах нөхцөл байдал аж ахуйн нэгжүүдийн хувьд одоогийнхоос хэзээ ч илүү сайн байгаагүй. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас тохиох болсон үй олон тооны байгалийн гамшиг бид бүгдэд нэгийг өгүүлнэ. Тэр

нь юу вэ гэвэл байгаль эхэд хүн биш, харин хүнд байгаль зайлшгүй хэрэгтэй аж. Иймээс байгаль орчноо хамгаалах нь тогтвортой байдалд оруулах хувь нэмэр төдийгүй, зөв стратегийг ашиглаваас компаниудын урт хугацааны турш ашигтай оршин тогтнохын үндэс юм. Энэ удаагийн бизнесийн зөвлөгөөг аж ахуйн нэгж, компаниудын тогтвортой үйл ажиллагаанд зориулж бэлтгэлээ.



Ажлын байраа хэрхэн “ногоон” болгох вэ?

- Дахин боловсруулсан цаасыг хэрэглэ. Мөн зөвхөн шаардлагатай бичиг баримтыг бичгийн цаасныхаа хоёр тал дээр хэвлэж байх.
- Хурал цуглаан, үдийн цайны завсарлага, аливаа арга хэмжээний үед ажлын албан тасалгааныхаа гэрэл, компьютер, хэвлэгч машин, скайнерыг унтрааж сурах. Тооцвоос: өдөрт нэг цаг гэж бодоход, долоо хоногийн турш тав, сард 20, жилд 250 цаг эрчим хүч хэмнэх бүрэн боломжтой. Хуралд орохдоо харин Та тэмдэглэл бичих цаас, харандаа үзгээ мартуузай.
- Уншиж дууссан, танд болон танай оффист хэрэггүй болсон сонин, сэтгүүлээ урж хаяхын оронд цуглуулаад, үйлчилгээний газруудад тарааж өгч байвал хоёр талдаа ашигтай. Шүдний эмнэлэг, гоо сайхны салоны үйлчлүүлэгч нар гээд л хүлээлтийн цагаа ашиглаж ертөнцийн сонин сайхныг олж мэдэхийг хүссэн хүмүүс хаа сайгүй байдаг даа.
- Ажлын өрөөгөө тасалгааны цэцгээр чимээрэй. Энэ нь гоё харагдаад зогсохгүй тасалгааны агаарыг

цэвэршүүлж, Таны эрүүл мэндэд сайнаар нөлөөлнө.

- Сэрүүцүүлэх төхөөрөмж, хөргөгч, кофены машин, хоол халаадаг цахилгаан зуухыг өнөө үед томоохон оффисууд хэрэглэдэг нь хэвийн үзэгдэл болсон боловч эрчим хүчинд хэмнэлттэй загварыг сонгоорой.
- Онгоц, машинаар очиж хэн нэгэнтэй хоромхон зуур уулзахын оронд мэдээллийн технологийн тусламжтайгаар аудио эсхүл видео хурал хийж, утсаар яриваас зардал хэмнэнэ.
- Ажлын байрны гэрлийн шилүүдийг эрчим хүчинд хэмнэлттэй шилээр солих.
- Албан газрын ариун цэврийн өрөөний суултуурт ус хэмнэгч нэмэлт төхөөрөмж суурилуулах.
- Танай ажлын байранд ногоожуулсан хэсэг байгаа бол тэр хэсэгтээ ургамал тарьж, шувуу үүрлэн амьдрах таатай орчныг бүрдүүлэх.
- Пестицид, хүлэр, хор хөнөөл учруулж болох цэвэрлэгээний шингэн зэрэг байгаль орчинд хортой бүтээгдэхүүн худалдаж авахаас зайлсхий. ■

Эх сурвалж: smallbiztrends.com, http://www2.wwf.fi/green_office/guidelines_for_the.html

Бизнесийн завсарлага

Та ямар Ногоон ном уншихыг зөвлөх вэ?

Д.Доржсүрэн

/Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга/:

Пулитцерийн шагналыг гурван удаа хүртсэн сэтгүүлч, тоймч Томас Л.Фрийдманы бичсэн “Халуун, хавтгай, хавчигдмал дэлхий” номыг уншихыг зөвлөж байна. Өнөөгийн дэлхий ертөнцөд хамт шийдэх, хамтын хариуцлагыг сөхөж гаргах чухал байна. Дэлхийг нэг хөлөг онгоц гэж авч үзье. Онгоцны нэг хэсэг шатаж, эсвэл эрэг боолт нь тасраад байвал тус хөлөг онгоц живж эхэлнэ. Иймээс эх дэлхийгээ хайрлаж хамгаалах асуудлыг олон нийтэд хүргэх хэрэгтэй юм.

Энэхүү номыг бичил бизнес эрхлэгчээс авахуулаад АНУ-ын ерөнхийлөгч Б.Обама хүртэл

олон сая хүний ширээний ном болж чадсан олон улсын бестселлер зохиол юм. Даяаршлийн үйл явцыг дэлхийн олон сая хүмүүс шинэлгээр ойлгуулж өгсөн бүтээл мөн. Уур амьсгалын өөрчлөлт, хүн амын түргэн өсөлт дэлхийг улам халуун, хавтгай, хавчигдмал болгож байна гэж хэлж болно. Ийм орчин нийгэмд өнөөг хүртэл амьдарч ирсэн хэвшмэл загварыг халж, Ногоон Кодыг зохиолч Фрийдман нэвтрүүлэхийг уриалж байна. Товчоор дүгнэхэд, Та болон бидний ирээдүй өнөөдрөөс эхэлнэ.




Л.Төр-Од

/Монголын эдийн засгийн чуулган ТББ-ын Захирал/

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс санаачлага гаргасан “Ногоон эдийн засаг руу тогтвортой хөгжил ба ядуурлыг бууруулах арга зам” нэртэй тайлан номыг уншиж байна. Энэхүү номыг тухайн салбарын нэр хүнд бүхий олон улсын шинжээч, эдийн засагч нар хамтран бичилцсэн бөгөөд аливаа улс орон “ногоон” буюу байгальд ээлтэй, халгүй байдалд шилжих нь эдийн засгийн өсөлтөнд дарамт, саад тогтоор

үзүүлэх бус, харин ч хөгжлийн онцгой шинэ хөдөлгүүр болоод зогсохгүй, ядуурлыг дорвитой бууруулж, байнгын ажлын байрыг цоо шинээр шууд бий болгодог болохыг тогтоожээ. Иймд, манай улсын бодлого боловсруулагчид, засаг төрийн албан тушаалтнууд “ногоон” эдийн засаг руу шилжихэд бүхий л хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэхэд энэхүү тайлан ширээний ном болохоор болжээ.



Б.Батболд /Байгаль Орчны “Эко Ази” Дээд сургуулийн багш, МБОИЗ-ийн УЗГ/:

Хүн бүр өөр өөрийн сонирхлын дагуу шүлэг, найраглал, өгүүллэг, үлгэр домог, адал явдал, аймшиг гэсэн чиглэлээр ном зохиол уншиж энэ бүхнээсээ амьдралын сайн сайхныг мэдэрч, цаашдын зорилгодоо хүрэх дөт замыг олж авдаг билээ. Бид бүхний эргэн тойронд янз бүрийн асуудал дүүрэн байдаг бөгөөд энэ бүхний дундаас байгаль орчны асуудал хамгаас чухал гэдгийг энэ цаг мөчид ухаарч байгаа нь харамсалтай. Саяхан “Орчны эрүүл мэндийн тухай” орчуулгын номыг уншлаа.

Энэхүү номонд орчны эрүүл мэндийн тухай ойлголт энэ талаар тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд олон нийтийн /эмэгтэйчүүд, хүүхэд, залуучууд, ахмадууд/ оролцоо ямар чухал болох мөн тэд нар хэрхэн, яаж, ямар түвшинд, үүрэг рольтой оролцож болохыг улс орнуудын туршлагаар харуулж өгсөн байна. Орчны эрүүл мэндийн тухай ярихын тулд орчин буюу хүрээлэн буй орчин нь хамгийн эх үндсийн

үндэс гэдгийг бид ухаарах хэрэгтэй. Уг бүтээлд ч энэ талыг түлхүү гаргаж өгсөн байгаа нь олон нийтийн экологийн боловсролд чухал үүргийг гүйцэтгэх болно.

Байгаль орчноо хамгаална гэдэг нь хүн төрөлхтөний нийгэм /боловсрол, эрүүл мэнд, амьжиргаа/, эдийн засгийг хамгаалж байгаагийн тод илрэл юм. Оюуны энэ бүтээлийг уншиж суухад байгаль орчны асуудлуудыг объект бүрээр авч үзэн яаж хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, тэнцвэрт байдлыг хангах арга замыг тодорхойлсон нь бидний амьдралд чухал хэрэгтэй бүтээл болсон нь харагдаж байна. Манай улсын хувьд ч энэ талруу хурдацтай хөгжиж байгаа билээ. Тогтвортой хөгжилд бид бүхний оролцоо маш их байгааг ухаарах цаг нэгэнт болжээ. Иймдээ ч энэхүү ном нь миний ажил, амьдралд олон өөрчлөлтийг авчирна гэдэгт би эргэлзэхгүй байна. Та унш, ойлго, оролдоод үз. Бүх зүйл таны гарт байна. ■



ТОД
ТАМГА
БИШИРТҮГЭЙ! АЮУТУГАЙ!



ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ ХҮРТ!

Утас: 91919499, 323454 www.todtamga.mn

Хаяг: ЧД, Татварын Ерөнхий газрын ард

“ТОД ТАУЭР” оффис, 101 тоот

Утас: 98907234

САЛБАНУУД:

Баруун 4 зам

Зуун айл

Түгээмэл

Утас: 98626587 todtamga2@yahoo.com

Ута: 98907912 todtamga1@yahoo.com

Утас: 98630499 todtamga3@yahoo.com

